



Долоо хоног тутмын хэвлэл  
2016 оны 03 дугаар сарын 04  
№ 09 /918/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

717

Монгол Улсын  
хууль

796

Монгол Улсын  
хууль

856

Монгол Улсын  
хууль

888

**Захиргааны хэрэг шүүхэд  
хянан шийдвэрлэх тухай  
/Шинэчилсэн найруулга/**

**Ард нийтийн санал  
асуулгын тухай  
/Шинэчилсэн найруулга/**

**Хүүхэд хамгааллын тухай**

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний  
эрхийн тухай**

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

350.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/	717
351.	Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	783
352.	Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	783
353.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	783
354.	Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	784
355.	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	784
356.	Шүүхийн шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	785
357.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	785
358.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	785
359.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	786
360.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	789
361.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	790
362.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	790
363.	Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	791
364.	Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай	791
365.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	791
366.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	792
367.	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	793



368.	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	793
369.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	794
370.	Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	795
371.	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	796
372.	Ард нийтийн санал асуулгын тухай /Шинэчилсэн найруулга/	796
373.	Ард нийтийн санал асуулгын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	807
374.	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	807
375.	Барилгын тухай /Шинэчилсэн найруулга/	808
376.	Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	854
377.	Барилгын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	854
378.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай	855
379.	Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай	855
380.	Хүүхэд хамгааллын тухай	856
381.	Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	871
382.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	872
383.	Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	872
384.	Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	873
385.	Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	873
386.	Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	874
387.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	874
388.	Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт оруулах тухай	875

389.	Хүүхдийн эрхийн тухай /Шинэчилсэн найруулга/	875
390.	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	888
391.	Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай	888
392.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай	888
393.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	918
394.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	919
395.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	919
396.	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай	920
397.	Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай	920
398.	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	921
399.	Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	921
400.	Ирээдүйн өв сангийн тухай	922
401.	Хүний хөгжил сангийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	951
402.	Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай	951
403.	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	952
404.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	952
405.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	953
406.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай	953
407.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	954
408.	Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль	954
409.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	955



410.	Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		956
411.	Авлигын эсрэг хуульд нэмэлт оруулах тухай		956
412.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		956
413.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		957
414.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай		961
415.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай		962
416.	Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай		962
417.	Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгох төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай		962
418.	Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай		963
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
419.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг буцаах тухай	Дугаар 15	963
420.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 16	964
421.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 20	964
422.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 21	965
423.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 28	965
424.	“Нийгмийн халамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 30	966
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
425.	Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай	Дугаар 484	966

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

426. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 03 971

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ**  
/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх  
тухай хууль тогтоомж**

2.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Захиргааны ерөнхий хууль<sup>2</sup>, Монгол Улсын шүүхийн тухай хууль<sup>3</sup>, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль<sup>4</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Монгол Улсын шүүхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 11 дугаарт нийтлэгдсэн.



### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“захиргааны байгууллага” гэж Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллагыг;

3.1.2.“захиргааны үйл ажиллагаа” гэж Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг;

3.1.3.“нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг;

3.1.4.“анхан шатны шүүхийн шийдвэр” гэж захиргааны хэргийн анхан шатны шүүхээс захиргааны хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шийдвэрийг;

3.1.5.“шүүхийн тогтоол” гэж захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх бүрэлдэхүүнээс гаргасан болон хяналтын шатны шүүхээс захиргааны хэргийг хянан хэлэлцэж гаргасан шийдвэрийг;

3.1.6.“магадлал” гэж захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс захиргааны хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шийдвэрийг;

3.1.7.“шүүгчийн захирамж” гэж захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс дангаараа гаргасан шийдвэрийг;

3.1.8.“шийтгэвэр” гэж захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчил гаргасан этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага оногдуулсан шийдвэрийг;

3.1.9.“захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг;

3.1.10.“хүн” гэж Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг.

### **4 дүгээр зүйл.Шүүхийн өмнө эрх тэгш байх**

4.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэж/ нь хүнийг үндэс, угсаа,



хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана.

#### **5 дугаар зүйл.Шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлэх, шүүгч хараат бус байх**

5.1.Шүүх эрх мэдлийг хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ.

5.2.Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах бөгөөд шүүгч хараат бус байх баталгааг хуулиар тогтооно.

#### **6 дугаар зүйл.Мэтгэлцэх зарчим**

6.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр хэрэгжүүлнэ.

6.2.Мэтгэлцэх зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжинэ.

6.3.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн буруутай үйл ажиллагаа, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний талаар нотлох болон үгүйсгэх байдлаар мэтгэлцэнэ.

6.4.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүх хуралдаанд биеэр оролцож үг хэлэх, бичгээр тайлбар өгөх, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэн судлахад тэгш эрхтэй оролцоно.

#### **7 дугаар зүйл.Шүүх нотлох зарчим**

7.1.Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна.

7.2.Шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлэх нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт гаргаж өгөх, энэ талаар хүсэлт гаргах эрхийг хязгаарлахгүй.

#### **8 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл, бичиг**

8.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан ёсны хэл, бичгээр хөтөлж, баримтжуулна.





8.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд монгол хэл мэдэхгүй бол өөрийн эх хэл болон мэддэг хэл, бичгээр, хэрэв хөгжлийн бэрхшээлтэйн улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан шүүхэд тайлбар, мэдүүлэг өгөх, нотлох баримт гаргах эрхтэй.

8.3.Шүүх энэ хуулийн 8.2-т заасан этгээдээс гаргасан тайлбар, мэдүүлэг, нотлох баримт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг хэргийн оролцогчид орчуулагч, хэлмэрчээр дамжуулан танилцуулах үүрэгтэй.

8.4.Гадаад хэлээр бичигдсэн нотлох баримт нь монгол хэлээр албан ёсоор орчуулагдсан байна.

### **9 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах**

9.1.Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

9.2.Хэргийн нотлох баримт, үйл явдал төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.

9.3.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдийг шүүх хуралдааны танхимд байлгаж болохгүй.

9.4.Шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр сургалтын зорилгоор багш, сурган хүмүүжүүлэгчийн удирдлагын доор шүүх хуралдаантай танилцаж байгаа 18 насанд хүрээгүй этгээдэд энэ хуулийн 9.3 дахь хэсэг хамаарахгүй.

### **10 дугаар зүйл.Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах**

10.1.Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

10.2.Шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргийг хянан шийдвэрлэж дуусах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй.

### **11 дүгээр зүйл.Хууль хэрэглэх**

11.1.Шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжийг хэрэглэнэ.

11.2.Хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй байна гэж шүүгч,



шүүх бүрэлдэхүүн үзвэл тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар саналаа гаргана.

11.3.Улсын дээд шүүх энэ хуулийн 11.2-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана. Харин үндэслэлгүй гэж үзвэл ердийн журмаар хянан шийдвэрлүүлэхээр санал гаргасан шүүхэд буцаана.

11.4.Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан тухайлсан хууль байхгүй бол ерөнхийлөн зохицуулсан хуулийг хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол шүүх Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн шийдвэрлэнэ.

11.5.Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн харилцааг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ.

11.6.Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй, эсхүл байгаа нь тодорхой бус гэсэн үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзах эрхгүй.

11.7.Шүүх хууль хоорондоо зөрчилтэй болон хууль шударга бус, эсхүл нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш гэсэн үндэслэлээр хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс татгалзах эрхгүй.

## **12 дугаар зүйл.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх**

12.1.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр дараахь хэлбэртэй байна:

- 12.1.1.анхан шатны шүүхийн шийдвэр;
- 12.1.2.магадлал;
- 12.1.3.тогтоол;
- 12.1.4.шүүгчийн захирамж;
- 12.1.5.шийтгэвэр.

12.2.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох захиргааны байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, хүн заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.

## **13 дугаар зүйл.Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан**

13.1.Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ.



13.2.Захиргааны ерөнхий хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа нь захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ**

### **14 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах хугацаа**

14.1.Хуульд өөрөөр заагаагүй, захиргааны үйл ажиллагаанд гомдол гаргах ажиллагаа Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу явагдсан бол дараахь тохиолдолд шийдвэрийг мэдэгдсэнээс хойш захиргааны хэргийн шүүхэд 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргана:

14.1.1.дээд шатны захиргааны байгууллага, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн бол;

14.1.2.холбогдох захиргааны байгууллага нь дээд шатны захиргааны байгууллага, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй бол.

14.2.Дээд шатны захиргааны байгууллага, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргасан гомдлыг Захиргааны ерөнхий хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй бол хугацаа өнгөрснөөс хойш 30 хоногийн дотор шүүхэд нэхэмжлэл гаргана.

14.3.Шүүхэд шууд хандахаар хуульд заасан бол тухайн хуульд заасан хугацаанд, хэрэв хугацаа заагаагүй бол шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд нэхэмжлэл гаргана.

14.4.Дээд шатны захиргааны байгууллага, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага байхгүй бол шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэлийг шууд шүүхэд гаргана.

14.5.Захиргааны байгууллагын гаргасан захиргааны акт, байгуулсан захиргааны гэрээ илт хууль бус болох, эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох болон захиргааны хэм хэмжээний акттай холбоотой нэхэмжлэлд энэ хуулийн 14.1-14.4-т заасан хугацаа үл хамаарна.

14.6.Энэ хуулийн 14.1-14.4-т заасан хугацаа зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтэрсэн бол хүн, хуулийн этгээд, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт тухайн захиргааны хэргийн шүүхэд гаргаж болох бөгөөд шүүгч уг хугацааг хэтэрснээс хойш гурван жилийн дотор нөхөн сэргээж болно.



14.7.Захиргааны байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас энэ хуулийн 14.1-14.4-т заасан хугацаа хэтэрсэн бол энэ хуулийн 14.6 дахь хэсэг хамаарахгүй.

### **15 дугаар зүйл.Захиргааны хэргийн нутаг дэвсгэрийн харьяалал**

15.1.Нэхэмжлэлийг тухайн шийдвэр гаргасан захиргааны байгууллагын оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд гаргана.

### **16 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал**

16.1.Захиргааны хэргийн анхан шатны шүүх энэ хуульд заасны дагуу захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

16.2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуулиар харьяалуулсан захиргааны хэргийг анхан шатны журмаар, анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

16.3.Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ.

16.4.Улсын дээд шүүх захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

16.5.Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын талаар анхан шатны шүүхийн хооронд гарсан маргааныг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч хянан шийдвэрлэнэ.

16.6.Хуульд заасан тохиолдолд захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Улсын дээд шүүх хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны болон давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

### **17 дугаар зүйл.Хэргийн оролцогч**

17.1.Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг хэргийн оролцогч гэнэ.

17.2.Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч, өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн



төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж байгаа этгээд мөн.

17.3.Энэ хуулийн 3.1.3-т заасан нэхэмжлэлийг гаргасан этгээдийг нэхэмжлэгч гэнэ.

17.4.Нэхэмжлэлийн шаардлагаар тодорхойлогдох захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлсэн захиргааны байгууллага, албан тушаалтныг хариуцагч гэнэ.

17.5.Нэхэмжлэлийн шаардлагад тодорхойлсон захиргааны акт, захиргааны гэрээний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг гуравдагч этгээд гэнэ.

### **18 дугаар зүйл.Хэргийн оролцогчийн эрх зүйн чадвар**

18.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүн, хуулийн этгээд, захиргааны байгууллага оролцох эрхтэй.

18.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг шүүгч захирамж гарган оролцуулж болно.

18.3.Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараахь шаардлагыг хангасан байна:

18.3.1.нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх;

18.3.2.дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх.

### **19 дүгээр зүйл.Хэргийн оролцогчийн эрх зүйн чадамж**

19.1.Шүүхэд захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр заагдсан эрхээ өөрөө хэрэгжүүлж, үүргээ биелүүлэх, хариуцлага хүлээх болон төлөөлөгчөөрөө гүйцэтгүүлэх чадварыг эрх зүйн бүрэн чадамжтай этгээд эдэлнэ.

19.2.Эрх зүйн зарим болон бүрэн бус чадамжтай, эсхүл сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч төлөөлөн хамгаална.



19.3.16-18 хүртэлх насны хүн өөрөө хүсвэл түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох эрхтэй.

## **20 дугаар зүйл.Нэхэмжлэгчийн эрх, үүрэг**

20.1.Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь эрх эдэлнэ:

20.1.1.нэхэмжлэлээ өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх, эсхүл багасгах, нэхэмжлэлээсээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзах, хариуцагчтай эвлэрэх;

20.1.2.хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, тэмдэглэл, хуулбар хийх, тэдгээрт тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцох;

20.1.3.нотлох баримт гаргаж өгөх, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, бусад нотлох баримт цуглуулах, нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;

20.1.4.шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлт гаргах;

20.1.5.шүүх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих;

20.1.6.шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах;

20.1.7.хуульд заасан бусад эрх.

20.2.Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь үүрэг хүлээнэ:

20.2.1.шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;

20.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;

20.2.3.шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

20.2.4.шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах;

20.2.5.шүүхийн шийдвэрийг хуульд заасан хугацаанд гардан авах;

20.2.6.хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг биелүүлэх.



20.3.Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно.

### **21 дүгээр зүйл.Хариуцагчийн эрх, үүрэг**

21.1.Хариуцагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь эрх эдэлнэ:

21.1.1.нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, нэхэмжлэгчтэй эвлэрэх, эсхүл татгалзах;

21.1.2.энэ хуулийн 20.1.2-20.1.7-д заасан эрх.

21.2.Хариуцагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь үүрэг хүлээнэ:

21.2.1.шүүхээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн талаар бичгээр тайлбар гаргах, шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх;

21.2.2.хариуцагч өөрөө, эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

21.2.3.энэ хуулийн 20.2-т заасан үүрэг.

### **22 дугаар зүйл.Гуравдагч этгээдийн эрх, үүрэг**

22.1.Үндсэн нэхэмжлэлийн шаардлагаар үүссэн маргааны үйл баримтын талаар бие даасан шаардлага гаргасан, эсхүл эдгээрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа гэж үзсэн гуравдагч этгээдийг тухайн этгээдийн хүсэлтээр, эсхүл шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасан гуравдагч этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй бол энэ талаар хүсэлтийг бичгээр гаргана.

22.3.Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд хэргийн оролцогчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

22.4.Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, ихэсгэх, багасгах, хүлээн зөвшөөрөх, эвлэрэх болон нэхэмжлэлээс татгалзахаас бусад хэргийн оролцогчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.



### **23 дугаар зүйл.Нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргах**

23.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил шаардлага бүхий нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч хамтран гаргаж болно.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан тохиолдолд нэхэмжлэгчид дундаасаа төлөөлөгч томилон түүнд олгосон итгэмжлэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрсдийгөө төлөөлүүлэн оролцуулах эрхтэй.

23.3.Нэхэмжлэлийг 10, түүнээс дээш этгээд хамтран гаргасан тохиолдолд шүүгч хэрэг үүсгэснээс хойш 14 хоногийн дотор тэдэнд төлөөлөгчөө томилохыг санал болгоно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан хугацаанд нэхэмжлэгчид төлөөлөгчөө томилоогүй бол шүүгч тэдгээрийн дундаас төлөөлөгч томилно.

23.5.Төлөөлөгчийн тоо тав хүртэл байна. 50-иас дээш нэхэмжлэгчтэй хэрэгт шүүгч төлөөлөгчийн тоог нэмж тогтоож болно.

### **24 дүгээр зүйл.Хамтран хариуцагч**

24.1.Нэг нэхэмжлэлд хэд хэдэн хариуцагч байж болох ба тэдгээр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцох эрхтэй.

24.2.Хамтран хариуцагчид нь ашиг сонирхлын зөрчилгүй, хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд бүгд оролцох шаардлагагүй, түүнчлэн шүүхийн шийдвэрт сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл хэн нэгийгээ томилон өөрсдийгөө төлөөлүүлэн оролцуулж болно.

### **25 дугаар зүйл.Хариуцагчийг солих**

25.1.Хариуцагчаар татагдсан этгээд нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь тогтоогдвол түүнийг шүүгч нэхэмжлэгчийн зөвшөөрснөөр жинхэнэ хариуцагчаар солино.

25.2.Нэхэмжлэгч хариуцагчийг солихыг зөвшөөрөөгүй бол шүүгч тухайн этгээдийг хамтран хариуцагчаар татан оролцуулна.

25.3.Хариуцагчийг нотлох баримт цуглуулахаас өмнө солих бөгөөд хэрэв цуглуулсны дараа солиход хүрвэл шинээр тогтоогдсон хариуцагч болон хамтран хариуцагч нь нотлох баримтыг шинээр цуглуулж, үнэлүүлэхийг шаардах эрхтэй.

### **26 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах**

26.1.Маргаантай эрх зүйн харилцааны хэргийн оролцогчийн аль нэг нь уг маргаанаас гарсан /хүн нас барсан, сураггүй алга болсонд





тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн, захиргааны байгууллага өөрчлөн байгуулагдсан/ бол шүүх тэрхүү хэргийн оролцогчийг сонирхогч этгээд болон эрх залгамжлагчийн гаргасан хүсэлтээр эрх залгамжлан авбал зохих этгээдээр сольж болно. Эрх залгамжлан авах ажиллагаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гүйцэтгэгдэж болно.

26.2.Захиргааны байгууллагын эрх залгамжлах үйл ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн 5.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

26.3.Эрх залгамжлагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарсан хэргийн оролцогчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

### **27 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүн, хуулийн этгээд, захиргааны байгууллагыг төлөөлөх**

27.1.Эрх зүйн чадамж бүхий хүн шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөө оролцуулна.

27.2.Хууль, эрх зүйн бусад акт болон үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлнө.

27.3.Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд нь өөрийн албан тушаал, эрх хэмжээгээ нотлох баримт бичиг, бусад этгээд олгосон итгэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргаж өгнө.

27.4.Итгэмжлэл нь дараахь шаардлагыг хангасан байна:

27.4.1.итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх;

27.4.2.олгосон он, сар, өдрийг заах;

27.4.3.хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх;

27.4.4.захиргааны ямар маргаанд оролцохыг тодорхой заах;

27.4.5.итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах.

27.5.Энэ хуулийн 27.4-т заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна.

27.6.Тодорхой хугацаагаар олгосон итгэмжлэл гурван жилээс илүүгүй хугацаагаар, хугацаа заагаагүй итгэмжлэл олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.



27.7.Итгэмжлэлээр төлөөлүүлж байгаа хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохгүй байж болно.

27.8.Захиргааны байгууллагыг Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөх бөгөөд энэ хуулийн 27.7 дахь хэсэг хамаарахгүй.

### **28 дугаар зүйл.Төлөөлөгчийн бүрэн эрх**

28.1.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулна.

28.2.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлд тусгайлан заасан тохиолдолд дараахь эрх эдэлнэ:

28.2.1.нэхэмжлэлд гарын үсэг зурах, хариу тайлбар гаргах;

28.2.2.нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх;

28.2.3.нэхэмжлэлийн шаардлагаас бүрэн, эсхүл хэсэгчлэн татгалзах;

28.2.4.нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, ихэсгэх, эсхүл багасгах;

28.2.5.эвлэрэх;

28.2.6.шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах;

28.2.7.төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийг бусдад шилжүүлэх;

28.2.8.захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах.

### **29 дүгээр зүйл.Төлөөлөн оролцож болохгүй байдал, төлөөлөл дуусгавар болох үндэслэл**

29.1.Дараахь этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцохыг хориглоно:

29.1.1.насанд хүрээгүй, эрх зүйн зарим болон бүрэн бус чадамжтай, чадамжгүй хүн;

29.1.2.гуравдагч этгээд, гэрчээр оролцсон этгээд;

29.1.3.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар, эсхүл ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч.

29.2.Төлөөлөл дараахь үндэслэлээр дуусгавар болно:



29.2.1.төлөөлөгч бүрэн эрхээсээ татгалзсан;  
29.2.2.төлөөлүүлэгч өөрийн олгосон итгэмжлэлийг хүчингүй болгосон;

29.2.3.хууль, эсхүл гэрээнд өөрөөр заагаагүй бол төлөөлүүлэгч нас барсан, эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон;

29.2.4.хуулийн этгээд татан буугдсан;

29.2.5.итгэмжлэлийн хугацаа дууссан.

29.3.Төлөөлүүлэгч итгэмжлэлээ хүчингүй болгох, төлөөлөгч итгэмжлэлээс татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд шүүхэд даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдэгдээгүйгээс гарах үр дагаврыг төлөөлүүлэгч хариуцна.

### **30 дугаар зүйл.Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох**

30.1.Хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авч болно.

30.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх нь хууль зүйн туслалцаа авч байгаа талын бичгээр гаргасан хүсэлт, эсхүл тэдний хооронд байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно.

30.3.Өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо дараахь эрх эдэлнэ:

30.3.1.захиргааны хэргийн нотлох баримт, хэргийн материалтай танилцах, танилцах боломжит хугацаагаар хангуулах, тэмдэглэл хийх, шаардлагатай материалыг өөрийн зардлаар хувилж, хуулбарлан авах;

30.3.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт гаргаж өгөх, хасуулах, шинэ нотлох баримт шаардах болон хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, шинжээч томилуулах санал, хүсэлт гаргах;

30.3.3.шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, орчуулагч, хэлмэрч, шинжээчийг хуульд заасан үндэслэл байвал татгалзан гаргах хүсэлт гаргах;

30.3.4.шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах;

30.3.5.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож хэргийн оролцогч, бусад оролцогчид асуулт тавих, үйлчлүүлэгчийнхээ гаргаж байгаа мэдүүлэг, тодорхойлолтод тайлбар хийх;

30.3.6.шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, холбогдох санал, хүсэлтээ бичгээр гаргах;

30.3.7.хуульд заасан бусад эрх.

30.4.Өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь үүрэг хүлээнэ:

30.4.1.хууль зүйн туслалцаа авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцох;

30.4.2.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон өмгөөлөгч, хуульчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

30.4.3.үйлчлүүлж байгаа этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах бүх арга хэрэгслийг ашиглан бүрэн, тууштай хамгаалах;

30.4.4.өмгөөллийн үйл ажиллагааны явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүн болон үйлчлүүлэгчийн нууцыг задруулахгүй байх;

30.4.5.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх;

30.4.6.үйлчлүүлэгчийн хууль бус шаардлагаас татгалзах;

30.4.7.хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүхээс товлосон хугацаанд шүүх хуралдаанд хүрэлцэн ирэх.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НОТЛОХ БАРИМТ**

### **31 дүгээр зүйл.Нотлох баримт**

31.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.

31.2.Нотлох баримт нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл, цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.



31.3.Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон, түүнчлэн албан үүрэгтэй нь холбогдуулж шүүгчид итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулахыг хориглоно.

### **32 дугаар зүйл.Нотлох баримт гаргах, цуглуулах**

32.1.Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ.

32.2.Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох этгээд шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

32.3.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүхэд гаргасан нэхэмжлэл, хариу тайлбарын үндэслэлийн талаар нотлох баримтаа шүүхэд гаргаж өгөх ба гаргаж өгөх боломжгүй, түүнчлэн шүүхэд мэдэгдээгүй нотлох баримтын эх сурвалжийг заах үүрэгтэй.

32.4.Шүүх хуралдаан товлохоос өмнө хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нотлох баримт гаргаж өгөх үүрэгтэй, түүнчлэн нотлох баримт цуглуулахыг захиргааны хэргийн шүүхээс шаардах эрхтэй.

32.5.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүхэд хуурамч, хуульд заасан арга хэрэгслээр олж аваагүй нотлох баримт гаргахыг хориглоно.

32.6.Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.

32.7.Энэ хуулийн 32.5-д заасныг зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

32.8.Хэргийн оролцогч өөрт байгаа нотлох баримтаа шүүхэд гаргаж өгөөгүй нь шүүхийг буруутгах үндэслэл болохгүй.

### **33 дугаар зүйл.Нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх**

33.1.Хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай бол хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр, шүүхийн санаачилгаар эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж болно.

33.2.Шүүхийн хүсэлтийг биелүүлэх журмыг тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр, гэрээ байхгүй тохиолдолд дипломат шугамаар тохиролцоно.



#### **34 дүгээр зүйл.Нотлох баримтыг үнэлэх**

34.1.Шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.

34.2.Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ.

34.3.Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.

34.4.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон болон нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.

34.5.Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчиж олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

34.6.Анхан шатны шүүхэд гаргаагүй нотлох баримтыг давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гаргахгүй.

#### **35 дугаар зүйл.Шүүхийн даалгавар, түүнийг биелүүлэх**

35.1.Шийдвэрлэж байгаа хэргийн талаар өөр орон нутгаас нотлох баримт бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байвал хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар тодорхой ажиллагаа гүйцэтгэхийг зохих шүүхэд даалгана.

35.2.Энэ хуулийн 35.1-д заасан шүүхийн даалгаварт хэргийн товч агуулга, бүрдүүлбэл зохих нотлох баримтыг зааж, даалгавар биелүүлэх хугацааг тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

35.3.Шүүхийн даалгавар хүлээн авсан шүүх түүнийг тогтоосон хугацаанд биелүүлнэ.

35.4.Шүүхийн даалгавар биелүүлэхэд хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн бүх материалыг хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

#### **36 дугаар зүйл.Хэргийн оролцогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар**

36.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн шүүхэд гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн, хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэгдсэн байна.



36.2.Энэ хуулийн 36.1-д заасан этгээд өөрийн, эсрэг талын гаргасан тайлбарт холбогдох өөрт байгаа болон гаргах боломжтой нотлох баримтыг шүүхэд өгнө.

### **37 дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг**

37.1.Хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.

37.2.Гэрчээр дуудагдсан этгээд шүүхэд заавал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй.

37.3.Мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх, эсхүл зориуд худал мэдүүлэг өгсөн бол хуульд заасан хариуцлага оногдуулна.

37.4.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн дуудсанаар ирж чадахгүй гэрчээс байгаа газарт нь очиж мэдүүлэг авч болно.

37.5.Гэрч шүүхийн дуудсанаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан ирүүлэхийг шүүхээс эрх бүхий байгууллагад даалгаж, холбогдох зардлыг гэрчээр гаргуулахаар тогтоож болно.

37.6.Гэрчүүдийн мэдүүлэгт ноцтой зөрүү байвал тэдгээрийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авч болно.

37.7.Шүүгч нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа гэрчүүдээс бие биеэ таних эсэх, хоорондоо ямар харилцаатай болохыг асуух бөгөөд тодруулах гэж байгаа зүйлийн талаар гэрчүүдээс ээлжлэн мэдүүлэг авна.

37.8.Мэдүүлэг өгсний дараа шүүгч гэрчүүдээс асуулт асууж болох бөгөөд харилцан нүүрэлдэж байгаа гэрчүүд бие биенээсээ асуулт асууж болохгүй.

37.9.Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

37.10.Дараахь хүнийг гэрчээр дуудах болон мэдүүлэг авч болохгүй:

37.10.1.үүргээ гүйцэтгэх замаар хэргийн нөхцөл байдлыг мэдэх болсон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч;

37.10.2.иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.

### **38 дугаар зүйл.Бичмэл нотлох баримт**

38.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ.



38.2.Бичмэл нотлох баримтыг шүүхэд эх хувиар нь, хэрэв тухайн баримтын эх хувийг өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Шүүх шаардлагатай гэж үзвэл тухайн баримтын эх хувийг шаардан авах эрхтэй.

38.3.Бичмэл нотлох баримтыг шаардан авахад бэрхшээлтэй байвал хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар түүний хадгалагдаж байгаа газарт нь шүүх үзлэг явуулна.

38.4.Төрийн байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг өөрийн байгууллагын архивын “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарж баталгаажуулна.

38.5.Шүүхээс өмнө нь шийдвэрлэсэн, эсхүл шийдвэрлэж байгаа хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад цугларсан нотлох баримтын шаардлага хангасан материалыг хэргээс хуулбарласан тохиолдолд бичмэл нотлох баримтыг нотлох баримтын шаардлага хангасан гэж үзнэ.

38.6.Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа бичмэл баримтын эх хувийг түүнийг гаргаж өгсөн этгээд хүсвэл буцаан өгч болно. Харин уг баримтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хэргийн материалд үлдээнэ.

### **39 дүгээр зүйл. Эд мөрийн баримт**

39.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоож чадах биет зүйлийг эд мөрийн баримт гэнэ.

39.2.Эд мөрийн баримтыг хэрэгт, эсхүл тусгай байр, саванд тодорхой бүртгэлтэйгээр хадгална.

39.3.Шүүхэд авчирч хадгалах боломжгүй эд мөрийн баримтыг түүний байгаа газарт нь үзлэг хийж, энэ тухай тэмдэглэл хөтөлнө.

39.4.Шаардлагатай бол уг эд мөрийн баримтын талаар гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж бэхжүүлэн хэрэгт хавсаргах, эсхүл түүнийг битүүмжилж болно.

39.5.Хүнсний болон түргэн муудаж, гэмтэх бусад эд зүйлд үзлэгийг шүүхээс хэргийн оролцогчдод мэдэгдэж даруй хийнэ. Хуульд өөрөөр заагаагүй бол үзлэг хийж дууссаны дараа эд зүйлийг эзэмшигчид буцаан олгоно.

39.6.Шаардлагатай бол эд мөрийн баримтыг эзэмшигч, эсхүл эд мөрийн баримт байгаа газрын баг, хорооны Засаг дарга, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хадгалуулж болно. Хадгалахаар авсан этгээд эд мөрийн баримтыг хэвийн байдлаар хадгалах үүрэгтэй.





39.7.Хуульд өөрөөр заагаагүй бол шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол эд мөрийн баримтыг эзэмшигчид буцаан олгох бөгөөд гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг хэрэгт үлдээнэ.

#### **40 дүгээр зүйл.Шинжээчийн дүгнэлт**

40.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар шинжээчийг томилж болно.

40.2.Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд<sup>5</sup> заасан журмыг баримтална.

#### **41 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагаа**

41.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулахын тулд шүүх үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулан хийх бөгөөд энэ тухай тэмдэглэл үйлдэж, уг ажиллагаанд оролцогчдоор гарын үсэг зуруулна.

41.2.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь энэ хуулийн 41.1-д заасан ажиллагааг явуулахад саад болохгүй.

41.3.Хөндлөнгийн гэрчээр хэрэгт хувийн болон албаны сонирхолгүй, эрх зүйн бүрэн чадамжтай хүнийг оролцуулна.

41.4.Хөндлөнгийн гэрч түүнийг байлцуулан хийсэн ажиллагааны явц, агуулга, дүнг баталж өгөх үүрэгтэй.

41.5.Хөндлөнгийн гэрч тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэй.

41.6.Энэ хуулийн 41.4-т заасан үүргээ биелүүлээгүй бол хөндлөнгийн гэрчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **42 дугаар зүйл.Тэмдэглэл**

42.1.Дараахь тохиолдолд шүүх хуралдааны тэмдэглэл үйлдэнэ:

42.1.1.анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд;

<sup>5</sup> Шүүхийн шинжилгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2010 оны 02 дугаарт нийтлэгдсэн.



42.1.2.давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцож байгаа бол.

42.2.Үзлэг, туршилт хийх, таньж олуулах, нүүрэлдүүлэн мэдүүлэг авах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааны үед тэмдэглэл үйлдэнэ.

42.3.Тэмдэглэлийг энэ хуулийн 8.1-д заасан шаардлагад нийцүүлэн үйлдэнэ.

42.4.Тэмдэглэлийг шүүх хуралдааны үед шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааны үед шүүгчийн даалгаснаар шүүгчийн туслах үйлдэнэ.

42.5.Тэмдэглэлд ямар ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, түүний эхэлсэн ба дууссан цаг, ажиллагаанд оролцсон болон байлцсан хүн нэг бүрийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, түүнчлэн ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ.

42.6.Тэмдэглэлийг уг ажиллагаа явуулахад оролцсон болон байлцсан бүх хүн уншиж танилцах бөгөөд тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг тэдэнд тайлбарлаж өгнө.

42.7.Энэ хуулийн 42.2-т заасан тэмдэглэлд уг ажиллагааг явуулсан этгээд, оролцсон болон байлцсан бүх хүн гарын үсэг зурна. Тэдгээр нь гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

42.8.Тэмдэглэлд гэрэл зураг, зураглал, ул мөрнөөс буулгаж авсан хэв болон хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой бусад зүйлийг хавсаргаж болох бөгөөд тэмдэглэлд энэ тухай заана.

### **43 дугаар зүйл.Нотлох баримтыг хамгаалах**

43.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг өөрчлөх, устгах, бусдад шилжүүлэх, нуун дарагдуулах зэргээр хэргийг хянан шийдвэрлэхэд саад учруулж болох үндэслэлтэй гэж үзвэл хэргийн оролцогч нотлох баримтыг хамгаалуулахаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд хүсэлт гаргаж болно.

43.2.Хүсэлтэд ямар нотлох баримтыг хамгаалах, хэргийн ямар нөхцөл байдлыг нотлоход ач холбогдолтой болон хамгаалах болсон шалтгааныг заана.



43.3.Шүүгч хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримтыг хамгаалах тухай, хэрэв үндэслэлгүй гэж үзвэл татгалзах тухай захирамж гаргана.

43.4.Шүүгчийн захирамжид хаана, хэнд байгаа, ямар нотлох баримтыг хэрхэн хамгаалах талаар заана.

43.5.Энэ хуулийн 43.3-т заасан шүүгчийн захирамжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага даруй биелүүлнэ.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ЗАРДАЛ, УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ**

#### **44 дүгээр зүйл.Шүүхийн зардал**

44.1.Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ.

44.2.Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

44.3.Дараахь зардлыг хэргийн оролцогчоор нөхөн төлүүлнэ:

44.3.1.шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэсэн ажил үндсэн ажлын чиг үүрэгт хамаарахгүй бол ажлын хөлс;

44.3.2.гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;

44.3.3.үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал;

44.3.4.эд мөрийн баримт хадгалах зардал;

44.3.5.гэрчийн мэдүүлгийг очиж авсан зардал.

#### **45 дугаар зүйл.Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох**

45.1.Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг дараахь журмаар тодорхойлно:

45.1.1.шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж байгаа албан томилолтын зардлын хэмжээгээр;

45.1.2. шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг шүүхээс төлсөн хэмжээгээр;

45.1.3. мэдүүлэг өгөхөөр шүүхэд дуудагдсан хугацаанд гэрч цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар;

45.1.4. бусад зардлыг гүйцэтгэлийн баримтад заасан хэмжээгээр.

45.2. Шүүхийн зардлыг улсын төсөвт тушаана.

#### **46 дугаар зүйл. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлаас чөлөөлөх, хөнгөлөх**

46.1. Хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал тэдгээрийг нөхөн төлүүлэх шүүхийн зардлаас чөлөөлж болно.

46.2. Шүүх тухайн этгээдийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн зардлыг нөхөн төлөх хэмжээг багасгах, хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно.

46.3. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжилж байгаа этгээдийг шүүхийн зардлаас чөлөөлнө.

#### **47 дугаар зүйл. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилах**

47.1. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ.

47.2. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шүүхийн зардлыг тэр хэмжээгээр хариуцагч болон нэхэмжлэгчид хуваарилан нөхөн төлүүлнэ.

47.3. Хяналтын шатны болон давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилсөн бол шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.

47.4. Нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэхдээ шүүхийн зардлыг өөрөөр хуваарилахаар тохиролцоогүй бол шүүх энэ зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.



47.5.Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзвал шүүхийн зардлыг нөхөн төлнө.

47.6.Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан бол хариуцагчийн төлөх шүүхийн зардлыг тавин хувиар хөнгөлнө.

#### **48 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамж**

48.1.Улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэгч урьдчилан төлөх бөгөөд нэхэмжлэл бүрэн, эсхүл хэсэгчлэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар нөхөн төлүүлж нэхэмжлэгчид буцаан олгоно.

48.2.Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдуулж төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар<sup>6</sup> зохицуулна.

48.3.Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахад улсын тэмдэгтийн хураамж төлнө.

#### **49 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх**

49.1.Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар, бусад нотлох баримтаар тогтоогдсон болон хуульд заасан бусад үндэслэл байвал Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу шүүгч улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлж, захирамж гаргана.

#### **50 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох**

50.1.Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол улсын тэмдэгтийн хураамжийг шүүгчийн захирамжаар нэхэмжлэгчид буцаан олгоно.

50.2.Шүүх хуралдаанаас өмнө давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан этгээд уг гомдлоосоо татгалзвал тухайн шатны шүүгч гомдлыг гаргаагүйд тооцож, гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгоно.

50.3.Давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэж шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон, эсхүл өөрчилсөн тохиолдолд гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг тухайн шатны шүүгчийн захирамжаар буцаан олгоно.

<sup>6</sup> Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2011 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



50.4.Энэ хуулийн 47.6-д заасан шалтгаанаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан бол нэхэмжлэгчийн урьдчилан төлсөн улсын тэмдэгтийн хураамжийн тавин хувийг буцаан олгоно.

50.5.Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа багасгах, энэ хуулийн 50.4-т зааснаас бусад тохиолдолд нэхэмжлэлээсээ татгалзах, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

50.6.Энэ хуулийн 91.3-д заасны дагуу шүүх нэхэмжлэлийг буцаах тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

### **51 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилах**

51.1.Улсын тэмдэгтийн хураамжийг хэргийн оролцогчид хуваарилах асуудлыг энэ хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ**

### **52 дугаар зүйл.Нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн хэлбэр, бүрдүүлбэр**

52.1.Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах бөгөөд түүнд нэхэмжлэгч, эсхүл түүний төлөөлөгч гарын үсэг зурсан байна.

52.2.Нэхэмжлэлд дараахь зүйлийг тусгана:

52.2.1.нэхэмжлэлийг захиргааны хэргийн аль шүүхэд гаргаж байгаа;

52.2.2.нэхэмжлэгчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаяг;

52.2.3.хариуцагчийн нэр, оршин байгаа газрын хаяг;

52.2.4.нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл;

52.2.5.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл чөлөөлөгдөх хүсэлт, түүнийг нотлох баримт;

52.2.6.хавсаргасан баримт бичгийн жагсаалт;

52.2.7.холбоо барих утас, факс, цахим хаяг.

52.3.Нэхэмжлэлийг итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргасан бол төлөөлөх эрх олгосон баримт бичиг болон итгэмжлэлийг хавсаргана.



52.4.Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.

52.5.Энэ хуулийн 52.2.4-т заасан нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлд дараахь зүйл хамаарна:

52.5.1.захиргааны акт, захиргааны гэрээг хүчингүй болгуулах, илт хууль бус болохыг тогтоолгох, эсхүл эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, захиргааны акт гаргуулахыг даалгах нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсэн;

52.5.2.хохирол гаргуулах нэхэмжлэлийн хувьд захиргааны байгууллага ямар үүргээ биелүүлээгүйгээс, эсхүл захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх;

52.5.3.нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгосноор нэхэмжлэгчид ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол үүсэхийг;

52.5.4.захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэлийн хувьд ямар хууль зөрчигдсэн, эсхүл нийтийн эрх зүйн ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн;

52.5.5.нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсэн, эсхүл зөрчигдөж болзошгүй;

52.5.6.захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд хүн, хуулийн этгээдийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсэн, эсхүл зөрчигдөж болзошгүй болон ямар хуультай зөрчилдсэн.

52.6.Захиргааны байгууллагаас гаргах захиргааны хэм хэмжээний акттай холбогдох нэхэмжлэлийн хувьд энэ хуулийн 3.1.3-т заасан хуульд тусгайлан заасан байх нөхцөл хамаарахгүй.

### **53 дугаар зүйл.Нэхэмжлэл хүлээн авах, хуваарилах**

53.1.Нэхэмжлэлийг тухайн захиргааны хэргийн шүүх хүлээн авч, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минут, нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудасны тоог тэмдэглэн нэхэмжлэл бүртгэх дэвтэрт бүртгэж баримтжуулна.

53.2.Хэрэг, нэхэмжлэлийг шүүгчид хуваарилах журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс батална.



53.3.Нэхэмжлэл нь энэ хуулийн 52.2, 52.3, 52.5-д заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно.

53.4.Нэхэмжлэгч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол уг нэхэмжлэлийг шүүгч буцаана.

#### **54 дүгээр зүйл.Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах**

54.1.Шүүгч дараахь тохиолдолд нэхэмжлэл хүлээн авахаас татгалзана:

54.1.1.захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус;

54.1.2.тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус;

54.1.3.Захиргааны ерөнхий хуулийн 92-94 дүгээр зүйлд заасан гомдол гаргах журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүй ба энэ журмыг хэрэглэх боломжтой;

54.1.4.нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй бөгөөд түүнийг төлөөлсөн этгээд байхгүй;

54.1.5.нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй болон нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;

54.1.6.нэхэмжлэлд заасан үйл баримт, захиргааны үйл ажиллагааны талаар, эсхүл уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол байгаа;

54.1.7.нэхэмжлэгч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан боловч эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;

54.1.8.энэ хуулийн 14.1-14.4-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн.

54.2.Нэхэмжлэлийг энэ хуулийн 54.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг дахин гаргах, эсхүл хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж, нэхэмжлэлийг буцаана.

#### **55 дугаар зүйл.Захиргааны хэрэг үүсгэх**

55.1.Шүүгч энэ хуулийн 54.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан, эсхүл нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж





ирүүлсэн өдрөөс хойш долоо хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

### **56 дугаар зүйл.Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа**

56.1.Хэрэг үүсгэсэн шүүгч дараахь ажиллагаа явуулна:

56.1.1.хариуцагчийг дуудан ирүүлж, нэхэмжлэлийн хувийг гардуулж, энэ тухай баримтжуулах;

56.1.2.хэргийн оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухайгаа баримтжуулах;

56.1.3.хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, гэрчийг дуудаж мэдүүлэг авах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох болон шаардлагатай бусад ажиллагаа явуулах;

56.1.4.шаардлагатай бол холбогдох шүүхэд шүүхийн даалгавар явуулах;

56.1.5.эвлэрүүлэх арга хэмжээ авах;

56.1.6.шаардлагатай бол гуравдагч этгээдийг оролцуулах захирамж гаргах;

56.1.7.хуульд заасан бусад ажиллагаа.

### **57 дугаар зүйл.Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах**

57.1.Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш нийслэлд долоо, орон нутагт 14 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулна.

57.2.Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэх талаар бичгээр хариу тайлбар гаргах бөгөөд тайлбартаа үндэслэлийг зааж, нотлох баримтаа хамтад нь гаргаж ирүүлнэ.

### **58 дугаар зүйл.Сөрөг нэхэмжлэл**

58.1.Хариуцагч нь хэрэг хянан шийдвэрлэх явцад захиргааны гэрээтэй холбоотой үндсэн нэхэмжлэлтэй хамтатган хянан шийдвэрлүүлэхийн тулд шүүх хуралдаанаар хэлэлцэхийн өмнө сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй.

58.2.Сөрөг нэхэмжлэлд нэхэмжлэл гаргах нийтлэг журмыг баримтална.

58.3.Сөрөг нэхэмжлэл нь үндсэн нэхэмжлэлийн шаардлагад тооцогдох, хэргийн оролцогчдын хүрээнд шийдвэрлэгдэхээр байна.



## **59 дүгээр зүйл. Шүүхэд дуудан ирүүлэх**

59.1. Шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, орчуулагч, хэлмэрч, шинжээчийг шүүхийн мэдэгдэх хуудсаар шүүх болон шүүх хуралдаанд дуудан ирүүлнэ.

59.2. Шүүх хуралдаанд ирвэл зохих оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа газрын, эсхүл ажлын газрын хаягаар мэдэгдэнэ.

59.3. Шүүхийн мэдэгдэх хуудсыг ирвэл зохих оролцогчийн оршин суугаа болон ажлын газрын хаягийн дагуу шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд утас, факс, цахим шуудан, цахилгаан болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж болох бөгөөд мэдэгдсэнээ баримтжуулна.

59.4. Мэдэгдэх хуудсыг шуудангаар хүргэсэн бол шүүх хүлээн авагчийн нэр, хаяг, явуулж байгаа он, сар, өдрийг тэмдэглэж, шүүхийн болон шуудангийн ажилтны гарын үсгийг зуруулна.

59.5. Газар нутгийн онцлогоос шалтгаалан шүүх мэдэгдэх хуудсыг биечлэн хүргэхийг өөр этгээдэд даалгаж болно.

59.6. Мэдэгдэх хуудсыг түүнд заасан этгээдэд гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан он, сар, өдөр, цагийг тэмдэглэнэ. Хуулийн этгээдэд өгөх мэдэгдэх хуудсыг удирдах албан тушаалтан, холбогдох ажилтанд гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан он, сар, өдөр, цагийг тэмдэглэнэ.

59.7. Мэдэгдэх хуудсыг гардуулан өгвөл зохих хүн оршин суугаа газартаа болон ажлынхаа газарт байхгүй бол уг хуудсыг түүний хамт амьдардаг насанд хүрсэн хүн, эсхүл сум, баг, хорооны Засаг дарга, түүний ажлын албанд, эсхүл ажлын газрынх нь захиргаанд хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.

59.8. Тухайн этгээд мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзвал энэ талаар мэдэгдэх хуудсанд тэмдэглэж шүүхэд буцаана. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

59.9. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оршин суугаа газрын хаягаа өөрчилсөн бол энэ тухай шүүхэд мэдэгдэх үүрэгтэй. Хаягаа өөрчилснөө мэдэгдээгүй тохиолдолд мэдэгдэх хуудсыг түүний шүүхэд бүртгүүлсэн хаягаар хүргүүлж, энэ хуулийн 59.6, 59.7-д заасан хүн, албан тушаалтанд хүлээлгэн өгөх бөгөөд түүнийг хүргэсэнд тооцно.



59.10.Мэдэгдэх хуудсыг хүлээн авсан хэргийн оролцогч, бусад оролцогч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхэд ирээгүй бөгөөд түүнийг зайлшгүй ирүүлэх шаардлагатай гэж үзвэл шүүгч албадан ирүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

59.11.Энэ хуулийн 59.10-т заасан ажиллагааг эрх бүхий байгууллага гүйцэтгэнэ.

### **60 дугаар зүйл.Хэргийг нэгтгэх, тусгаарлах**

60.1.Аль нэг захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн маргаантай хэрэг байгаа, эсхүл нэг нэхэмжлэгчээс өөр өөр хариуцагчид гаргасан нэхэмжлэлтэй хэд хэдэн хэргийг шүүх нэг ажиллагаагаар нэгтгэн хэлэлцэж болно.

60.2.Нэгтгэн гаргасан, эсхүл хэд хэдэн нэхэмжлэгч гаргасан болон хэд хэдэн хариуцагчид холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагатай нэг болон хэд хэдэн хэргийг тусгаарлаж болно.

### **61 дүгээр зүйл.Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх**

61.1.Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, эмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ.

61.2.Захиргааны хэм хэмжээний актын биелэлтийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлж болно.

61.3.Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамж нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хүчин төгөлдөр байна.

### **62 дугаар зүйл.Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл**

62.1.Захиргааны актын биелэлтийг дараахь тохиолдолд түдгэлзүүлж болохгүй:

62.1.1.захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол;

62.1.2.хүн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай шийдвэр бол;



62.1.3.захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн бол уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр бол;

62.1.4.хуульд заасан тохиолдолд үл маргалдах журмаар биелүүлэх бол.

### **63 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа**

63.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

63.2.Хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээс дахин хэлэлцүүлэхээр буцаасан бол хэргийг тухайн шүүх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

63.3.Энэ хуулийн 63.1, 63.2-т заасан хугацааг шаардлагатай тохиолдолд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс эхний удаа 30 хүртэл хоногоор, хоёр дахь удаагаа 15 хүртэл хоногоор сунгаж болно.

63.4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад хугацааг энэ хуулийн 63.1-63.3-т заасан хугацааны дотор шүүгч тогтоож болно.

63.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хугацаа энэ хуулийн 63.1-63.3-т заасан хугацаанд хамаарахгүй.

### **64 дүгээр зүйл.Хугацааг тодорхойлох, тоолох**

64.1.Хугацааг тодорхойлох, тоолохдоо Захиргааны ерөнхий хуулийн 33 дугаар зүйлд заасан хугацааг тодорхойлох, тоолох журмыг баримтална.

### **65 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх**

65.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараахь тохиолдолд шүүгч захирамж, шүүх тогтоол гарган түдгэлзүүлнэ:

65.1.1.хэргийн оролцогч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан үед маргаантай байгаа шаардлага болон үүрэг эрх залгамжлагчид шилжих ёстой байвал;

65.1.2.хэргийн оролцогч онц ба дайны байдал зарласан нөхцөлд цэргийн алба хааж байгаа;



65.1.3.эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх, арбитрын журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй;

65.1.4.хэргийн оролцогч хүнд өвчний учир эмчлүүлж байгаа бөгөөд төлөөлөгч томилох боломжгүй;

65.1.5.хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй тухай асуудлаар Улсын дээд шүүхэд санал оруулсан;

65.1.6.хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэсэн;

65.1.7.энэ хуулийн 33, 35, 40 дүгээр зүйлд заасан ажиллагаа явуулж байгаа.

65.2.Энэ хуулийн 65.1-д зааснаас бусад шалтгаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

65.3.Энэ хуулийн 65.1-д заасан нөхцөл байдал арилсан тохиолдолд шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

### **66 дугаар зүйл.Нэхэмжлэлийн шаардлагаас татгалзах**

66.1.Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд нэхэмжлэлээсээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзаж болно.

66.2.Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаа бичгээр илэрхийлэх бөгөөд шүүх хуралдааны явцад нэхэмжлэлээсээ бүхэлд нь татгалзвал шүүх хуралдааны ажиллагааг дуусгаж, тэмдэглэлд тусгана.

66.3.Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаасаа хэсэгчлэн татгалзсан тохиолдолд татгалзсан хэсгийг баталж, үлдсэн нэхэмжлэлийн шаардлагад холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ердийн журмаар явагдана.

66.4.Нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан этгээд уг асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхээ алдах бөгөөд харин бусад этгээд уг асуудлаар нэхэмжлэл гаргахад саад болохгүй.



### **67 дугаар зүйл.Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх**

67.1.Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн нь бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй байвал шүүх хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

### **68 дугаар зүйл.Нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх**

68.1.Нэхэмжлэгч, хариуцагч харилцан буулт хийж, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, шаардлагыг биелүүлэх арга замаа тодорхойлох зэргээр хоорондоо тохиролцож эвлэрлийн гэрээ байгуулж, маргаанаа дуусгавар болгож болно.

68.2.Нэхэмжлэгч, хариуцагч нар эвлэрлийн гэрээг бичгээр хийж, гарын үсгээ зурсан байна.

68.3.Шүүх хуралдааны явцад эвлэрвэл энэ тухай хуралдааны тэмдэглэлд тусгана.

68.4.Нэхэмжлэгч, хариуцагчийн эвлэрсэн нь хуульд харшлаагүй бөгөөд бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй нь тогтоогдвол шүүх эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

### **69 дүгээр зүйл.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсний үр дагавар**

69.1.Шүүх хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ нөхөн төлүүлэх шүүхийн зардал болон улсын тэмдэгтийн хураамжийг энэ хуулийн 47, 48 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэнэ.

69.2.Энэ хуулийн 66-68 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй бөгөөд шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелүүлнэ.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

### **70 дугаар зүйл.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журам**

70.1.Шүүгч дараахь хүсэлтийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор урьдчилсан хэлэлцүүлгээр хянан хэлэлцэнэ:



70.1.1. нотлох баримт хасуулах;

70.1.2. захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх;

70.1.3. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх;

70.1.4. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс урьдчилсан хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

70.2. Шүүх хуралдааныг товлон зарлахад урьдчилсан хэлэлцүүлэг хийнэ.

70.3. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг гурваас доошгүй хоногийн өмнө хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

70.4. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохгүй тухай шүүхэд мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүй нь урьдчилсан хэлэлцүүлэг явуулахад саад болохгүй.

70.5. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг мэтгэлцэх зарчмаар явагдах бөгөөд хэргийн оролцогчид гаргасан хүсэлт, татгалзлын үндэслэлээ нотолно.

70.6. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.

70.7. Энэ хуулийн 70.1.2-т заасан хүсэлтийг шийдвэрлэх хугацааг хэргийн оролцогчдыг татан оролцуулснаас хойш тооцно.

70.8. Шаардлагатай бол энэ хуулийн 70.1-д заасан хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор шүүгч сунгаж болно.

70.9. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу үйлдсэн тэмдэглэлтэй хэргийн оролцогч танилцаж болно.

70.10. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой асуудлыг хэлэлцэхгүй.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ  
ШҮҮХ ХУРАЛДААНЫГ ТОВЛОН ЗАРЛАХ,  
ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮН, ШҮҮХ ХУРАЛДААНЫ ОРОЛЦОГЧ,  
ХУРАЛДААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ**

**71 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг товлон зарлах**

71.1. Шүүгч захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд хангалттай нотлох баримт цугларсан гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 63 дугаар зүйлд заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай бусад тохиолдолд шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг урьдчилсан хэлэлцүүлгийн журмаар товлож, долоо, түүнээс доошгүй хоногийн өмнө зарлаж, хэргийн оролцогч, бусад оролцогчид хурлын товыг мэдэгдэнэ.

71.2. Хэргийн оролцогч шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүрэгтэй.

**72 дугаар зүйл. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох**

72.1. Хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг жил, хагас жил зэрэг тодорхой хугацаагаар тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс хуваарь гарган томилж, Ерөнхий шүүгчийн захирамжаар албажуулна.

72.2. Хуваарийн дагуу томилогдсон шүүгч, шүүх бүрэлдэхүүн тухайн шүүх хуралдаанд оролцож чадахгүй тохиолдолд түүнийг орлох шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг энэ хуулийн 72.1-д заасан журмаар томилно.

72.3. Шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч удирдана. Шүүгчдийн зөвлөгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шүүгчдийн зөвлөгөөн тухайн шүүхийн шүүгчдийн олонхи оролцсон тохиолдолд хүчинтэй байна. Шүүгч бүр тэгш эрхтэй оролцоно.

72.4. Ерөнхий шүүгч бусад шүүгчтэй адил энэ хуулийн 72.1-д заасан хуваарийн дагуу хэрэг хянан шийдвэрлэнэ.

72.5. Тухайн жилийн турш шүүгчийн ажлын ачаалал ихэссэн, ажиллах шүүгчдийн тоо нэмэгдсэн, хасагдсаны улмаас энэ хуулийн 72.1, 72.2-т заасны дагуу хянан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Ерөнхий шүүгч тухай бүр шүүгчдийн зөвлөгөөнийг зарлан хуралдуулна.

**73 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгч оролцох**

73.1. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн иргэдийн





төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд<sup>7</sup> заасан журмын дагуу оролцуулна.

#### **74 дүгээр зүйл. Шүүх бүрэлдэхүүн**

74.1. Захиргааны хэргийн шүүх дараахь хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ:

74.1.1. анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүхээс хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан;

74.1.2. захиргааны хэм хэмжээний акттай холбоотой;

74.1.3. тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоосон.

74.2. Энэ хуулийн 74.1-д зааснаас бусад хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.

74.3. Давж заалдах журмаар хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

74.4. Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүх таван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

#### **75 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгч, түүний эрх, үүрэг**

75.1. Захиргааны хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулна.

75.2. Иргэдийн төлөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэхэд дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

75.2.1. шүүхийн байранд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх;

75.2.2. нотлох баримт шинжлэхэд оролцох;

75.2.3. хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих;

75.2.4. нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах;

<sup>7</sup> Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

75.2.5.хэргийн үйл баримт, захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргах;

75.2.6.өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх;

75.2.7.энэ хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх.

75.3.Энэ хуулийн 75.2.5-д зааснаар хэргийн үйл баримт, захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэх талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсоно.

#### **76 дугаар зүйл.Шүүх бүрэлдэхүүнийг өөрчилж үл болох**

76.1.Шүүх хуралдааны явцад хэргийг гагцхүү шүүхийн нэг бүрэлдэхүүнээр шийдвэрлэнэ. Хэрэв шүүх бүрэлдэхүүний хэн нэг нь шүүх хуралдааны ажиллагаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд энэ хуулийн 72.1-д заасан журмын дагуу өөр шүүгч, шүүх бүрэлдэхүүнээр сольж, уг хэргийг шинээр хянан шийдвэрлэнэ.

#### **77 дугаар зүйл.Шүүх хуралдаанд оролцогч**

77.1.Шүүх хуралдаанд оролцогчийг энэ хуулийн 17 дугаар зүйл, 77.2-т заасны дагуу хэргийн болон бусад оролцогч гэж ангилна.

77.2.Шүүх хуралдаанд оролцож байгаа хэргийн оролцогчийн төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг бусад оролцогч гэнэ.

#### **78 дугаар зүйл.Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга**

78.1.Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдаан явуулах бэлтгэлийг хангаж, шүүх хуралдааны ирцийг бүртгэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүнд танилцуулах, шүүх хуралдааныг дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр танилцуулан, шүүгчээр баталгаажуулан хэргийн баримтад хавсаргах, шаардлагатай бусад ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

#### **79 дүгээр зүйл.Орчуулагч, хэлмэрч**

79.1.Хэргийн оролцогч монгол хэл мэдэхгүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэйн улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол шүүгч тэдгээрийн хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг захирамж гарган томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.



79.2. Орчуулагч, хэлмэрч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал, шүүх хуралдааны болон бусад ажиллагаа, шүүхийн шийдвэрийн агуулгыг үнэн зөв, бүрэн орчуулж, хэлмэрчилж өгөх, хэргийн материалтай цаг хугацаанд нь танилцахад туслах үүрэгтэй.

79.3. Орчуулагч, хэлмэрч нь орчуулгыг тодруулахаар асуулт тавьж болно.

79.4. Хэргийн болон бусад оролцогч орчуулагч, хэлмэрчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

79.5. Санаатайгаар буруу орчуулсан, хэлмэрчилсэн, эсхүл орчуулга хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан орчуулагч, хэлмэрчид холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **80 дугаар зүйл. Шүүх хуралдаан**

80.1. Энэ хуулийн 66-68 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд захиргааны хэргийг гагцхүү шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

80.2. Нотлох баримт цуглуулах зайлшгүй шаардлагатай, эсхүл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцох боломжгүй нь шүүх хуралдаанаас өмнө тогтоогдсон тохиолдолд уг нөхцөлийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр товлосон хуралдааныг 14 хүртэл хоногоор хойшлуулж болно.

### **81 дүгээр зүйл. Шүүх хуралдаан даргалагчийн эрх, үүрэг**

81.1. Шүүх хуралдааныг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилсон шүүгч даргална.

81.2. Шүүх хуралдаан даргалагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, хэргийн болон бусад оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчмыг хангах, шүүх хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

### **82 дугаар зүйл. Шүүх хуралдааны нийтлэг журам**

82.1. Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн шүүхийг хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.

82.2.Шүүх хуралдаанд оролцогч тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас суудлаасаа босч чадахгүй бол хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаагаар үг хэлж болно.

82.3.Шүүгч, шүүх бүрэлдэхүүн хуралдааны танхимд орж ирэх, шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох үед танхимд байгаа бүх хүн суудлаасаа босно.

82.4.Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Зөрчлийг дахин гаргасан этгээдийг хуралдаан даргалагчийн шийдвэрээр шүүх хуралдааны танхимаас гаргаж, энэ хуулийн 83 дугаар зүйлд заасан шийтгэл оногдуулна.

82.5.Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, бусад оролцогчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар хойшлуулах, эсхүл тэдгээрийн тайлбар, мэдүүлэг, дүгнэлтийг сонсохгүйгээр хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл үргэлжлүүлэн явуулах бөгөөд хуралдаан даргалагч уг этгээдэд түүний байхгүйд хэлэлцсэн асуудлыг танилцуулна.

### **83 дугаар зүйл. Шийтгэл оногдуулах**

83.1.Хуульд заасан торгох шийтгэл оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч шийтгэвэр, шүүх тогтоол гарган зөрчил гаргасан этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

83.2.Энэ хуулийн 83.1-д зааснаас бусад тохиолдолд торгох шийтгэл оногдуулах асуудлыг зөрчил гаргасан этгээдийг дуудан ирүүлж шийдвэрлэнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр түүний ирээгүй явдал шийтгэвэр гаргахад саад болохгүй.

### **84 дүгээр зүйл. Татгалзан гарах үндэслэл**

84.1.Дараахь үндэслэл байвал шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй:

84.1.1.урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэхэд хэргийн оролцогч, бусад оролцогчийн хувиар оролцож байсан;

84.1.2.уг хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн гэр бүл, төрөл садан, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн болон төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон;



84.1.3.хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, эсхүл уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;

84.1.4.анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх болсон;

84.1.5.ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон;

84.1.6.анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг тухайн шатны журмаар хянан шийдвэрлэхэд дахин оролцох болсон.

84.2.Энэ хуулийн 84.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно.

84.3.Энэ хуулийн 84.1.1-84.1.3, 84.1.5-д заасан заалт шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргад нэгэн адил хамаарна.

84.4.Энэ хуулийн 84.1-д заасан татгалзан гарах үндэслэл байвал шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдаан эхлэхээс өмнө бичгээр, эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад илэрхий болсон бол энэ тухайгаа бичгээр мэдэгдэж, тэмдэглэлд тусгуулан татгалзан гарах үүрэгтэй.

84.5.Шинжээч энэ хуулийн 84.1.1-84.1.3, 84.1.5-д зааснаас гадна дараахь тохиолдолд дүгнэлт гаргахаас татгалзана:

84.5.1.албан тушаалын болон бусад байдлаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нь шинжээчид нөлөөлөхөөр бол;

84.5.2.урьд нь түүний хийсэн шинжилгээний дүгнэлт уг хэргийн үндэс болсон.

### **85 дугаар зүйл.Татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх журам**

85.1.Энэ хуулийн 84.1-д заасан үндэслэлээр шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлтийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гаргаж болох ба энэ тохиолдолд татгалзан гаргагдаж байгаа этгээдийн тайлбарыг сонсож болно.



85.2.Татгалзан гаргах хүсэлтийг шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гарган шийдвэрлэнэ.

85.3.Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг түүнийг байлцуулахгүйгээр бусад шүүгчид шийдвэрлэх ба санал тэнцвэл уг шүүгчийг татгалзан гаргасанд тооцно.

85.4.Хэд хэдэн болон хэргийг дангаар шийдвэрлэх шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.

85.5.Иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлтийг хэргийг хэлэлцэж байгаа шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

85.6.Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан, эсхүл тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөгөөн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

85.7.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэрлэсэн асуудалтай нь холбогдуулан шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргахыг хориглоно.

## **86 дугаар зүйл.Татгалзан гаргасны үр дагавар**

86.1.Шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг хангасан бол хэргийг өөр шүүгч, шүүх бүрэлдэхүүн хянан шийдвэрлэнэ.

86.2.Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд заасан үндэслэлээр дахин оролцох боломжгүй болсон, шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй болсон тохиолдолд хэргийг анхан шатны өөр захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шилжүүлнэ.

86.3.Энэ хуулийн 86.2-т заасны дагуу хэрэг шилжиж ирсэн тохиолдолд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу тухайн шүүхийн шүүгч хүлээн авч хянан шийдвэрлэнэ.

86.4.Иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлтийг хангасан тохиолдолд өөр оролцогчийг оролцуулна.



**87 дугаар зүйл. Шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах, санал хураах**

87.1. Бүх шатны захиргааны хэргийн шүүх Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31.5, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.6-д заасны дагуу шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана.

87.2. Зөвлөлдөх тасалгаанд хэргийг шийдвэрлэх талаар шүүгчийн гаргасан санал нууц байна.

87.3. Шүүх бүрэлдэхүүн асуудал бүрийг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

87.4. Хуралдаан даргалагч бүрэлдэхүүнд орсон бусад шүүгчийн дараа саналаа гаргана.

87.5. Зөвлөлдөх тасалгаанд шүүгч саналаа өгөхөөс татгалзах эрхгүй.

**88 дугаар зүйл. Шүүх хуралдааны тэмдэглэл**

88.1. Шүүх хуралдааны тэмдэглэлд хуралдааныг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дууссан цаг, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, ирц болон тэдэнд эрх, үүргийг тайлбарласан байдал, шүүх хуралдаанд оролцогчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, нотлох баримтыг шинжилсэн байдал, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэргийн талаар асууж тодруулсан байдал, тусгай саналын товч утга, шүүхийн шийдвэрийн агуулга, түүнд гомдол гаргах хугацаа, журмыг тайлбарласан талаар бичнэ.

88.2. Шүүх хуралдааныг дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулна. Энэ заалт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хамаарахгүй.

88.3. Шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш долоо хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгох ба түүнд шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

88.4. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж болно. Тэмдэглэлтэй холбогдон гарсан саналыг шүүгч шийдвэрлэнэ.

88.5. Шүүх хуралдааны тэмдэглэл алдаатай, дутуу бичигдсэн бол шүүгч, шүүх бүрэлдэхүүн өөрийн санаачлагаар, эсхүл шүүх хуралдааны оролцогчийн хүсэлтээр гурван хоногийн дотор засвар хийж, энэ тухай тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

**АРАВДУГААР БҮЛЭГ**  
**АНХАН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР**

**89 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээх**

89.1.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг нээж, ямар хэрэг хянан шийдвэрлэх гэж байгааг зарлан мэдэгдэж, танхимд байгаа хүмүүст суухыг зөвшөөрнө.

**90 дүгээр зүйл.Шүүх хуралдааны ирц, оролцох эрхийг шалгах**

90.1.Шүүх хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, ирээгүй оролцогчид шүүх хуралдааны товыг мэдэгдсэн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг хуралдаан даргалагчид илтгэн танилцуулна.

90.2.Шүүх хэргийн оролцогч, бусад оролцогчтой нэг бүрчлэн танилцаж, төлөөлөх, өмгөөлөх бүрэн эрхийг шалгана.

**91 дүгээр зүйл.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ирээгүйгээс гарах холбогдол**

91.1.Нэхэмжлэгч өөрөө болон төлөөлөгч, өмгөөлөгчийнхөө эзгүйд шүүх хуралдааныг хийх талаар шүүхэд бичгээр хүсэлт ирүүлсэн бол тэдгээрийг оролцуулахгүйгээр хэргийг хянан шийдвэрлэж болно.

91.2.Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд хариуцагчийн хүсэлтээр шүүх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл хэргийг хянан шийдвэрлэж болно.

91.3.Шүүх энэ хуулийн 91.2-т заасан этгээдийг заавал байлцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг хойшлуулж, дахин дуудан ирүүлэх бөгөөд хоёр дахь удаагаа ирээгүй бол нэхэмжлэлийг буцаана.

91.4.Хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бөгөөд нэхэмжлэгч хэргийг тэдгээрийн эзгүйд хянан шийдвэрлэх талаар хүсэлт гаргасан бол шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг үндэслэн хэргийг хянан шийдвэрлэж болно.

91.5.Энэ хуулийн 91.2, 91.4-д зааснаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын эзгүйд хэргийг хянан шийдвэрлэх тухай хүсэлтийг гаргаагүй байсан ч шүүх хэрэгт цугларсан нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан хэргийг шийдвэрлэж болно. Ингэхдээ хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс урьд гаргасан тайлбарыг шүүх хуралдаан дээр гаргасантай адилтгаж үзнэ.





91.6.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын аль аль нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол шүүх хэргийг энэ хуулийн 91.5-д заасны дагуу шийдвэрлэж болно.

91.7.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 71.1-д заасны дагуу мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол хэргийн оролцогчийн зөвшөөрлөөр түүний эзгүйд шүүх хуралдаан явуулж болно. Харин хэргийн оролцогчийн аль нэг нь зөвшөөрөөгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.

## **92 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрчийн үүргийг тайлбарлах**

92.1.Шүүх хуралдаан даргалагч орчуулагч, хэлмэрчид түүний үүрэг, буруу орчуулж, хэлмэрчилбэл хүлээлгэх хариуцлагыг сануулж, энэ тухайгаа баримтжуулна.

## **93 дугаар зүйл. Гэрчийг гаргах**

93.1.Шүүх хуралдаанд дуудагдсан гэрчийг шүүх хуралдааны танхимаас түр гаргана.

93.2.Гэрчүүдийг хооронд нь харилцуулахгүй байлгах талаар шүүх хуралдаан даргалагч шаардлагатай арга хэмжээ авна.

## **94 дүгээр зүйл. Шүүх бүрэлдэхүүнийг зарлах ба татгалзан гаргах эрхийг тайлбарлах**

94.1.Шүүх хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүнийг зарлан, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг танилцуулж, тэдгээрийг татгалзан гаргах эрхтэйг тайлбарлана.

94.2.Татгалзан гаргах хүсэлтийг энэ хуулийн 85 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

## **95 дугаар зүйл. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид эрх, үүргийг тайлбарлах**

95.1.Шүүх хуралдаан даргалагч хэргийн оролцогч, бусад оролцогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлан өгнө.

## **96 дугаар зүйл. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг шийдвэрлэх**

96.1.Шинэ нотлох баримт цуглуулах болон хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой бусад асуудлын талаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргасан хүсэлтийг бусад оролцогчийн саналыг сонсмогц шүүгч, шүүх бүрэлдэхүүн даруй шийдвэрлэнэ. Шүүхийн



урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлаар шүүх хуралдаан дээр дахин хүсэлт гаргах эрхгүй.

96.2.Шүүх хуралдааны явцад нэмэлт нотлох баримт зайлшгүй шаарлагатай болсон, эсхүл шүүх хуралдаанд ирээгүй оролцогчийг зайлшгүй оролцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг 14 хүртэл хоногоор хойшлуулж болно.

96.3.Шүүх хуралдааны явцад шинэ нотлох баримт зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулж болно.

### **97 дугаар зүйл.Хэрэг хэлэлцэж эхлэх**

97.1.Хэрэг хэлэлцэх ажиллагаа шүүгч хэргийн талаар танилцуулснаар эхэлнэ.

97.2.Нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж байгаа эсэх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрч байгаа эсэх, эвлэрэх хүсэлтэй байгаа эсэхийг шүүх хуралдаан даргалагч асууж тодруулна.

### **98 дугаар зүйл.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч мэтгэлцэх**

98.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч тайлбар гаргахын өмнө шүүх хуралдаан даргалагч тэдэнд эрх, үүрэг болон үнэн зөв тайлбар өгөхийг урьдчилан сануулна.

98.2.Нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл, маргааны үйл баримт, захиргааны үйл ажиллагааны үндэслэлийг нотлох болон үгүйсгэх байдлаар мэтгэлцэнэ.

98.3.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч урьд бичгээр тайлбар гаргасан бол шүүх хуралдаан дээр тухайн тайлбараа танилцуулж болно.

### **99 дүгээр зүйл.Нотлох баримтыг шинжлэх дараалал**

99.1.Шүүх хуралдаан даргалагч гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, цугларсан бичмэл болон эд мөрийн баримтыг судлах, үзлэг хийх, бусад нотлох баримтыг шинжлэх дарааллыг тогтооно.

### **100 дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг сонсох**

100.1.Шүүх хуралдаан даргалагч гэрчийг шүүх хуралдааны танхимд оруулж, түүний үүрэг, хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, баримтжуулна.



100.2.Хоёр, түүнээс олон гэрчийг тус тусад нь асууна. Мэдүүлэг өгч эхлээгүй байгаа гэрч шүүх хуралдааны ажиллагаа явагдаж байх үед шүүх хуралдааны танхимд байж болохгүй. Хэрэв мэдүүлэг өгсөн гэрчийг гарч явахыг шүүх хуралдаан даргалагч зөвшөөрөөгүй бол гэрч шүүх хуралдаан дуустал танхимд байна.

100.3.Насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахдаа эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл сурган хүмүүжүүлэгчийг байлцуулна.

100.4.Насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг шүүх сонсохдоо үнэн зөв мэдүүлэг өгөхөд нь нөлөөлж болохоор оролцогчийг шүүх хуралдааны танхимаас түр гаргаж болох бөгөөд гарсан этгээд шүүх хуралдааны танхимд буцаж ороход насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг түүнд танилцуулж, асуулт тавих боломж олгоно.

100.5.Насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонссоны дараа түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргана.

100.6.Шүүгч гэрчээс мэдүүлгийг урьдчилан авах, эсхүл давтан асууж болно.

### **101 дүгээр зүйл.Бичмэл, цахим болон эд мөрийн баримтыг шинжлэх**

101.1.Шүүх хэрэгт цугларсан эд мөрийн баримт болон баримт бичгийг судалж, шаардлагатай бол хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчийн хүсэлтээр бичмэл, цахим нотлох баримтыг шүүх хуралдаанд уншин сонгож, эд мөрийн баримтыг танилцуулна.

101.2.Хуульд заасан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбогдсон баримтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад танилцуулахгүй. Захидал харилцааны нууцыг хамгаалахын тулд хувийн захидал, бичгийг тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр нээлттэй шүүх хуралдаанд уншин сонгож болно. Хэрэв зөвшөөрөл аваагүй бол хувийн захидал, бичгийг уншин сонгох болон шинжлэх ажиллагааг хаалттай шүүх хуралдаанаар гүйцэтгэнэ.

101.3.Хэрэгт байгаа бичмэл, цахим баримт хуурамч болохыг мэдсэн этгээд уг баримтыг нотлох баримтаас хасуулах хүсэлтийг шүүхэд гаргана. Бичмэл баримт хуурамч гэж мэдэгдсэн этгээд энэ тухайгаа нотлох үүрэгтэй. Бичмэл, цахим баримт хуурамч эсэхийг шалгахын тулд шүүх шинжилгээ хийлгэх болон бусад нотлох баримт шаардан авч болно.

101.4.Бичмэл, цахим баримт хуурамч байсан нь тогтоогдвол шүүх түүнийг нотлох баримтаас хасах бөгөөд хэргийн оролцогч, тэдгээрийн



төлөөлөгч, өмгөөлөгч шаардлагатай гэж үзвэл хуурамч баримт бичгийн талаар эрх бүхий байгууллагад гомдол гаргаж болно.

### **102 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт сонсгох**

102.1.Шинжээчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсоно.

102.2.Шинжээч шүүх хуралдаанд оролцож байгаа бол өөрийн дүгнэлтийг тайлбарлана. Дараа нь шинжээчид асуулт тавьж болно.

102.3.Шүүх шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, тодорхой бус болон үндэслэлгүй, эсхүл шинжээч зөрүүтэй дүгнэлт гаргасан гэж үзвэл Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасны дагуу шинжилгээ хийлгэж болно.

### **103 дугаар зүйл.Хэргийн оролцогчоос нэмж тодруулах**

103.1.Нотлох баримт шинжлэн судалсны дараа шүүх хуралдаан даргалагч нэмж тодруулах зүйл байгаа эсэхийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс асууна.

### **104 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргах**

104.1.Иргэдийн төлөөлөгч маргааны үйл баримтын талаар дүгнэлтээ бичгээр гаргана. Эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, амаар дүгнэлт гаргаж болно.

104.2.Иргэдийн төлөөлөгч дүгнэлтээ шүүх хуралдаанд уншиж сонсоно.

### **105 дугаар зүйл.Шүүх хуралдаан завсарлах**

105.1.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаан завсарласныг мэдэгдэж, шүүх бүрэлдэхүүн шийдвэрээ гаргахын тулд зөвлөлдөх тасалгаанд орно.

105.2.Шүүх хуралдааны завсарлагаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүх хуралдааныг орхиж явахыг хориглоно.

### **106 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр, түүнийг гаргах**

106.1.Анхан шатны шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.

106.2.Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.



106.3. Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараахь шийдвэрийг гаргана:

106.3.1. захиргааны акт, захиргааны гэрээ хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох;

106.3.2. захиргааны акт, захиргааны гэрээ нь илт хууль бус болохыг тогтоох;

106.3.3. захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох;

106.3.4. захиргааны актыг гаргахаас татгалзсан шийдвэр, эсхүл гаргахгүй байгаа эс үйлдэхүй нь хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн бол шаардагдах захиргааны акт гаргахыг тухайн захиргааны байгууллагад даалгах, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоох;

106.3.5. эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож, хүлээн зөвшөөрөх;

106.3.6. төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг багасгах;

106.3.7. захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчилж тогтоох;

106.3.8. захиргааны хэм хэмжээний акт хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоох;

106.3.9. захиргааны байгууллагын гаргасан нэхэмжлэлийн хувьд хууль зөрчигдсөн болон нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн нь тогтоогдвол хүчингүй болгох;

106.3.10. захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох;

106.3.11. шүүх хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд нэмж тодруулах зүйлийн цар хүрээ

шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн гэж үзвэл захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актыг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх;

106.3.12.нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангах;

106.3.13.нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох;

106.3.14.нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох.

106.4.Шүүхийн шийдвэр нь хэрэгт авагдсан бөгөөд шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтад үндэслэсэн байна.

106.5.Шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй.

106.6.Захиргааны үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарч хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

106.7.Шүүх захиргааны байгууллага сонгох боломжийг хэрэглэхдээ хуулийн хязгаарыг хэтрүүлсэн, буруу хэрэглэсэн, эсхүл өөрт олгосон эрх хэмжээг зорилгодоо нийцээгүй байдлаар ашигласны улмаас түүний гаргасан захиргааны акт, эсхүл татгалзсан үйлдэл, эс үйлдэхүй хууль зөрчсөн эсэхийг шалгана.

106.8.Шүүхийн шийдвэрт шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурах ба шүүгч гарын үсгээ зурахаас татгалзах эрхгүй.

### **107 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийн агуулга**

107.1.Шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ.

107.2.Удиртгал хэсэгт шүүхийн шийдвэрийг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана.

107.3.Тодорхойлох хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг тусгана.

107.4.Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэслэл болгосон нотлох



баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэл, түүнд өгөх тайлбар, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон хэм хэмжээ, тэдгээрийг хэргийн бодит нөхцөл байдалд хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн тухайгаа тусгана.

107.5.Тогтоох хэсэгт хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, түүнчлэн нөхөн төлүүлэх шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилсан байдал, эд мөрийн баримтыг хэрхэх, хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч тус бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана. Шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацаа, шийдвэрийг давж заалдах журам, хугацааг заана.

107.6.Энэ хуулийн 106.3.11-д заасан шийдвэрийг гаргасан бөгөөд шүүхээс тогтоосон хугацаанд захиргааны байгууллага шинэ акт гаргаагүй бол уг маргаан бүхий актыг хүчингүй болгох талаар тогтоох хэсэгт тусгана.

107.7.Энэ хуулийн 107.5-д заасан тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байна.

### **108 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг танилцуулах, шийдвэр хүчинтэй болох**

108.1.Шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулж, шаардлагатай бусад асуудлыг тайлбарлан шүүх хуралдааныг хаана.

108.2.Шүүхийн шийдвэр танилцуулан сонсгосноор хүчинтэй болно.

108.3.Шүүхийн шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 14 хоногийн дотор шийдвэрийн агуулгыг энэ хуулийн 107 дугаар зүйлд заасны дагуу бүрэн эхээр нь бичгээр үйлдэж шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна.

108.4.Шүүх хуралдаанд оролцсон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 108.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор шүүхэд хүрэлцэн ирж шүүхийн шийдвэрийг өөрөө гардан авна.

108.5.Энэ хуулийн 108.4-т заасан хугацаанд гардан аваагүй нь гомдол гаргах хугацааг хуульд заасан журмын дагуу тоолоход саад болохгүй.



108.6.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн оролцоогүйгээр хэргийг шийдвэрлэсэн бол шүүх шийдвэрийг энэ хуулийн 108.4-т заасан хугацаанд тэдгээрт гардуулах бөгөөд гардуулах боломжгүй, эсхүл энэ хуулийн 108.4-д заасны дагуу хүрэлцэн ирж шүүхийн шийдвэрийг гардан аваагүй бол шүүх шүүхийн шийдвэрийг уг хугацаа өнгөрснөөс хойш долоо хоногийн дотор хэргийн оролцогчийн оршин суугаа /оршин байгаа/ газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар хүргүүлнэ.

108.7.Энэ хуулийн 108.6-д заасны дагуу хүргүүлснийг гардан авсанд тооцох бөгөөд шүүхийн шийдвэрийг хүргүүлэхдээ энэ хуулийн 59.7-д заасан журмыг баримтална.

108.8.Шүүхийн буруутай үйл ажиллагааны улмаас энэ хуулийн 108.4-т заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд энэ хуулийн 108.5 дахь хэсэг хамаарахгүй. Энэ тохиолдолд шийдвэрийг энэ хуулийн 108.6-д заасан журмын дагуу хүргүүлж, хугацааг энэ хуулийн 108.6-д заасны дагуу тоолно.

### **109 дүгээр зүйл.Шүүхээс гаргах бусад шийдвэр**

109.1.Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад энэ хуулийн 66-68 дугаар зүйлд заасан үндэслэл, нөхцөл байдал илэрвэл шүүгч, шүүх бүрэлдэхүүн нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

109.2.Энэ хуулийн 54.1-д заасан үндэслэл хэргийг хянан шийдвэрлэх явцад, эсхүл шүүх хуралдааны үед тогтоогдвол шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

### **110 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох**

110.1.Анхан шатны шүүхийн шийдвэр дараахь тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болно:

110.1.1.энэ хуулийн 114.1-д заасан хугацаанд давж заалдах гомдол гаргаагүй;

110.1.2.давж заалдах гомдол гаргасан бөгөөд давж заалдах журмаар гомдлыг хянан хэлэлцээд энэ хуулийн 119.2-т заасны дагуу гаргасан магадлалд хяналтын журмаар гомдол гаргаагүй;

110.1.3.давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гомдол гаргасан бөгөөд хяналтын шатны шүүх гомдлыг хянан хэлэлцээд энэ хуулийн 127.2.1-127.2.3-т заасан тогтоол гаргасан.





110.2.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, түүнчлэн хэргийн оролцогчийн эрх залгамжлагч шүүхээр нэгэнт хянан шийдвэрлэсэн маргааны талаар дахин шүүхэд нэхэмжлэл гаргах болон шүүхээс нэгэнт тогтоосон үйл баримт, эрх зүйн харилцаа, хэрэг хянан шийдвэрлэх өөр ажиллагааны талаар маргах эрхгүй.

**111 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, тэдгээрийг хүчингүй болгох, өөрчлөх**

111.1.Энэ хуулийн 106 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаснаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэрлэж байгаа асуудлаар шүүгч захирамж, шүүх тогтоол гаргана.

111.2.Хуульд гомдол гаргахаар заасан болон шүүх хуралдааны бус үед хянан шийдвэрлэж байгаа асуудлаар шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг ажлын гурван өдрийн дотор бичгээр гаргана.

111.3.Энэ хуулийн 111.1-д заасны дагуу гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол илт үндэслэлгүй бол уг захирамж, тогтоолыг гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүн хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
ТУСГАЙ ЖУРАМ**

**112 дугаар зүйл.Тусгай журмаар шийдвэрлэх маргаан**

112.1.Дараахь төрлийн маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ:

112.1.1.улсын хэмжээний, эсхүл хоёр болон түүнээс дээш засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд үйлчлэх захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргаан;

112.1.2.аймаг хоорондын, эсхүл аймаг, нийслэлийн хоорондын маргаан;

112.1.3.хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргаан;

112.1.4.хуулиар тусгайлан заасан бусад маргаан.

112.2.Энэ хуулийн 112.1.3-т заасан маргааныг шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор сунгаж болно.

112.3.Энэ хуулийн 112.2-т зааснаас бусад 112.1-д заасан маргааны хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ердийн хугацаа үйлчилнэ.



112.4. Дараахь төрлийн маргааныг анхан шатны шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ:

112.4.1. хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргаан;

112.4.2. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой маргаан.

112.5. Энэ хуулийн 112.4.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэхэд хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор сунгаж болно.

112.6. Шүүх нэмэлт нотлох баримт цуглуулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 112.4.2-т заасан маргааныг хянан шийдвэрлэх хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

112.7. Энэ хуулийн 112.1.3, 112.4.1, 112.4.2-т заасан маргааны нэхэмжлэлийг хариуцагч гардан авсанаас хойш долоо хоногийн дотор хариу тайлбар болон нотлох баримтаа шүүхэд ирүүлнэ.

### **113 дугаар зүйл. Тусгай журмаар хэлэлцэх шүүхийн шийдвэр**

113.1. Энэ хуулийн 112.1.3, 112.4-д заасан маргааныг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэрийг таван хоногийн дотор бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гардан авна.

113.2. Энэ хуулийн 113.1-д заасан шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш таван хоногийн дотор давж заалдах журмаар гомдол гаргах эрхтэй.

113.3. Энэ хуулийн 113.2-т заасан гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

113.4. Энэ хуулийн 112.1.1, 112.1.2-т заасан маргааны хувьд энэ хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ердийн хугацаа үйлчилнэ.

### **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ДАВЖ ЗААЛДАХ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

#### **114 дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах, гомдлыг хүлээн авах**

114.1. Хуульд өөрөөр заагаагүй бол анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш



хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч 14 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.

114.2. Давж заалдах гомдлыг шийдвэр гаргасан шүүхээр дамжуулан гаргана.

114.3. Давж заалдах гомдлын үндэслэлд анхан шатны шүүхээр хэлэлцээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй.

114.4. Давж заалдах гомдлыг тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх хүлээн авч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэрэгт хавсаргаж болно.

114.5. Энэ хуулийн 114.2-т заасан шүүх нь давж заалдах гомдолд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган хэргийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд гурван, орон нутагт долоо хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.

114.6. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 114.1-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт анхан шатны шүүхэд гаргах бөгөөд уг хүсэлтийг хангах эсэхийг шүүгч тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг хянаж, захирамж гарган шийдвэрлэнэ.

114.7. Хуульд өөрөөр заагаагүй бол давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэхээр хуулиар тусгайлан харьяалуулсан гомдол гаргах, уг гомдлыг хүлээн авахад энэ хуульд заасан журмыг баримтлана.

## **115 дугаар зүйл. Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга**

115.1. Давж заалдах гомдлыг бичгээр гаргана.

115.2. Давж заалдах гомдолд дараахь зүйлийг тусгана:

115.2.1. гомдлыг ямар шүүхэд гаргаж байгаа;

115.2.2. гомдол гаргагч этгээдийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын болон цахим хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, цахим хаяг, оршин байгаа газрын хаяг, утас, факсын дугаар;

115.2.3. аль шүүхийн ямар шийдвэрийг давж заалдаж байгаа;

115.2.4. шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл ямар үндэслэл, заалтыг зөвшөөрөхгүй байгаа;

115.2.5. гомдлын шаардлага.



115.3. Давж заалдах гомдолд гомдол гаргасан этгээд, хуулийн этгээд гаргасан бол байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээд, албан тушаалтан гарын үсэг зурж, байгууллагын тамгыг дарсан байна.

115.4. Давж заалдах гомдол гаргаж байгаа этгээд энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан журмаар улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлж, баримтыг гомдолд хавсаргах бөгөөд гомдлыг хэргийн оролцогчийн тоогоор хувилан өгнө.

115.5. Гомдол гаргах эрхгүй этгээдийн гаргасан давж заалдах гомдлыг шүүх буцаана.

### **116 дугаар зүйл. Давж заалдах гомдлоос татгалзах**

116.1. Давж заалдах гомдол гаргасан этгээд шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд давж заалдах гомдлоосоо татгалзах эрхтэй.

116.2. Давж заалдах гомдол гаргасан этгээд шүүх хуралдаан эхлэхээс өмнө гомдлоосоо татгалзвал түүнийг гомдол гаргаагүйд тооцож, шүүгч захирамж, харин шүүх хуралдааны явцад татгалзвал давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг хэрэгсэхгүй болгож, шүүх тогтоол гаргана. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгоно.

116.3. Энэ хуулийн 66-68 дугаар зүйлд заасан нөхцөл байдал шүүх хуралдаан эхлэхээс өмнө илэрвэл шүүгч захирамж, шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх явцад илэрвэл шүүх тогтоол гарган анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

### **117 дугаар зүйл. Шүүх хуралдаанд оролцох**

117.1. Давж заалдах шатны шүүх хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид давж заалдах шатны шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэж, тэдгээрийн шүүх хуралдаанд оролцох эрхийг хангах үүрэгтэй.

117.2. Энэ хуулийн 117.1-д зааснаар шүүх хуралдааны товыг мэдэгдсэн боловч шүүх хуралдаанд ирээгүй нь давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

### **118 дугаар зүйл. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх**

118.1. Давж заалдах гомдол гарсан хэргийг давж заалдах шатны шүүх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.



118.2.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг шүүгчдийн зөвлөгөөнөөс томилогдсон шүүгч даргална.

118.3.Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдлын хүрээнд хянах ба хэргийн хоёр, түүнээс дээш оролцогч гомдол гаргасан, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гомдол гаргасан тохиолдолд хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй.

118.4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн бол гомдлоор хязгаарлахгүй.

118.5.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд тухайн хэргийг хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан шүүгч нь хэргийн талаар илтгэж танилцуулна.

118.6.Шүүх хуралдааны дэг нь илтгэгч шүүгчээс хэргийн талаар танилцуулах хүртэл энэ хуулийн 89, 90, 94, 96.1-д заасан журмаар зохицуулагдана.

118.7.Илтгэгч шүүгчээс нэхэмжлэлийн шаардлага, анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулга, давж заалдах гомдлын үндэслэлийг танилцуулж, гомдол гаргагч болон хэргийн бусад оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн давж заалдах гомдолтой холбоотой тайлбарыг сонсон шүүх бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзвэл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс асууж, тодруулсны дараа нэмэлт тайлбарыг сонсож, шүүх хуралдаан завсарлан шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орно.

### **119 дүгээр зүйл.Шүүхийн магадлал**

119.1.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлалд анхан шатны шүүхийн шийдвэрийн болон давж заалдах гомдлын агуулга, давж заалдах шатны шүүхээс гаргаж байгаа шийдвэр, түүний үндэслэл тусгагдсан байна.

119.2.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргана.

119.3.Магадлалыг шүүх хуралдааны оролцогчдод танилцуулан сонсгосноор хүчинтэй болно.

119.4.Магадлал хүчинтэй болсноос хойш 14 хоногийн дотор магадлалын агуулгыг бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Магадлалыг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч,



өмгөөлөгч энэ хуулийн 108.4-т заасны дагуу гардан авах, эсхүл шүүх энэ хуулийн 108.6-д заасны дагуу хүргүүлнэ.

119.5.Магадлалд энэ хуулийн 123.2-т заасан үндэслэлээр хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 119.4-т заасны дагуу магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хяналтын журмаар гомдол гаргаж болно.

119.6.Энэ хуулийн 119.5-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ.

### **120 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх болон өөрчлөх**

120.1. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэр хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл уг шийдвэрийг хэвээр үлдээнэ.

120.2. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг зөв гэж үзсэн хууль зүйн үндэслэлээ магадлалд заах үүрэгтэй.

120.3. Анхан шатны шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн, эсхүл хууль буруу хэрэглэсэн бол давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь өөрчлөх эрхтэй.

### **121 дүгээр зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох**

121.1. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон бол дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

121.1.1. нэхэмжлэлийг хангасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

121.1.2. нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон анхан шатын шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсэг, эсхүл бүхэлд нь хангах;

121.1.3. анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах;



121.1.4.шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах.

121.2.Хэрэг хянан шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт цугларсан, шүүх хуралдаан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдсан боловч шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн, эсхүл хуулийг буруу хэрэглэсэн бол давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх энэ хуулийн 121.1.1, 121.1.2-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

121.3.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх дараахь үндэслэл илэрвэл энэ хуулийн 121.1.4-т заасан шийдвэрийг гаргана:

121.3.1.анхан шатны шүүх хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг нь хангалгүй хэргийг шийдвэрлэсэн;

121.3.2.хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн;

121.3.3.анхан шатны шүүх энэ хуулийг зөрчсөн нь шүүхийн шийдвэр гаргахад нөлөөлсөн байвал;

121.3.4.шүүх шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн, эсхүл хуулийн шаардлага хангаагүй болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдээгүй нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон;

121.3.5.шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй;

121.3.6.шүүхийн шийдвэрт шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан;

121.3.7.шүүх нэхэмжлэлийн болон гуравдагч этгээдийн бие даасан шаардлага, түүний зарим хэсэгт нь дүгнэлт өгөөгүй, эсхүл шийдвэрлэлгүй орхигдуулсан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол.

## **122 дугаар зүйл.Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах**

122.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 14.6, 32.6, 54.2, 61.1, 65.1, 111.3, 119.6, 123.7 дахь хэсэгт заасан болон гуравдагч этгээдийг оролцуулахаас татгалзсан тухай шүүгчийн



захирамж, шүүхийн тогтоолд бичгээр гарсан өдрөөс нь хойш долоо хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

122.2.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 122.1-д зааснаас бусад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй.

122.3.Энэ хуулийн 112.1-д заасан хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргасан бол уг гомдлыг тухайн шатны шүүх хянан шийдвэрлэнэ.

122.4.Энэ хуулийн 112.1.3, 112.4-т заасан маргааны хувьд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзснаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахгүй.

122.5.Гомдол гаргаж болох шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд энэ хуульд заасан холбогдох заалтыг бус хуулийн өөр зүйл, заалтыг баримталсан нь тухайн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй.

122.6.Энэ хуулийн 122.1-д заасны дагуу гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор давж заалдах шатны шүүх гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж, дараахь тогтоол гаргана:

122.6.1.шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;

122.6.2.шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг өөрчлөх;

122.6.3.шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгох.

122.7.Энэ хуулийн 122.6-д заасан тогтоол эцсийн шийдвэр байна.

### **АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

#### **123 дугаар зүйл.Хяналтын журмаар гомдол гаргах**

123.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 119 дүгээр зүйлд заасан магадлалд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

123.2.Дараахь үндэслэлээр Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргана:





123.2.1.шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн;

123.2.2.шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн бол.

123.3.Давж заалдах шатны журмаар хэлэлцээгүй хэрэгт хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй.

123.4.Хяналтын журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 48.1-д заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ.

123.5.Хяналтын журмаар гомдол гаргасан этгээд хяналтын шатны шүүх хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзвал түүнийг гомдол гаргаагүйд тооцож, шүүгч захирамж, харин шүүх хуралдааны явцад татгалзвал хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгож, шүүх тогтоол гаргаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгоно.

123.6.Хяналтын журмаар гомдол гаргасны дараа хэргийн оролцогчид эвлэрсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрсөн бол анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

123.7.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 119.5-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт анхан шатны шүүхэд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг шүүгч тухайн хүсэлтэд хавсаргасан баримтын хүрээнд захирамж гарган шийдвэрлэнэ.

#### **124 дүгээр зүйл.Хяналтын журмаар гаргасан гомдол хүлээж авах**

124.1.Хяналтын журмаар гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээж авах бөгөөд энэ хуулийн 114 дүгээр зүйлд заасан ажиллагааг гүйцэтгэнэ. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гомдлын талаар тайлбараа гаргах эрхтэй.

124.2.Гомдол хүлээж авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган гомдлыг хүлээж

авсан өдрөөс хойш нийслэлд гурван хоногийн дотор, орон нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

124.3.Хяналтын журмаар хэрэг хүлээн авсан шүүгч 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэх тухай захирамж гаргана.

124.4.Хяналтын журмаар гаргасан гомдол нь энэ хуульд заасан журмыг баримтлаагүй бол шүүгч гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргана.

124.5.Гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдлыг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж, тогтоол гаргана.

### **125 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа**

125.1.Хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

### **126 дугаар зүйл.Хэргийн оролцогчид мэдэгдэх**

126.1.Хяналтын шатны шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

126.2.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид шүүх хуралдааны товыг мэдэгдсэн боловч шүүх хуралдаанд ирээгүй нь хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

### **127 дугаар зүйл.Хяналтын шатны шүүх хуралдаан**

127.1.Хэргийг хяналтын журмаар Улсын дээд шүүх таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

127.2.Шүүх хяналтын журмаар хэргийг дараахь байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:

127.2.1.шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;

127.2.2.шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулах;

127.2.3.магадлалыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл өөрчлөх;

127.2.4.шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг болон нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг хангах;



127.2.5. шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаах.

127.3. Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын журмаар гаргасан гомдлын болон гаргаж байгаа тогтоолын хуулийн үндэслэлийг тусгаж, шүүх хуралдаан даргалагч, илтгэгч шүүгч гарын үсэг зурна.

### **128 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан**

128.1. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 127.2-т заасан тогтоолыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор хуульд харшилсан гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.

128.2. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч энэ хуулийн 114.4, 114.5, 124.1, 124.2-т заасан журмын дагуу хэргийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Энэ хуулийн 128.1-д заасны дагуу гомдол гаргасан этгээдэд энэ хуулийн 48.1, 48.3-т заасан журам хамаарахгүй.

128.3. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэлгүй гэж үзвэл 30 хоногийн дотор гомдол гаргагчид бичгээр хариу өгнө.

128.4. Хяналтын шатны шүүхийн шийдвэр гаргахад оролцсон шүүх бүрэлдэхүүний хоёр шүүгч тусгай санал гаргасан, эсхүл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч хуульд харшилсан гэж дүгнэлт гаргасан бол хэргийг 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

128.5. Энэ хуулийн 128.4-т заасан тохиолдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан явуулах тухай шийдвэр гаргаж, хуралдааны тов тогтооно.

128.6. Энэ хуулийн 128.4-т заасан хуралдааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч даргална.

128.7. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс



гадна Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчдийн дөрөвний гурваас доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцогдоно.

**129 дүгээр зүйл. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны шийдвэр**

129.1. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэргийг дараахь байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:

129.1.1. шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, энэ хуулийн 128.4-т заасан санал, дүгнэлтийг хангахгүй орхих;

129.1.2. шийдвэр, магадлал, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах;

129.1.3. магадлал, тогтоолыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл өөрчлөх;

129.1.4. тогтоолыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, магадлал, шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл өөрчлөх;

129.1.5. шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг болон нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох;

129.1.6. шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхэд буцаах.

129.2. Энэ хуулийн 129.1-д заасан шүүхийн тогтоол танилцуулан сонсгомогц хуулийн хүчин төгөлдөр болно.

129.3. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байна.

**130 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын алдааг засварлах**

130.1. Анхан шатны шүүхийн шийдвэр болон магадлал, тогтоолд үг, үсэг, тооны зэрэг илэрхий алдаа байгаа бол тухайн шийдвэрийг гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүн залруулга хийж болно.



**АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС  
ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ДАХИН ХЯНАХ**

**131 дүгээр зүйл. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас  
шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл**

131.1. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараахь үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно:

131.1.1. Шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй болон мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрсэн;

131.1.2. Шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт хуурамч, эсхүл шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хэргийн оролцогчийн хэргийг хянан шийдвэрлэх үед гаргасан үйлдэл /эс үйлдэхүй/ гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;

131.1.3. Шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол болон шийдвэр, эсхүл захиргааны болон бусад байгууллагын шийдвэр нь хууль бус байсны улмаас хүчингүй болсон;

131.1.4. Гуравдагч этгээдийг татан оролцуулалгүйгээр шүүхээс хэргийг хянан шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтойгоор нөлөөлсөн.

**132 дугаар зүйл. Шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах**

132.1. Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг хянуулах үндэслэл байгааг мэдсэнээс хойш 30 хоногийн дотор хэргийн оролцогч, төлөөлөгч, өмгөөлөгч уг шийдвэрт давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргаагүй бол анхан шатны, гомдол гаргасан бол тухайн шатны шүүхэд гаргана.

132.2. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө энэ хуулийн 131.1-д заасан үндэслэл шинээр илэрсэн бол шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 132.1-д заасан хүсэлтийг гаргаж болно.

132.3. Захиргааны актыг түдгэлзүүлэн шийдвэрлэсэн бол шинэ захиргааны акт гарснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 132.1-д заасан хүсэлтийг гаргаж болно.

132.4. Хүсэлтийг бичгээр гаргаж түүнд шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх баримтыг хавсаргана.



132.5.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө хүсэлтээсээ татгалзвал түүнийг хүсэлт гаргаагүйд тооцно.

### **133 дугаар зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх**

133.1.Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан журмын дагуу тухайн шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

133.2.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянахад анхан шатны шүүхийн шийдвэр гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүн дахин оролцохгүй.

133.3.Хүсэлт гаргасан этгээд шүүх хуралдаанд оролцохыг хүсвэл түүнд мэдэгдэх ба хүсэлт гаргасан этгээд хүрэлцэн ирээгүй нь хүсэлтийг шийдвэрлэхэд саад болохгүй.

133.4.Шүүх хуралдаанаар шинээр илэрсэн нөхцөл байдлыг баталж байгаа шинэ нотлох баримтыг үндэслэн шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоох, уг нөхцөл байдал нь шийдвэрийг гаргахад хэрхэн нөлөөлсөн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянан шийдвэрлэх хууль ёсны үндэслэл байгаа эсэхийг шийдвэрлэнэ.

133.5.Шүүх хүсэлтийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлээд түүнийг хангах, эсхүл хангахаас татгалзах тухай тогтоол гаргана.

133.6.Шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоосон нөхцөлд шүүхийн урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

### **134 дүгээр зүйл.Биелэгдсэн шийдвэрийг цуцлах**

134.1.Биелэгдсэн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянан шийдвэрлэсэн шүүх хүчингүй болгож байгаа бол биелэгдсэн шийдвэрийг цуцлах тухай асуудлыг тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ.

## **АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ**

### **135 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх**

135.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн<sup>8</sup> дагуу явуулна.

<sup>8</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.



### **136 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл**

136.1.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна.

### **АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **137 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

137.1.Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараахь шийтгэлийг шүүгч зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд оногдуулна:

137.1.1.энэ хуулийн 32.2-т зааснаар шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

137.1.2.энэ хуулийн 57.2-т заасан хугацаанд хариу тайлбараа гаргаж өгөөгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

137.1.3.энэ хуулийн 59.10-т зааснаар шүүхэд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

137.2.Шүүхийн шийдвэрийг биелүүлэлгүй хоёр, түүнээс дээш удаа торгох шийтгэл авагдсан хариуцагчид шүүгч Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан сахилгын шийтгэлийг оногдуулах мэдэгдлээ эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

137.3.Энэ хуулийн 137.2-т заасан мэдэгдлийг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан, байгууллага мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуульд заасан сахилгын шийтгэлийг шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд оногдуулж, энэ тухай шүүхэд мэдээлнэ.

### **138 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

138.1.Энэ хуулийг 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийтийн сонсголын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.1, 18.2, 18.3-т” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.1, 19.2, 19.3-т” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46.1.3-т” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.1.3-т” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх





тухай хуулиар” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46.1.3-т” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.1.3-т” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН  
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.1.13 дахь заалт нэмсүгэй:

“41.1.13.захиргааны хэргийн шүүхэд хандаж нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн гаргасан нэхэмжлэл.”



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Арав<sup>1</sup> дүгээр бүлэг нэмсүгэй:

**“АРАВ<sup>1</sup> ДҮГЭЭР БҮЛЭГ  
Захиргааны хэргийн талаарх шүүхийн  
шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

**79<sup>1</sup> дүгээр зүйл.Захиргааны хэргийн шүүхийн  
шийдвэрийг биелүүлэх**

79<sup>1</sup>.1.Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр /шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр/-ийг хэргийн оролцогч, эрх залгамжлагч заавал биелүүлэх үүрэгтэй.

79<sup>1</sup>.2.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд энэ бүлэгт заасан журмын дагуу албадан гүйцэтгэнэ.

79<sup>1</sup>.3.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагааг энэ хуулийн дагуу явуулна.

79<sup>1</sup>.4.Захиргааны байгууллагын шийдвэрийг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

**79<sup>2</sup> дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

79<sup>2</sup>.1.Дараахь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ:

79<sup>2</sup>.1.1.хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр;

79<sup>2</sup>.1.2.захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүчин төгөлдөр болсон шүүгчийн захирамж;



79<sup>2</sup>.1.3.хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол;

79<sup>2</sup>.1.4.шүүхийн зардал тогтоосон шүүгчийн захирамж;

79<sup>2</sup>.1.5.шүүгчийн шийтгэвэр;

79<sup>2</sup>.1.6.хуульд заасан бусад.

79<sup>2</sup>.2.Дараахь тохиолдолд шүүхийн шийдвэрийг даруй гүйцэтгэнэ:

79<sup>2</sup>.2.1.төрийн албан хаагчийг ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоохоор шийдвэрлэсэн;

79<sup>2</sup>.2.2.ажил, албан тушаалаас буруу халсан, эсхүл шилжүүлсэн үеийн олговор олгуулах тухай шийдвэр гаргасан;

79<sup>2</sup>.2.3.захиргааны актыг түдгэлзүүлэх тухай шүүгчийн захирамж хүчин төгөлдөр болсон;

79<sup>2</sup>.2.4.шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацаанаас хамаарч иргэн, хуулийн этгээдэд ноцтой хохирол учирахаар бол түүний хүсэлтээр;

79<sup>2</sup>.2.5.хуульд заасан бусад тохиолдолд.

79<sup>2</sup>.3.Хэргийн оролцогч хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхэд гаргана.

79<sup>2</sup>.4.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна.

79<sup>2</sup>.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн анхан шатны шүүх хяналт тавина.

### **79<sup>3</sup> дугаар зүйл.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа**

79<sup>3</sup>.1.Шүүхийн шийдвэрийг дараахь тохиолдолд албадан гүйцэтгүүлэхээр шүүгч захирамж гаргана:

79<sup>3</sup>.1.1.шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан;

79<sup>3</sup>.1.2.шүүгч шийдвэрийг даруй биелүүлэх шаардлагатай гэж үзсэн.



79<sup>3</sup>.2.Гүйцэтгэх хуудаст дараахь зүйлийг тусгана:

79<sup>3</sup>.2.1.гүйцэтгэх хуудас олгосон шүүхийн нэр;

79<sup>3</sup>.2.2.гүйцэтгэх хуудас бичсэн шүүгчийн нэр, олгосон он, сар, өдөр;

79<sup>3</sup>.2.3.гүйцэтгэх хуудас олгож байгаа шийдвэрийн он, сар, өдөр, дугаар;

79<sup>3</sup>.2.4.шийдвэрийг гүйцэтгэвэл зохих этгээдийн нэр, хаяг, албан тушаал;

79<sup>3</sup>.2.5.шийдвэрийг гүйцэтгэх арга, журам, хугацаа;

79<sup>3</sup>.2.6.шийдвэрээр эрх, хууль ёсны ашиг нь хамгаалагдсан этгээдийн нэр, хаяг.

79<sup>3</sup>.3.Гүйцэтгэх хуудсанд шүүгч гарын үсэг зурж, тамга дарна.

79<sup>3</sup>.4.Гүйцэтгэх хуудсыг бичсэний дараа шүүгч шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг 30 хүртэл хоногоор тогтоож, энэ тухай мэдэгдэл гаргана. Шүүхийн мэдэгдэлд энэ хуулийн 79<sup>3</sup>.2-т зааснаас гадна албадан гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх хугацаа, тогтоосон хугацааны дотор шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд авах албадлагын арга хэмжээ болон оногдуулах хариуцлагын талаар тусгана.

79<sup>3</sup>.5.Гүйцэтгэх хуудас бичигдсэнээс хойш гурван хоногийн дотор шүүгчийн туслах шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудас, шүүхийн мэдэгдэл, шаардлагатай бусад баримт бичгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, мэдэгдлийг шийдвэрийг гүйцэтгэвэл зохих этгээдэд хүргүүлнэ.

79<sup>3</sup>.6.Гүйцэтгэх хуудсыг хүлээн авсан шийдвэр гүйцэтгэх байгууллага түүнийг үл маргалдах журмаар биелүүлнэ.

79<sup>3</sup>.7.Шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа дуусмагц шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэрийг холбогдох этгээд тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлээгүй бол гурван хоногийн дотор албадлагын арга хэмжээ авахуулахаар хүсэлтийг шүүхэд хүргүүлнэ.

#### **79<sup>4</sup> дүгээр зүйл.Албадлагын арга хэмжээ**

79<sup>4</sup>.1.Шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш гурван хоногийн дотор шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй шалтгааныг судлаж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний



төгрөгөөр торгох шийтгэл оногдуулах шийтгэвэр гарган шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.

79<sup>4</sup>.2.Хариуцагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй нь тогтоогдвол шүүгч биелүүлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.

79<sup>4</sup>.3.Энэ хуулийн 79<sup>4</sup>.1.-д заасан шүүгчийн шийтгэврийг шийдвэр гүйцэтгэгч хүлээн авсан даруйд хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх хэсэг нэмсүгэй:

“9.Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний акт Захиргааны ерөнхий хуулийн 67.1, 67.2-т заасан журмын дагуу хүчин төгөлдөр болно.”

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Монгол Улсын Үндсэн хууль,” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газар нь Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гаргаж болно. Энэ эрхийн акт нь тогтоол хэлбэрээр байна.” гэсэн 3, 4 дэх өгүүлбэрийг “Засгийн газар хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний акт гаргаж болох бөгөөд тогтоол хэлбэртэй байна.” гэж, 5 дахь өгүүлбэрийн “нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тогтоол” гэснийг “захиргааны хэм хэмжээний акт” гэж тус тус өөрчилсүгэй.



**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА  
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн” гэснийг “захиргааны хэм хэмжээний актын” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.3 дахь заалтын “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, 156 дугаар зүйлийн 156.1.1 дэх заалтын “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 4.2-т зааснаас” гэснийг “Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гаалийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.3-т” гэснийг “Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Татварын ерөнхий хуулийн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,” гэснийг “Захиргааны ерөнхий хууль,” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Авлигын эсрэг хууль,” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль,” гэж нэмсүгэй.





**2 дугаар зүйл.**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3, 11.4 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.7, 16.8 дахь хэсгийн “акт” гэснийг “шийдвэр” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,  
АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ,  
ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “тушаалтанд” гэсний дараа “, харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад, эсхүл гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллагад” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн “Хуульд өөрөөр заагаагүй бол гомдлыг зохих дээд шатны нь байгууллага, албан тушаалтанд гаргана.” гэсэн хоёр дахь өгүүлбэрийг “Гомдлыг тухайн захиргааны актыг гаргасан байгууллага, албан тушаалтны дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд, дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргана.” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төсвийн тухай,” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтын “нийтээр дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, журам, норм, нормативыг” гэснийг “захиргааны хэм хэмжээний актыг” гэж, 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалтын “нийтээр дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Засгийн газраас баталсан журмын дагуу” гэснийг “захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

**1/7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт:**

“7.1.13.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;”

**2/8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг:**

“8.5.Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ.”



**2 дугаар зүйл.**Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төсвийн тухай хууль,” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалтын дугаарыг “7.1.14” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт:**

“17.1.9.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;”

#### **2/18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг:**

“18.2.Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ.”

#### **3/30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалт:**

“30.1.16.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;”

#### **4/31 дүгээр зүйлийн 31.1.9 дэх заалт:**

“31.1.9.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны



ерөнхий хуулийн 64.4, 64.5-д заасан журмын дагуу холбогдох байгууллагад хүргүүлэх,”

**2 дугаар зүйл.**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хууль,” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль,” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын з/ дэд заалтын “тогтоомж,” гэсний дараа “Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “тогтоомж” гэсний дараа “, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг” гэж, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “тогтоомж,” гэсний дараа “Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллага,” гэж, мөн зүйлийн 40.3 дахь хэсгийн “Засгийн газар,” гэсний дараа “тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллага,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалтын дугаарыг “17.1.10” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын ж/ дэд заалтын “тогтоомжид” гэснийг “тогтоомж, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрт” гэж, мөн зүйлийн 18.2 дахь хэсгийн дугаарыг “18.3” гэж, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “газрын” гэснийг “газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллагаас гаргасан” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалтын дугаарыг “30.1.17” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1.9 дэх заалтын дугаарыг “31.1.10” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Сонгуулийн тухай хуулийн 115 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 115.8 дахь хэсэг нэмсүгэй:

“115.8.Энэ хуульд заасан маргааны тухайд нэхэмжлэлийг хүлээн авахаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахгүй.”

**2 дугаар зүйл.**Сонгуулийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.4.2 дахь заалтын “Улсын дээд шүүхэд” гэснийг “захиргааны хэргийн



давж заалдах шатны шүүхэд” гэж, 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсгийн “Улсын дээд шүүх анхан болон давж заалдах журмаар” гэснийг “захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар” гэж, 115.6 дахь хэсгийн “Улсын дээд шүүх” гэснийг “захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх” гэж, 115.7 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн” гэснийг “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24.3.8.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлэх асуудлыг;”

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалтын “Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын” гэснийг “Тогтвортой хөгжлийн зорилгын” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АРД НИЙТИЙН САНАЛ  
АСУУЛГЫН ТУХАЙ**  
/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.**Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь ард нийтийн санал асуулга /цаашид “санал асуулга” гэх/ явуулах зарчим, журмыг тодорхойлж, санал асуулгыг

бэлтгэн зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## **2 дугаар зүйл. Санал асуулгын тухай хууль тогтоомж**

2.1. Ард нийтийн санал асуулгын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Сонгуулийн тухай хууль<sup>2</sup>, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль<sup>3</sup>, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль<sup>4</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

## **3 дугаар зүйл. Санал асуулгын зарчим**

3.1. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ.

3.2. Санал асуулга бүх нийтийн байх бөгөөд түүнд Монгол Улсын 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн бүр оролцох эрхтэй.

3.3. Иргэн санал асуулгад ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргана.

3.4. Санал асуулга нь чөлөөтэй байх бөгөөд иргэнээс санал асуулгад оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.

3.5. Иргэн хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа гаргах боломжоор хангагдсан байна.

3.6. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах, тоолох, зохион байгуулахтай холбогдсон журмыг энэ хууль болон Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн сонгуулийн төв байгууллага болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

3.7. Иргэн саналаа нууцаар гаргана.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Сонгуулийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 4 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Сонгуулийн төв байгууллагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 5 дугаарт нийтлэгдсэн.



#### **4 дүгээр зүйл.Санал асуулгаар шийдвэрлэх асуудал**

4.1.Төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлохтой холбогдсон тодорхой асуудлаар сонголт хийлгэх шаардлага гарсан тохиолдолд санал асуулга явуулна.

4.2.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал асуулга явуулж болно.

4.3.Ард нийтийн санал асуулгыг нэг удаад гурваас дээшгүй асуудлаар явуулах бөгөөд санал асуулга явуулах асуултын тоо, агуулгыг Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэнэ.

#### **5 дугаар зүйл.Санал асуулгыг санаачлах эрх бүхий этгээд**

5.1.Ард нийтийн санал асуулга явуулахыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь санаачлах эрхтэй.

5.2.Иргэд санал асуулга явуулах тухай саналаа Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүнд уламжлах бөгөөд энэ саналд санал асуулга явуулах болсон үндэслэл, тооцоо, холбогдох бусад баримт бичгийг хавсаргана.

#### **6 дугаар зүйл.Санал асуулга явуулах шийдвэр гаргах**

6.1.Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар санал асуулга явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

6.2.Санал асуулгаар шийдвэрлэх асуудлын агуулгыг илэрхийлсэн асуулт, түүнд өгөх эсрэг утга бүхий хариултын хувилбарыг Улсын Их Хурал хэлэлцэж батална.

6.3.Санал асуулгын асуулт, хариултыг хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгомжтой томъёолсон байна.

#### **7 дугаар зүйл.Санал асуулгыг товлон зарлах**

7.1.Санал асуулга явуулах тухай шийдвэрт санал асуулга явуулах өдрийг уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 21-ээс 45 хоногийн дотор явуулахаар Улсын Их Хурал товлон зарлана.

7.2.Гадаад улсад байгаа иргэдээс ард нийтийн санал авах өдрийг Улсын Их Хурал тогтооно.

7.3.Онцгой нөхцөл бий болсны улмаас санал асуулга явуулах боломжгүй болсон бол санал асуулга явуулахаар шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага санал асуулгыг хойшлуулна.



7.4.Энэ хуулийн 7.3-т зааснаар ард нийтийн санал асуулгыг хойшлуулсан онцгой нөхцөл арилсны дараа 30 хоногт багтаан санал асуулга явуулах өдрийг товлон зарлана.

7.5.Санал асуулгаар тавигдаж байгаа асуудлаар ард нийтэд таниулах, мэдээллээр хангах асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газар болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар хариуцна.

7.6.Улс төрийн нам, төрийн бус байгууллага сонгуулийн төв байгууллагаас баталсан журмын дагуу ухуулга сурталчилгааг өөрийн зардлаар явуулж болно.

7.7.Санал асуулгыг Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай хамтатган явуулах бол Сонгуулийн тухай хуульд заасны дагуу санал асуулгыг санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө товлон зарлана.

## **8 дугаар зүйл.Санал асуулга явуулахтай холбогдсон зардал**

8.1.Санал асуулга явуулахтай холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

8.2.Санал асуулга явуулахтай холбогдсон зардлын төрөл нь Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан зардал байна.

8.3.Санал асуулгын зардлын хэмжээг Улсын Их Хурал батална.

8.4.Зардлын хэмжээг батлахдаа улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан хүн амын тоонд харгалзан тооцсон сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэнэ.

8.5.Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан хэсгийн хороодын ажиллах болон санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө.

8.6.Хэсгийн хороодыг ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна.

8.7.Энэ хуулийн 8.1-д заасан зардлын гүйцэтгэлд төрийн аудитын дээд болон орон нутгийн аудитын байгууллага аудит хийж, дүгнэлт гаргана.





**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
САНАЛ АСУУЛГА ЯВУУЛАХ НУТАГ ДЭВСГЭР,  
СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТ, БҮРЭН ЭРХ**

**9 дүгээр зүйл. Санал асуулга явуулах нутаг  
дэвсгэрийн хуваарь**

9.1. Ард нийтийн санал асуулга явуулах нутаг дэвсгэр нь Монгол Улсын нутаг дэвсгэр байна.

9.2. Иргэдийн санал авах зорилгоор санал асуулга явуулах нутаг дэвсгэрийг хэсэгт хуваана.

**10 дугаар зүйл. Хэсэг, түүнийг байгуулах**

10.1. Санал асуулгыг Улсын Их Хурлын эсхүл, Ерөнхийлөгчийн сонгуультай хамтатган явуулж байгаа бол сонгуулийн санал авах хэсэг нь санал асуулгын санал авах хэсэгтэй нэг байна.

10.2. Санал асуулгыг дангаар явуулж байгаа бол иргэдээс санал авч тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугчдын байнга оршин суугаа газрын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн хэсгийг санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана.

10.3. Нэг хэсэг нь суманд 2000-аас, аймгийн төвд 2500-аас, нийслэлийн дүүрэгт 3000-аас дээшгүй санал өгөх иргэнтэй байх бөгөөд нэг хэсэгт байх санал өгөх иргэний тоо 200-аас доошгүй байна.

10.4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид энэ хуулийн 10.1-д заасны дагуу байгуулсан хэсгийн мэдээллийг аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн байгууллагад нэн даруй хүргүүлэх бөгөөд аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн байгууллага нь хүлээн авсан мэдээллийг аймаг, дүүрэг тус бүрийн хэмжээнд нэгтгэн тав хоногт улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

10.5. Энэ хуулийн 10.4-т заасан мэдээллийг үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэсгийн дугаарыг тухайн аймаг, дүүргийн хэмжээнд давхардахгүй байхаар тав хоногийн дотор тогтооно.



### **11 дүгээр зүйл.Санал асуулгыг эрхлэн явуулах байгууллага, түүний зохион байгуулалт**

11.1.Санал асуулга явуулах ажлын бэлтгэлийг улсын хэмжээнд сонгуулийн төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг даргын Тамгын газар /цаашид “Засаг даргын Тамгын газар” гэх/, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд сонгуулийн хэсгийн хороод /цаашид “хэсгийн хороо” гэх/ тус тус эрхлэн зохион байгуулна.

11.2.Энэ хуулийн 10.5-д заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэсгийн дугаарыг тогтоосноос хойш сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хэсгийн хороог дарга, нарийн бичгийн дарга, тав хүртэл гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр тав хоногт багтаан байгуулна.

11.3.Санал асуулгыг Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн сонгуультай хамт явуулах бол Сонгуулийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн байгууллага эрхлэн явуулна.

### **12 дугаар зүйл.Сонгуулийн хороодын зохион байгуулалт бүрэн эрх**

12.1.Сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрхтэй холбогдох харилцаанд Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд заасан журмыг баримтлана.

12.2.Тухайн шатны Засаг даргын Тамгын газар болон хэсгийн хороод санал асуулга явуулахад Сонгуулийн тухай хуулийн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны болон сонгуулийн хэсэг дэх нэгж санал авахтай холбогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭДИЙН НЭРИЙН ЖАГСААЛТ**

### **13 дугаар зүйл.Иргэдийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах**

13.1.Санал асуулгад оролцох иргэдийн нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангана.

13.2.Иргэдийн нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг Сонгуулийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд энэ хуульд заасан хугацааг баримтлан шийдвэрлэнэ.



## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНАЛ АВАХ, ТООЛОХ**

### **14 дүгээр зүйл.Санал авах газар, хугацаа**

14.1.Иргэдээс санал авах газар, хугацаатай холбогдох харилцаанд Сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.

### **15 дугаар зүйл.Санал асуулгын хуудас**

15.1.Санал асуулгын хуудас /цаашид “саналын хуудас” гэх/ нь иргэнээс саналаа илэрхийлэх, санал асуулгын дүнг гаргах үндсэн баримт бичиг мөн бөгөөд дараахь шаардлагыг хангасан байна:

15.1.1.санал асуулга явуулах саналын хуудсанд санал асуулгаар шийдвэрлэх асуудлын агуулгыг илэрхийлсэн асуултыг түүнд өгөх эсрэг утга бүхий хариултын хувилбарын хамт Улсын Их Хурлаас баталсан томъёоллоор хэвлэх;

15.1.2.тусгай нууцлалтай, индекс, дугаартай байх.

15.2.Сонгуулийн төв байгууллага саналын хуудасны тоо, загвар болон саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмыг батална.

15.3.Санал асуулгын саналын хуудсыг хэвлүүлэх, хэсгийн хороодод санал асуулга явуулах өдрөөс хоёроос доошгүй хоногийн өмнө хүргүүлэх ажлыг сонгуулийн төв байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна.

### **16 дугаар зүйл.Санал авах ажиллагаа**

16.1.Санал асуулга явуулах өдрийн 07.00 цагт хэсгийн хорооны бүрэлдэхүүн иргэний төлөөлөл, ажиглагчийг байлцуулан дараахь ажиллагааг доор дурдсан дарааллын дагуу гүйцэтгэнэ:

16.1.1.тухайн хэсгийн иргэдийн нэрийн жагсаалтад бичигдсэн нийт иргэний тоо, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн иргэний тоог зарлах;

16.1.2.саналын хуудасны индекс, дугаарыг зарлах;

16.1.3.хүлээн авсан, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад зарцуулсан, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад иргэн саналаа буруу тэмдэглэсэн үндэслэлээр энэ хуульд заасны дагуу дахин нэг саналын хуудас авч



саналаа гаргасны улмаас хүчингүй болгосон, түүнчлэн алдагдаж үрэгдсэн, утсан, үлдсэн саналын хуудасны тоог мэдээлэх;

16.1.4.зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаас бусад санал авах бүх хайрцгийг нээж харуулах, санал авах хайрцгийг битүүмжлэх, лацдах, санал авахад бэлэн болгох.

16.2.Хэсгийн хороо энэ хуулийн 16.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсэн тухай тэмдэглэл хөтөлж, уг тэмдэглэлд бүртгэлийн хуудсыг хавсарган хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга болон бүх гишүүн гарын үсэг зурна.

16.3.Санал асуулгад оролцохоор ирсэн иргэн санал авах байранд ажиллах иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд иргэний үнэмлэх, биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өө шалгуулах бөгөөд иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан тухайн иргэний мэдээллийг системээс шалгаж зөрчилгүй бол бүртгэлийн хуудас олгоно.

16.4.Бүртгэлийн хуудас авсан иргэн уг бүртгэлийн хуудсаа иргэний үнэмлэхийн хамт хэсгийн хорооны гишүүнд шалгуулж саналын хуудас авна.

16.5.Санал асуулга явуулах ажиллагаанд ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.

### **17 дугаар зүйл.Санал асуулгыг ажиглах**

17.1.Санал асуулгыг иргэний төлөөлөл болон олон улсын байгууллага, гадаад улсын иргэн, гадаад улсын болон дотоодын байгууллага ажиглаж болно.

17.2.Санал асуулгыг ажиглах, сурвалжлах журмыг сонгуулийн төв байгууллага батална.

### **18 дугаар зүйл.Санал өгөх**

18.1.Иргэн санал авах байранд өөрийн биеэр ирж, саналаа өгнө.

18.2.Иргэн саналын хуудсанд бичигдсэн асуулттай танилцсаны үндсэн дээр эсрэг утга бүхий хариултын аль нэгийн өмнөх дугаарыг сонгож, саналаа тэмдэглэнэ.

18.3.Иргэн санал тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа саналын хайрцагт хийхээс өмнө энэ тухайгаа



хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч саналаа өгч болно.

18.4.Хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй иргэн өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болох ба сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтан, ажиглагч нь итгэмжлэгдсэн хүн байж болохгүй.

18.5.Санал асуулга явуулахад сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах эсэхийг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

18.6.Иргэний саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах журмыг сонгуулийн төв байгууллага батална.

## **ТАВДУГААР БҮЛЭГ САНАЛ ТООЛОХ, ДҮН ГАРГАХ**

### **19 дүгээр зүйл.Санал тоолох**

19.1.Хэсэгт санал тоолох ажиллагааг санал асуулга явуулах өдрийн 22.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын болон иргэний төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.

19.2.Хэсгийн хороо санал тоолох бэлтгэл хангагдмагц тухайн хэсгийн хорооны дарга санал тоолох тухай зарлах ба санал тоолох ажиллагааг гүйцэтгэхээс өмнө дараахь ажиллагааг хийн тэмдэглэл үйлдэнэ:

19.2.1.санал авах байранд болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн иргэний тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах;

19.2.2.санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган боож битүүмжлэх.

19.3.Хэсгийн хороо энэ хуулийн 19.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа асуултын хариулт бүрд өгсөн саналын тоог хэсгийн хэмжээгээр нэгтгэн тоолж дүнг гаргана.

19.4.Санал асуулгын саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүн мэдээ нь тухайн хэсгийн санал асуулгын дүн байна. Санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнг хэвлэж авсны дараа сонгуулийн төв байгууллагын дэргэдэх Мэдээллийн



технологийн төвд нэн даруй дамжуулна. Санал асуулгын саналыг гар аргаар тоолж, дүнг гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох журмыг сонгуулийн төв байгууллага батална.

19.5.Иргэн аль ч асуултын хариултад санал өгөөгүй бол аль ч асуудлыг дэмжээгүй санал гэж үзэн тухайн иргэнийг санал өгсөн иргэний тоонд оруулан тоолох ба энэ тохиолдолд уг саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаcт тооцно.

19.6.Санал авахад зарцуулсан болон зарцуулаагүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хороо хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл хэсгийн хороо шалтгааныг шалгаж тогтоох бөгөөд шаардлагатай гэж үзвэл саналын хуудсыг нэн даруй дахин тоолно.

19.7.Хэсгийн хороо энэ хуулийн 19.6-д заасан ажиллагааг гүйцэтгэхдээ зөвхөн саналын хуудсыг тоолно.

19.8.Санал тоолох цаг болоогүй байхад саналыг тоолох, түүнчлэн санал тоолох ажиллагааг завсарлахыг хориглоно.

19.9.Хэсгийн хороо тухайн хэсгийн санал асуулгын дүнг уншиж сонсгосны дараа, санал асуулгын дүнг нэгтгэсэн тэмдэглэлд хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, нэг хувийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус нэн даруй хүргүүлнэ.

19.10.Хэсгийн хороо саналын хайрцгаас гарсан саналын хуудас болон энэ хуульд заасны дагуу хураагдсан саналын хуудсыг тус тусад нь багцлан боож битүүмжлэн, сонгуулийн бусад баримт бичгийн хамт сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тав хоногт хүргүүлнэ.

19.11.Саналын хуудасны мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор энэ хуулийн 19.10-т заасны дагуу битүүмжилсэн саналын хуудасны битүүмжлэлийг задлахгүйгээр холбогдох журамд заасны дагуу аймаг, нийслэлийн архивт хадгална.

## **20 дугаар зүйл.Санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох**

20.1.Баталсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.



20.2.Эсрэг утга бүхий хариултын хоёуланг нь тэмдэглэсэн саналыг хүчингүйд тооцно.

20.3.Иргэний санал хүчингүй болсон нь саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.

### **21 дүгээр зүйл.Санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураах**

21.1.Хэсэгт явагдсан санал хураалтыг доор дурдсан тохиолдолд хүчингүйд тооцно:

21.1.1.гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар авснаас бусад тохиолдолд санал авахаар зарласнаас өөр өдөр санал авсан;

21.1.2.санал авсан саналын хайрцаг болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан үндэслэлээр сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцно.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасны дагуу хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцвол энэ тухай шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор дахин санал хураалт явуулна.

21.4.Санал хураалтыг хэсгийн хэмжээгээр хүчингүйд тооцсон бол тухайн хэсгийн нийт иргэнийг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар авсан саналыг хүчингүйд тооцсон бол уг саналын хайрцагт саналаа өгсөн иргэнийг дахин санал хураалтад оролцуулна.

### **22 дугаар зүйл.Санал асуулгын нэгдсэн дүн гаргах, мэдээлэх**

22.1.Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас санал асуулгын дүнг ирүүлснээс хойш хоёр хоногийн дотор сонгуулийн төв байгууллага уг дүнг нэгтгэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

22.2.Улсын Их Хурал санал асуулга хуулийн дагуу явагдсан эсэх талаар санал хураана. Улсын Их Хурлын хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи санал асуулга хуулийн дагуу явагдсан гэж үзвэл уг асуудлыг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэгдсэнд тооцно.

22.3.Санал асуулгад нэрийн жагсаалтад бичигдсэн иргэдийн олонхи оролцоогүй бол дахин санал асуулга явуулахгүй бөгөөд уг санал асуулгыг ард нийт дэмжээгүй гэж үзнэ.

22.4.Санал асуулгаар нэгэнт шийдвэрлэгдсэн асуудлаар таван жилийн дотор, санал асуулгаар шийдвэрлэгдээгүй асуудлаар Улсын Их



Хурал тухайн бүрэн эрхийн хугацаанд, гэхдээ уг санал асуулга явуулснаас хойш хоёр жилийн дотор дахин санал асуулга явуулахгүй.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ  
ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА,  
ГОМДОЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ХАРЬЯАЛАЛ, ЖУРАМ**

**23 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага,  
хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг  
шийдвэрлэх харьяалал**

23.1.Санал асуулгын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, маргаан шийдвэрлэх харьяаллыг Сонгуулийн тухай хуульд зааснаар шийдвэрлэнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН  
ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД  
ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**1995 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталсан Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Ард нийтийн санал асуулгын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17.12 дахь хэсгийн “25 дугаар зүйл, 26





дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэгт заасныг” гэснийг “21 дүгээр зүйлд заасныг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Ард нийтийн санал асуулгын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАРИЛГЫН ТУХАЙ**  
/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Барилгын тухай хууль тогтоомж**

2.1.Барилгын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Газрын тухай хууль<sup>3</sup>, Хот байгуулалтын тухай хууль<sup>4</sup>, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль<sup>5</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Энэ хуулиар зохицуулаагүй барилгын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон бусад харилцааг холбогдох салбарын хуулиар зохицуулна.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Хот байгуулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

### **3 дугаар зүйл.Барилгын салбарт төрийн үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим**

3.1.Барилгын салбарт төрийн үйлчилгээ үзүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

3.1.1.барилгын үйл ажиллагааны зохицуулалт, бүртгэл, зөвшөөрлийг олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулах;

3.1.2.барилгын үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдлыг хангах.

### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, зам гүүр, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;

4.1.2.“барилга байгууламжийг ашиглалтад оруулсан гэрчилгээ” гэж барилга байгууламжийг ашиглалтад оруулсныг баталгаажуулан эрх бүхий байгууллагаас олгох баримт бичгийг;

4.1.3.“барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа” гэж барилга байгууламжийг ашиглалтад оруулж, гэрчилгээ олгосноос хойш захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд барилгын хийц, бүтээц, эдлэхүүн, тоног төхөөрөмж, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны ашиглалтын хэвийн нөхцөлийг хариуцан хангах хугацааг;

4.1.4.“барилга байгууламжийн баримт бичиг” гэж барилгын ажлын зөвшөөрөл олгох, барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай энэ хуульд заасны дагуу боловсруулж, баталгаажуулсан техникийн нөхцөлүүд, зураг төсөл, ил далд ажлын акт, талбайн журнал болон холбогдох бусад баримт бичгийг;

4.1.5.“барилга байгууламжийг засварлах, тоноглох” гэж ашиглалтын хэвийн нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

4.1.6.“барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт” гэж барилга байгууламжийн зураг төсөлд хараат бус, бие даасан, мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргах иргэн, хуулийн этгээдийг;



4.1.7.“барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх” гэж барилга байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн үндсэн бүтээц болон инженерийн шугам сүлжээг өөрчлөх, өргөтгөл, шинэчлэлт хийх үйл ажиллагааг;

4.1.8.“барилга байгууламжийн техникийн нөхцөл” гэж барилга байгууламжийг дулаан, уур, хий, цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа холбоо, дохиолол зэрэг эх үүсвэрт холбох эрх бүхий хуулийн этгээдээс гаргах шийдвэрийг;

4.1.9.“барилга байгууламжийн хамгаалалтын горим” гэж барилгын ажил түр зогсох хугацаанд барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах, барилгын бүрэлдэхүүн хэсгийг эвдэрч гэмтэхээс хамгаалах, барилгын ажлыг үргэлжлүүлэх нөхцөл бүрдүүлэхийг;

4.1.10.“барилга байгууламж шинээр барих” гэж барилга байгууламж барих, эсхүл хуучин барилга байгууламжийг буулгаж барихыг;

4.1.11.“барилгын ажил” гэж бүх төрлийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх талбайг бэлтгэх, бүрдэл хэсгийг угсрах, шинэчлэн барих, буулгах, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

4.1.12.“барилгын ажил гүйцэтгэгч” гэж захиалагчтай гэрээ байгуулсаны үндсэн дээр барилгын ажлыг гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээдийг;

4.1.13.“барилгын ажлын захиалагч” гэж барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгүүлэх сонирхол бүхий иргэн, хуулийн этгээд болон тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг;

4.1.14.“барилгын ажлын талбай” гэж барилгын ажил гүйцэтгэж байгаа газрыг;

4.1.15.“барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл /цаашид “барилгын ажлын зөвшөөрөл” гэх/ гэж энэ хуульд заасны дагуу барилгын ажлыг гүйцэтгэхийг зөвшөөрч, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг;

4.1.16.“барилга байгууламжийн зураг төслийн магадлал” гэж барилга байгууламжийн зураг төсөл, технологи, өргөх байгууламжийн сонголт, хот болон архитектур төлөвлөлт, үндсэн бүтээцийн бат бэхийн шийдэл барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлага, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах хараат бус, бие даасан мэргэжлийн үйл ажиллагааг;



4.1.17. “барилгын материал” гэж стандарт, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан барилга байгууламжид хэрэглэгдэх эрдэс, түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг;

4.1.18. “барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг” гэж барилга байгууламжийн техникийн шаардлагыг агуулсан, заавал болон сонгон мөрдөх, барилгын норм, дүрэм, техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал, стандартыг;

4.1.19. “барилга байгууламжийн техникийн улсын хяналт” гэж барилгын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг тогтоохоор хяналт хэрэгжүүлэх эрх бүхий хуулийн этгээдээс хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.20. “барилгын үйл ажиллагаа” гэж барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг боловсруулах, магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, чанар аюулгүй байдлын шинжилгээ хийх, ашиглалтад оруулж, гэрчилгээжүүлэхийг;

4.1.21. “барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” гэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн<sup>6</sup> 15.14-т заасан барилгын чиглэлээр эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх эрхийг;

4.1.22. “барилгын хөрөнгө оруулагч” гэж барилга байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлсэн иргэн, хуулийн этгээдийг;

4.1.23. “бие даасан эх үүсвэр, шугам сүлжээ” гэж тухайн барилга байгууламжийн хэрэгцээг хангахад зориулан барих ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбоо зэрэг инженерийн хангамжийн шугам сүлжээ, байгууламжийг;

4.1.24. “буулгалтын ажил” гэж ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг ноцтой зөрчиж баригдсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон барилга байгууламжийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буулгах үйл ажиллагааг;

4.1.25. “гадна тохижилтын ажил” гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг;

<sup>6</sup> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



4.1.26.“гүйцэтгэлийн зураг” гэж батлагдсан зураг төслийг зохиогчийн зөвшөөрлөөр өөрчилж, эрх бүхий этгээдийн баталгаажуулсан барилгын ажлын зураг төслийг;

4.1.27.“загвар зураг” гэж барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, эзлэхүүн төлөвлөлт, барилгын нүүр тал /фасад/, өнгөний шийдэл, төлөвлөлтийг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.28.“засварын ажил” гэж барилгын үндсэн хийц, бүтээцийг өөрчлөхгүйгээр барилга байгууламжийг засварлах, түүнд суурилуулсан цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, механик тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг бууруулахгүйгээр ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор элэгдэж хуучирсан, эвдэрсэн тоног төхөөрөмжийг солих зэрэг үйл ажиллагааг;

4.1.29.“зөвлөх үйлчилгээ” гэж барилгын үе шатны ажил гүйцэтгэх, норм, нормативын баримт бичиг боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн сонголт, механик-автоматжуулалт, тохируулга, зүгшрүүлэх, чанар аюулгүй байдлын түвшин, төлөв байдлыг тогтооход шаардлагатай мэргэжил, тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг;

4.1.30.“зураг төсөл” гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

4.1.31.“зураг төсөл зохиогч” гэж барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий хуулийн этгээдийг;

4.1.32.“зураг төсөл зохиогчийн хяналт” гэж барилгын ажил, зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг зохиогчоос хянаж байгаа үйл ажиллагааг;

4.1.33.“инженерийн дэд бүтэц” гэж авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг;

4.1.34.“инженер хайгуулын судалгаа” гэж барилгын ажил гүйцэтгэхээс өмнө тухайн газрын инженер-геологи, геотехник, гидрогеологи, газар хөдлөлт, байгаль, ус цаг уурын нөхцөл, газрын төлөв

байдал, орчны архитектур төлөвлөлт, тохижилт, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээгээр хангах боломжийг тогтоох мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.35. “инженерийн шугам сүлжээ” гэж ус хангамж, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, газрын тос болон төрөл бүрийн хий дамжуулах хоолой, харилцаа холбооны төвлөрсөн байгууламжийг;

4.1.36. “өргөх байгууламж” гэж босоо болон хэвтээ чиглэлд хүн, ачаа өргөх, тээвэрлэх зориулалт бүхий суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг;

4.1.37. “төвлөрсөн бус инженерийн шугам сүлжээ” гэж тодорхой талбай, эсхүл барилга байгууламжид ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбооны үйлчилгээ нийлүүлэх зориулалт бүхий байгууламжийг;

4.1.38. “төвлөрсөн инженерийн шугам сүлжээ” гэж төв суурин газар, түүний тодорхой хэсэгт орших барилга байгууламжийг ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбооны төвлөрсөн эх үүсвэртэй холбох үндсэн байгууламжийг;

4.1.39. “төвөгшил” гэж барилга байгууламжийн бүтээц, технологи, эзлэхүүн төлөвлөлт, инженерийн шийдэл, хийцийн төрлөөс хамаарч зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх төлөв байдлыг;

4.1.40. “тэг тэнхлэг” гэж барилга байгууламжийн үндсэн хэмжээ, түвшинг улсын геодезийн сүлжээнд холбосон газар дээрх тэмдэглэгээг;

4.1.41. “үе шатны ажил” гэж барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах үйл ажиллагаа тус бүрийн технологийн дарааллыг;

4.1.42. “паспортжуулах” гэж ашиглагдаж байгаа барилга байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргаж, баталгаажуулахыг;

4.1.43. “эх загвар зураг /эскиз/” гэж инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулсан барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тохижилт, гудамжны дэлгээсүүд, орчны барилгуудтай уялдсан байдал, эзлэхүүн төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн ерөнхий шийдэл, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, нарны тусгал, барилгын давхрын байгуулалт, огтлол, нүүр тал /фасад/, архитектур, өнгөний шийдэл, үзүүлэлтийг тодорхойлсон баримт бичгийг.



## **5 дугаар зүйл.Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг**

5.1.Барилгын үйл ажиллагааг доор дурдсан норм, нормативын баримт бичгээр зохицуулна:

5.1.1.барилгын норм, дүрэм;

5.1.2.барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал;

5.1.3.стандарт.

5.2.Барилгын үйл ажиллагаанд энэ хуулийн 5.1.1-д заасан барилгын норм, дүрмийг заавал, 5.1.2-т заасан баримт бичгийг сонгож мөрдөнө.

5.3.Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр барилга байгууламжийн техникийн нарийвчилсан нөхцөл, шаардлагыг тогтооно.

5.4.Энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээнд энэ хуулийн 5.1.2, 5.1.3-т заасан баримт бичгийг заавал мөрдөхөөр тусгаж болно.

5.5.Энэ хуулийн 5.1-д заасан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлах, сурталчлах зэрэг үйл ажиллагааны зардлыг улсын төсөв болон Барилга байгууламжийн норм, нормативын сангаас санхүүжүүлнэ.

5.6.Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журмыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.7.Барилга байгууламжийн норм, нормативын сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.7.1.барилга байгууламжийн төсөвт өртгөөс 0.18 хувиар авсан орлого;

5.7.2.норм, нормативын баримт бичгийн борлуулалтын орлого;

5.7.3.норм, нормативыг боловсронгуй болгох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын орлого;

5.7.4.бусад орлого.

5.8.Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг



боловсруулах, судлах, сурталчлах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулна.

5.9.Барилгын материалын үйлдвэрлэлийн болон барилгын үйл ажиллагаанд дагаж мөрдөх стандартыг боловсруулах, батлах, ашиглах, тохирлын гэрчилгээ олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

5.10.Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хэвлэхийг хориглоно.

### **6 дугаар зүйл.Олон улсын техникийн дүрэм, стандарт хүлээн зөвшөөрөх**

6.1.Монгол Улсын барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулаагүй асуудлыг олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартаар зохицуулж болно.

6.2.Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллагын норм, дүрэм, стандартыг энэ хуулийн 6.3-т заасан журмын дагуу бүртгэж, мөрдөнө.

6.3.Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журмыг Засгийн газар батална.

### **7 дугаар зүйл.Нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхол**

7.1.Эрх бүхий байгууллага барилгын ажлын зөвшөөрөл олгохдоо доор дурдсан асуудлыг харгалзан үзнэ:

7.1.1.барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэх иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх, ашиг сонирхол;

7.1.2.иргэн, хуулийн этгээдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллахтай холбогдон үүсэх эрх, ашиг сонирхол;

7.1.3.энэ хууль болон хот байгуулалтын тухай хууль тогтоомжид заасан зарчимд нийцэж байгаа эсэх.

7.2.Нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөх тохиолдолд энэ хуульд заасан шаардлага, үндэслэлийн дагуу





барилгын үйл ажиллагаатай холбоотой хувийн эрх, ашиг сонирхлыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр хязгаарлаж болно.

7.3.Барилгын үйл ажиллагааны явцад гуравдагч этгээдийн ажиллаж, амьдрах орчинг болон барилга байгууламж ашиглах эрхийг нь дордуулахгүйгээр хууль тогтоомжид заасан хэмжээгээр өөрчилж болно.

7.4.Барилга байгууламжийн зураг төсөл, байр зүйн дэвсгэр зураг зэрэг мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн<sup>7</sup> 18.1-д заасан мэдээлэл үүнд хамаарахгүй.

7.5.Барилгын асуудал эрхэлсэн төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих замаар хувийн, нийтийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ.

## **8 дугаар зүйл.Барилгын салбарын даатгал**

8.1.Барилгын үйл ажиллагаанд оролцогч учирч болзошгүй эрсдлийг даатгуулж болно.

8.2.Барилгын үйл ажиллагаанд оролцогчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлыг даатгуулна. Даатгалыг захиалагч, гүйцэтгэгч урьдчилан тохиролцон барилгын ажил гүйцэтгэх гэрээнд тусгана.

8.3.Энэ хуулийн 44.3.2, 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна.

8.4.Барилгын ажлын гүйцэтгэгч тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ БАРИЛГЫН АЖИЛ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ**

### **9 дүгээр зүйл.Барилгын ажлын төрөл**

9.1.Барилгын ажил нь дараахь төрөлтэй байна:

- 9.1.1.барилга байгууламж шинээр барих;
- 9.1.2.барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;
- 9.1.3.барилга байгууламжийг засварлах, тоноглох;

<sup>7</sup> Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 26 дугаарт нийтлэгдсэн.



- 9.1.4.буулгалтын ажил;
- 9.1.5.гадна талбайн тохижилт.

## **10 дугаар зүйл.Барилга байгууламжийн ангилал**

10.1.Барилга байгууламжийг төвөгшлөөр нь дараахь байдлаар ангилна:

10.1.1.барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж;

- 10.1.2.бага төвөгшилтэй барилга байгууламж;
- 10.1.3.дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж;
- 10.1.4.өндөр төвөгшилтэй барилга байгууламж;
- 10.1.5.онцгой төвөгшилтэй барилга байгууламж.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зориулалт, хүчин чадлыг энэ хуулийн 9.1-д заасан барилгын ажлын төрөлтэй уялдуулан барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ШААРДЛАГА**

### **11 дүгээр зүйл.Барилгын үйл ажиллагааны зарчим**

11.1.Барилгын үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

11.1.1.механик аюулгүй байдлыг хангах: барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байх;

11.1.2.галын аюулгүй байдлыг хангах: барилга байгууламжийн ашиглалтын явцад галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулаас хамгаалах, хор хөнөөлийг хязгаарлах нөхцөлийг зураг төсөлд тусгах;

11.1.3.хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах: барилга байгууламж хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр төлөвлөгдөн баригдаж, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө болон амьтан, ургамалд аюул учруулахгүй байх;

11.1.4.хүний аюулгүй байдлыг хангах: барилга байгууламж физик, хими, биологи, цацраг, өндөр хэлбэлзлийн долгионы болон



бусад хортой бодисын нөлөөллөөс хамгаалагдсан байхаар төлөвлөгдөн баригдсан байх;

11.1.5.барилга байгууламж ашиглагчдын аюулгүй байдлыг хангах: барилга байгууламж ашиглалтын явцад хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, галд тэсвэртэй, цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байхаар төлөвлөгдөн баригдсан байх;

11.1.6.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах: барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх;

11.1.7.барилгын үйл ажиллагаанд ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх: дэвшилтэт техник, технологийн нэвтрүүлэх, цахилгаан, дулаан, уур, усны эх үүсвэрийг үр ашигтай төлөвлөх.

## **12 дугаар зүйл.Барилгын зураг төсөлд тавих шаардлага**

12.1.Барилгын зураг төсөл дараахь шаардлагыг хангасан байна:

12.1.1.эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх;

12.1.2.эрчим хүч, усан хангамж, ариутгах татуурга, харилцаа холбооны систем нь хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөгдсөн, сэргээгдэх эрчим хүч, байгалийн гэрэлтүүлэг ашиглах боломжийг хязгаарлахгүй байх;

12.1.3.барилга байгууламжаас хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэх дуу чимээ, доргио, утаа, хорт хий, өндөр үелзлэл, хог хаягдал, цацраг идэвхт бодис, хөрсний бохирдол зэргээс хамгаалагдсан байх;

12.1.4.нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг орон зайг чөлөөтэй ашиглах, авто зогсоол түүний орц гарцыг хөдөлгөөнд саадгүй байхаар төлөвлөсөн байх;

12.1.5.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг техникийн болон галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн, байгалийн гамшиг, ослын үед нүүлгэн шилжүүлэх нөхцөлийг хангасан байх;



12.1.6.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх;

12.1.7.барилгын ажилд аюулгүй ажиллагааг хангах хөдөлмөр зохион байгуулалтын зураг боловсруулсан байх;

12.1.8.орчны архитектур төлөвлөлттэй уялдуулж барилгын нүүр тал /фасад/, дээвэр, тагтны хашлага, хаалтыг төлөвлөж байх.

### **13 дугаар зүйл.Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага**

13.1.Барилга байгууламжид ашиглах барилгын материал, бүтээгдэхүүн дараахь шаардлагыг хангасан байна:

13.1.1.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан байх;

13.1.2.хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байх;

13.1.3.чанарыг баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн батламжтай байх;

13.1.4.чанарын шаардлага хангасан зориулалтын сав, баглаа, боодол, хаяг, шошготой байх.

13.2.Барилгын материал, бүтээгдэхүүнийг барилга байгууламжийн зориулалт, төлөвлөлтийн дагуу сонгож зураг төсөлд тусгана.

13.3.Барилга байгууламжийн зураг төсөлд барилгын материал, бүтээгдэхүүний стандартын шаардлагын тухай мэдээллийг тусгана.

13.4.Барилгын материал, бүтээгдэхүүнийг барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн зураг төсөл зохиогчийн шийдвэрээр өөрчилнө.

13.5.Барилгын материалын үйлдвэрлэл, олборлолт болон барилгын материал, бүтээгдэхүүнд тавих нарийвчилсан шаардлагыг барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулна.

### **14 дүгээр зүйл.Барилга байгууламжид тавих шаардлага**

14.1.Барилга байгууламж дараахь шаардлагыг хангасан байна:

14.1.1.зураг төслийн дагуу баригдсан байх;



14.1.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;

14.1.3.байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх;

14.1.4.зэргэлдээ орших барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулахгүй байх.

14.2.Барилга байгууламжийн гадна тохижилтын талбай, ногоон байгууламж хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичигт заасан хэмжээнээс багагүй байна.

14.3.Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

14.4.Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно.

14.6.Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

14.7.Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна.

14.8.Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн<sup>8</sup> 43.6-д заасны дагуу зохицуулна.

14.9.Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоох дүрмийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

<sup>8</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

14.10.Энэ хуулийн 14.9-т заасан хугацаа дуусгавар болсноор цаашид ашиглах эсэх асуудлыг барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага тогтооно.

14.11.Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацаа дуусгавар болсноор захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, барилгын материал ханган нийлүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, экспертийг энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болно.

14.12.Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацаа дуусгавар болсны дараа тухайн барилга байгууламжийг энэ хуулийн 14.10-т заасан эрх бүхий байгууллага цаашид ашиглаж болохыг тогтоовол энэ хуулийн 49.2.1-д заасан ашиглалтын гэрчилгээ олгоно.

### **15 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шаардлага**

15.1.Барилга байгууламжийн зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шаардлагыг тусгана.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан шаардлагыг барилгын норм, дүрэм, стандартаар зохицуулна.

### **16 дугаар зүйл.Барилгын ажлын талбайд тавих шаардлага**

16.1.Захиалагч, гүйцэтгэгч барилга байгууламжийг барихаар олгогдсон газрын хил хязгаар, хэмжээг дур мэдэн өөрчлөхийг хориглоно.

16.2.Барилга байгууламжийн тэг тэнхлэгийг зураг төсөлд заасны дагуу геодезийн тэмдэглэгээ /улаан шугам/-тэй уялдуулан тухайн барилгын ажлын талбайд барилгын геодези, зураг зүйн ажил эрхлэх эрх бүхий хуулийн этгээд тогтооно.

16.3.Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна.

16.4.Энэ хуулийн 16.2-т заасан эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн тэг тэнхлэгийн тухай мэдээллийг нутгийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

### **17 дугаар зүйл.Барилгын ажил гүйцэтгэх газарт сервитут тогтоох**

17.1.Барилгын ажлын талбайд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан үндэслэл, журмын дагуу сервитут тогтоож болно.



17.2.Зайлшгүй шаардлагатай тохиолдолд дараахь барилгын ажилд зориулан зэргэлдээ орших газарт, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн газар болон үл хөдлөх эд хөрөнгөд сервитут тогтооно:

17.2.1.барилга байгууламж барих, шинэчлэн барих, засварлах;

17.2.2.шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламж барих, шинэчлэн барих;

17.2.3.тухайн газар нутагт хөрсний инженерийн хайгуулын судалгаа гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалалтад авах;

17.2.4.барилга байгууламжид түр болон байнгын зориулалттай нэвтрэх орц барьж байгуулах.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасны дагуу тусгай хэрэгцээний газар, нийтийн эзэмшлийн газар, талбайг барилгын үйл ажиллагаанд түр хугацаагаар ашиглахад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр сервитут тогтоож болно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ**

#### **18 дугаар зүйл.Барилгын үйл ажиллагаа эрхлэх**

18.1.Барилгын үйл ажиллагааг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхэлнэ.

18.2.Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн барилгын ажлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхэлнэ.

18.3.Энэ хуулийн 10.1.1-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхэд энэ хуулийн 19.1.2-т заасан тусгай зөвшөөрлийг шаардахгүй.

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилгын салбарын хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагааг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.



### **19 дүгээр зүйл.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл**

19.1.Дараахь барилгын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ:

19.1.1.энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах;

19.1.2.энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх;

19.1.3.өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх;

19.1.4.даацын хийц, бүтээц, эдлэхүүн, материал түүний түүхий эд болон шатамхай, химийн хортой, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

19.2.Энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан эрх бүхий этгээд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн бүртгэлийг хөтөлж, мэдээллийг барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

### **20 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох**

20.1.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.

20.2.Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгоно.

20.3.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан байгууллагад бүрдүүлж өгнө:

20.3.1.мэргэжилтнүүдийн талаархи мэдээлэл;

20.3.2.багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт болон тодорхойлолт, үйлдвэрлэлийн байрны талаархи мэдээлэл;

20.3.3.шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 20.3.2-т заасан тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бусад хуулийн этгээдээс авч ашиглах тухай гэрээний хуулбар;





20.3.4.энэ хуулийн 20.2-т заасан барилга байгууламжийн хувьд зураг төсөлд хийгдсэн магадлалын дүгнэлт.

20.4.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохтой холбогдуулан энэ хуулийн 20.3-т зааснаас бусад баримт бичгийг шаардахыг хориглоно.

20.5.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгоно.

20.6.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 20.5-д заасан хугацаагаар сунгаж болно.

20.7.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан барилгын ажлын зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлнэ.

20.8.Дараахь тохиолдолд барилгын улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ:

20.8.1.энэ хуулийн 12, 13, 14, 15, 16 дугаар зүйлд тавьсан шаардлагыг зөрчсөн;

20.8.2.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг гурван жил дараалан эрхлээгүй.

20.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны мэдээ, тайланг энэ хуулийн 33.1.17-д заасан барилга байгууламжийн баримт бичгийн дагуу барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр хүргүүлнэ.

20.10.Энэ хуулийн 20.2-т заасан барилга байгууламжийн зураг төслийг давтан хэрэглэхэд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахгүй.

### **21 дүгээр зүйл.Барилгын үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэл**

21.1.Барилгын инженер хайгуулын судалгаа, геодези зураг зүйн ажил эрхлэх, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын төсвийн тооцоо хийх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 21.2-т

заасан шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичгийг бүрдүүлж бүртгэлд хамрагдана. Бүртгэлийг цахим хэлбэрээр хийж болно.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан ангилалын дагуу тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, бүртгэх журмыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.3.Барилгын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, ажилтан бүртгэл, мэдээллийн санд хамрагдана.

## **22 дугаар зүйл. Техникийн нөхцөл олгох**

22.1.Барилга байгууламжийн техникийн нөхцөл авах хүсэлтийг энэ хуулийн 22.2-т заасан инженерийн хангамжийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ. Хүсэлтэд дараахь баримт бичгийг хавсаргана:

22.1.1.эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл;

22.1.2.барилга барих газрын нэгж талбарын кадастрын зураг, түүний нөхцөл, байдлыг харуулсан гэрэл зураг;

22.1.3.хүсэлт гаргасан этгээдийн иргэний үнэмлэх, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

22.1.4.өргөдлийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хүргүүлэх тохиолдолд итгэмжлэл;

22.1.5.барилга архитектурын загвар зураг;

22.1.6.техникийн нөхцөл олгоход шаардагдах барилга байгууламжийн хүчин чадал, инженерийн хангамжийн хэрэгцээг тодорхойлсон мэдээлэл.

22.2.Инженерийн хангамжийн байгууллага техникийн нөхцөл олгож, баталгаажуулах ажиллагааг ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

22.3.Инженерийн хангамжийн байгууллага техникийн нөхцөл олгохоос татгалзсан нь хүсэлт гаргасан этгээд инженерийн хангамжийн хэрэгцээг өөрийн эх үүсвэрээр хангахад саад болохгүй.

22.4.Хүсэлт гаргасан этгээд инженерийн хангамжийн хэрэгцээг өөрийн эх үүсвэрээр хангах зураг төсөл боловсруулан баталгаажуулсан тохиолдолд барилгын ажлын зөвшөөрөл олгож болно.



### **23 дугаар зүйл.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах**

23.1.Барилга байгууламжийн байршил, загвар зургийг баталгаажуулах эсэх асуудлыг энэ хуулийн 35.1.3-т заасны дагуу ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу баталгаажуулсан барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлүүдэд үндэслэн эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулна.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан иж бүрэн ажлын зураг төслийг дараахь үе шатаар боловсруулна.

23.3.1.энэ хуулийн 10.1.5-д заасан ангилалын болон цогцолбороор баригдах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг “техникийн зураг”, “ажлын зураг” гэсэн хоёр үе шатаар;

23.3.2.энэ хуулийн 23.3.1-д зааснаас бусад барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг “ажлын зураг” гэсэн нэг үе шатаар.

23.4.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үе шатыг зураг төслийн байгууллагатай байгуулсан гэрээ болон зургийн даалгаварт тусгана.

23.5.Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төслийн баримт бичгийг Монгол Улсын эрх бүхий хуулийн этгээдтэй хамтран баталгаажуулсан байх бөгөөд зураг төслийн баримт бичиг нь англи, монгол хэлээр байна.

23.6.Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төслийг баталгаажуулахад тавих шаардлагыг энэ хуулийн 32.1.8-д заасан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэмд тусгана.

### **24 дүгээр зүйл.Барилга байгууламжийн төсөв**

24.1.Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

24.1.1.батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх;

24.1.2.барилга байгууламжийн байршил, байгаль, цаг уурын нөхцөл, газар чөлөөлөх асуудлыг тусгасан байх;

24.1.3.барилгын үнэ бүрдэл, төсвийн норм, нормативын баримт бичиг, дүрэм, заавар, аргачлалыг удирдлага болгосон байх;

24.1.4.хараат бус байх.

24.2.Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжийн төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэсэн байна.

24.3.Энэ хуулийн 44.3.2, 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй төсөвчид төсөвчний мэргэжлийн байгууллагаар ажлын тайлангаа жил бүр дүгнүүлнэ. Төсөвчний ёс зүйн дүрмийг энэ хуулийн 33.1-д заасан байгууллага баталж, мөрдүүлнэ.

24.4.Барилгын материалын үнэ болон ханшны өөрчлөлт, бусад хүчин зүйлээс хамааран барилга байгууламжийн төсвийн тооцоонд өөрчлөлт оруулах тохиолдолд санхүү, эдийн засгийн болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран үндэслэл, тооцоог хянаж, санхүүжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

24.5.Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн, зохих журмын дагуу баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг үндэслэлгүйгээр саатуулахыг хориглоно.

24.6.Барилгын үнэ бүрдлийн дүрэм, төсөв зохиох аргачлалыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **25 дугаар зүйл.Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх**

25.1.Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг энэ хуулийн 23.2-т заасан эх загвар зураг /эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ.

25.2.Магадлалыг дараахь зураг төсөлд хийнэ:

25.2.1.газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт;

25.2.2.газар хөдлөлтийн долоогоос доош баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт;



25.2.3.барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд;

25.2.4.инженер-геологийн дүгнэлт, геодезийн зураглалд;

25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

25.3.Энэ хуулийн 25.2 дахь хэсэгт гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төсөлд нэгэн адил хамаарна.

25.4.Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно.

25.5.Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.

25.6.Магадлалын дүгнэлт татгалзсан, зөвшөөрсөн гэсэн хоёр хэлбэртэй байна. Магадлалын татгалзсан дүгнэлт барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл болно.

25.7.Энэ хуулийн 25.6-д заасан магадлалын дүгнэлттэй холбоотой маргаантай асуудлыг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлж болно.

25.8.Энэ хуулийн 10.1.1-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөлд захиалагчийн хүсэлтээр магадлал хийж болно.

25.9.Энэ хуулийн 12.1-д заасан шаардлагыг зөрчсөн нь магадлалын татгалзсан дүгнэлт гаргах үндэслэл болно.

## **26 дугаар зүйл.Барилгын ажлын зөвшөөрөл**

26.1.Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжид дараахь төрлөөр барилгын ажлын зөвшөөрөл олгоно:

26.1.1.барилга байгууламжийг шинээр барих;

26.1.2.барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэн барих;

26.1.3.барилга байгууламжийг буулгах.

26.2.Барилга байгууламжийн үндсэн бүтээцэд болон инженерийн шугам сүлжээний хэмжээ, хүчин чадалд өөрчлөлт оруулсан бол зураг төслийг дахин боловсруулж, барилгын ажлын зөвшөөрөл шинээр авна.



26.3.Барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэн барихад барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 10.1, 23.2, 28.2-т заасны дагуу ангилал, зураг төсөл, баримт бичгийн дагуу олгоно.

26.4.Олгогдсон газарт нэгээс дээш барилга байгууламж барих тохиолдолд төвөгшлийн дээд ангилалаар барилгын ажлын зөвшөөрөл авна.

### **27 дугаар зүйл.Барилгын ажлын зөвшөөрөл олгох үйл ажиллагаа**

27.1.Энэ хуулийн 35.1-д заасан байгууллага барилгын ажлын зөвшөөрлийг олгоно.

27.2.Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгийг үндэслэн барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 27.1-д заасан байгууллага ажлын 10 өдөрт багтаан олгоно.

27.3.Энэ хуулийн 27.1-д заасан байгууллага барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзсан бол үндэслэл бүхий тайлбарыг шийдвэрт тусган хүсэлт гаргасан этгээдэд бичгээр өгнө.

### **28 дугаар зүйл.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох**

28.1.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу барилгын ажлын зөвшөөрлийг гэрчилгээгээр баталгаажуулна.

28.2.Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд дараахь баримт бичгийг хавсаргана:

28.2.1.барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр;

28.2.2.барилга байгууламжийн магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлт;

28.2.3.зураг төсөл зохиогч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

28.2.4.байгаль орчны хууль тогтоомжийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай барилга байгууламжийн үнэлгээний тайлан;

28.2.5.гэнэтийн ослын болон хариуцлагын даатгалд даатгуулсан бол гэрчилгээг хавсаргах.



28.3.Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгээс гадна зураг төсөл боловсруулсан болон барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хавсаргана.

28.4.Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсаргана.

28.5.Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргасан этгээдийн хүсэлтэд хавсаргасан энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгийг хянан шийдвэрлэж, зөвшөөрөл олгоно.

28.6.Энэ хуулийн 35.1-д заасан байгууллага энэ хуулийн 28.2, 28.3, 28.4-т зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

### **29 дүгээр зүйл.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл**

29.1.Энэ хуулийн 27.1-д заасан байгууллагаас олгосон барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд дараахь мэдээллийг тусгана:

29.1.1.барилга байгууламжийн байршлын талаархи мэдээлэл;

29.1.2.газрын бүртгэлийн мэдээлэл, кадастрын код;

29.1.3.барилгын ажлын зөвшөөрөл олгосон он, сар, өдөр, зөвшөөрлийн дугаар;

29.1.4.барилгын ажлын зөвшөөрлийн хүчинтэй хугацаа;

29.1.5.барилгын ажлын зөвшөөрлийн хугацаа үйлчилж эхлэх он, сар, өдөр;

29.1.6.барилга байгууламжийн зориулалт, хүчин чадлын талаархи мэдээлэл;

29.1.7.барилга байгууламжийн ангилал;

29.1.8.барилгын ажлын захиалагч, гүйцэтгэгчийн талаархи мэдээлэл;

29.1.9.барилгын ажлын зөвшөөрөл олгосон ажилтны албан тушаал, гарын үсэг.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага зөвшөөрөл олгох тухай шийдвэр болон барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох өөрчлөлтийг оруулах эрхтэй.

### **30 дугаар зүйл.Барилгын ажлын зөвшөөрлийн хугацаа**

30.1.Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд заасан

хугацаагаар олгоно. Хугацааг барилгын ажил эхлүүлэхээр заасан өдрөөс эхлэн тооцно.

30.2.Барилгын ажил энэ хуулийн 30.1-д заасан хугацаанд дуусаагүй бол захиалагч зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтийг энэ хуулийн 27.1-д заасан байгууллагад гаргаж, дуусаагүй ажлыг гүйцэтгэх бодит хугацааг тусгасан төлөвлөгөөг хавсаргана.

30.3.Энэ хуулийн 27.1-д заасан байгууллага энэ хуулийн 30.2-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдөрт багтаан асуудлыг шийдвэрлэж, барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

30.4.Энэ хуулийн 30.2-т заасны дагуу хүсэлт гаргаагүй, барилгын ажлын зөвшөөрлийн хугацаа дууссан бол энэ хуулийн 27.2, 28.2-т заасны дагуу барилгын ажлын зөвшөөрлийг шинээр авна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БАРИЛГЫН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ**

### **31 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

31.1.Улсын Их Хурал барилгын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, барилгын хууль тогтоомжийг батлан, хэрэгжилтэд хяналт тавина.

### **32 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

32.1.Засгийн газар барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.барилгын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

32.1.2.барилгын салбарын төсөв, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

32.1.3.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог батлах;

32.1.4.нутагшил, суурьшил, бүсчлэлийн нийт нутаг дэвсгэр дэх харилцаа холбооны болон инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийг суурилуулах трасс, техникийн нөхцөл, зарчим, дарааллыг тодорхойлох;

32.1.5.цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть





болон хийн хоолой зэрэг улсын чанартай барилга байгууламжид барилгын ажлын зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх;

32.1.6.барилга байгууламжийн ашиглалтын дүрмийг батлах;

32.1.7.барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг батлах;

32.1.8.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийг батлах;

32.1.9.барилгын ажлын захиалагчийн дүрмийг батлах;

32.1.10.барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийг батлах;

32.1.11.зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

32.1.12.тусгай хэрэгцээний газар нутагт түгээмэл тархацтай ашигт малтмал, түүхий эдийг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;

32.1.13.хууль тогтоомжид заасан бусад эрх.

### **33 дугаар зүйл.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1.барилгын талаархи төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх;

33.1.2.энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг батлах;

33.1.3.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам батлах;

33.1.4.инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, барилга техникийн нэгдсэн бодлогыг тодорхойлж зохицуулалтаар хангах;

33.1.5.барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн журам батлах;

33.1.6.нутгийн захиргааны барилгын асуудал эрхэлсэн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

33.1.7.барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг боловсруулж батлах;

33.1.8.барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн ажиллах журам батлах;

33.1.9.барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм батлах;

33.1.10.санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индекс барилгын ажилтны тарифт цалинг батлах;

33.1.11.туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрмийг батлан, удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;

33.1.12.архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам батлах;

33.1.13.барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг баталгаажуулж, хэрэглэх журмыг батлах;

33.1.14.барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах журам батлах;

33.1.15.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам батлах;

33.1.16.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олголт, барилга байгууламжийн чанар, паспортжуулалт, ашиглалт, бүртгэлийн асуудлаар аймаг, нийслэлийн Засаг даргын тайланг хэлэлцэх;

33.1.17.улсын хэмжээнд барилгын талаар нэгтгэж гаргах салбарын бүртгэл, мэдээллийн маягыг Бүртгэл, статистикийн үндэсний хороотой хамтран батлах;

33.1.18.барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;



33.1.19.экспорт, импортын барилгын материал, тоног төхөөрөмж, машин механизм, түүхий эдийн бүртгэлийн “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийг жил бүр холбогдох байгууллагатай хамтран өргөтгөн боловсронгуй болгох;

33.1.20.барилгын үйл ажиллагаанд мөрдөх гэрээний загвар батлах;

33.1.21.барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм батлах;

33.1.22.барилгын үйл ажиллагаанд холбогдсон зөвшөөрөл олгох хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх болон барилгын салбарт нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх нийтлэг журам батлах;

33.1.23.хууль тогтоомжид заасан бусад эрх.

#### **34 дүгээр зүйл.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

34.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

34.1.1.барилгын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

34.1.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах;

34.1.3.барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах;

34.1.4.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;

34.1.5.барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг хэрэгжүүлэх;

34.1.6.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

34.1.7.барилгын салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

34.1.8.барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индексийг боловсруулах;



34.1.9.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох;

34.1.10.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;

34.1.11.зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

34.1.12.барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

34.1.13.архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах;

34.1.14.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулах;

34.1.15.барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

34.1.16.хууль тогтоомжид заасан бусад эрх.

34.2.Энэ хуулийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.14, 34.1.15-д заасан чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

### **35 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

35.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1.нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;

35.1.2.барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх;

35.1.3.барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион



байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээлэл түүний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн байнгын үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих;

35.1.4. тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах;

35.1.5. барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах;

35.1.6. барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах;

35.1.7. барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг улсын хяналт хэрэгжүүлэгч байгууллагын ерөнхий байцаагчийн дүгнэлт болон шүүхийн шийдвэрийг үндэслэн албадан буулгах арга хэмжээг авч, холбогдох зардлыг буруутай этгээдээр төлүүлэх;

35.1.8. энэ хуулийн 35.1.3, 35.1.4, 35.1.6-д заасан үйл ажиллагаатай холбоотой хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэн, нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулах.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ**

#### **36 дугаар зүйл. Иргэн, төрийн бус байгууллагын оролцоо**

36.1. Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 18.4, 34.2, 44.7-д заасны дагуу шилжүүлсэн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

36.2. Барилгын үйл ажиллагаанд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлага болон иргэний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах эрхийг зөрчиж байгаа талаар хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад санал, хүсэлт, гомдол гаргах эрхтэй.

36.3. Иргэн, төрийн бус байгууллага барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт санал өгч болно.

#### **37 дугаар зүйл. Захиалагчийн чиг үүрэг**

37.1. Барилгын ажлын захиалагч дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:



37.1.1.барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлэх;

37.1.2.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.4.1-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаархи иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах;

37.1.3.барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх;

37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах;

37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

37.1.6.энэ хуулийн 48.1-д заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах;

37.1.7.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу барилгын ажлыг түр зогсоосон бол тогтоосон хугацаанд хамгаалалтын горимыг хангаж ажиллах;

37.1.8.барилгын үе шатны ажилд эрх бүхий байгууллагаас өгсөн шаардлага, зааварчилгааг биелүүлэх;

37.1.9.барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах;

37.1.10.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах;

37.1.11.түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэх, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах;

37.1.12.барилгын үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцан зохицуулж, санхүүжилтийг тогтоосон хугацаанд хийх;



37.1.13.барилгын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гарах эрсдэл, хохирлыг хариуцах;

37.1.14.барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохирлыг хариуцах;

37.1.15.барилга байгууламжийн баримт бичгийг ашиглалтын хугацаанд хадгалж, баяжуулалт хийх;

37.1.16.барилга байгууламжийн баримт бичгийн үнэн зөвийг хариуцах;

37.1.17.барилгын үйл ажиллагааны явцад орчны тохижилт, эзлэхүүн төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн талаархи зурагт болон бусад сурталчилгаа бодит байдалд нийцсэн байх ба хэрэглэгчийн өмнө тэдгээр мэдээллийн үнэн зөв байдлын хариуцлагыг хүлээх;

37.1.18.энэ хуулийн 37.1.17-д заасан зурагт сурталчилгаа болон холбогдох материалыг хэрэглэгчтэй байгуулах гэрээнд хавсаргах;

37.1.19.барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах;

37.1.20.барилга байгууламж барих талбайг чөлөөлөх, ашиглалтад оруулах зардлыг хариуцах.

37.2.Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

37.3.Барилгын үйл ажиллагаанд захиалагч тодорхой байна. Захиалагч тодорхой бус тохиолдолд тухайн барилга байгууламжийн эзэмшигч буюу өмчлөгчийг захиалагчид тооцно. Барилга байгууламжийн эзэмшигч, өмчлөгч тодорхой бус бол тухайн газрын эзэмшигч буюу өмчлөгчийг захиалагчид тооцно.

37.4.Захиалагч барилга байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

37.5.Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгоогүй, зураг төсөл нь боловсруулагдаж дуусаагүй орон сууцны барилгад иргэдээс хөрөнгө төвлөрүүлэхийг хориглоно.

37.6.Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.



37.7.Барилга байгууламж барих, шинэчлэх, засварлахдаа гудамж, зам, талбай сэтлэх, эвдэж сүйтгэх, шугам сүлжээ шилжүүлэх, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулбал тэдгээрийг нөхөн сэргээж, зардлыг хариуцна.

37.8.Энэ хуулийн 16.3-т заасан зураг төслийг үндэслэн барилга байгууламжийн буулгалтын ажлыг гүйцэтгэнэ.

37.9.Доорхи барилга байгууламжийн зураг төслийн даалгавар, норм, нормативын баримт бичгийн техникийн даалгаврыг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хянуулсан байна:

37.9.1.энэ хуулийн 5.1-д заасан заавал мөрдөх норм, нормативын баримт бичиг;

37.9.2.энэ хуулийн 4.1.18-д заасан цомог;

37.9.3.энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан барилга байгууламжийн нэг маягийн зураг;

37.9.4.энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан барилга байгууламжийн зураг төсөл.

### **38 дугаар зүйл.Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг**

38.1.Зураг төсөл зохиогч дараахь чиг үүрэгтэй:

38.1.1.барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн хөрөнгө оруулалтын үр ашиг болон техникийн тооцоонд тулгуурлан боловсруулах;

38.1.2.барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх;

38.1.3.зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх;

38.1.4.зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

38.1.5.барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажиллагаанд оролцох;





38.1.6.барилга байгууламжийн зураг төсөлд өөрчлөлт оруулах захиалагчийн санал барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт тавих чанар, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн тохиолдолд зөвшөөрч, баталгаажуулах;

38.1.7.энэ хуулийн 16.3-т заасан зураг төслийг боловсруулах;

38.1.8.барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авахыг захиалагчаас шаардах;

38.1.9.барилга байгууламжийн хийц, бүтээц, материал, эдлэхүүнд хөндлөнгийн лабораторийн шинжилгээ хийлгэж баталгаажуулахыг захиалагчаас шаардах;

38.1.10.барилгын ажлыг зураг төсөл болон барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт тавьсан шаардлагад нийцүүлэн гүйцэтгээгүй тохиолдолд дүгнэлт гаргаж, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагад мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авахуулах.

38.2.Зураг төсөл зохиогч барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гаргасан хохирлыг хариуцна.

38.3.Зураг төсөл зохиогч өөрийн боловсруулсан зураг төсөлд магадлал хийхийг хориглоно.

### **39 дүгээр зүйл.Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт**

39.1.Барилга байгууламжийн зураг төсөлд хийх магадлалыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 34.1.10-т заасны дагуу эрх олгосон иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

39.2.Экспертийн эрх бүхий иргэн нь магадлал хийх эрх бүхий хоёроос дээшгүй хуулийн этгээдийн бүрэлдэхүүнд ажиллаж болно.

39.3.Энэ хуулийн 39.2-т заасныг зөрчсөн экспертийн магадлал хийх эрхийг энэ хуулийн 33.1.3-т заасан журмын дагуу эрх бүхий этгээд хүчингүй болгоно.

39.4.Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.

39.5.Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн

шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ.

#### **40 дүгээр зүйл.Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг**

40.1.Барилгын ажил гүйцэтгэгч дараахь чиг үүрэгтэй:

40.1.1.барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих;

40.1.2.барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

40.1.3.барилга байгууламжийг давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

40.1.4.барилгын ажлын талбайд гал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горимыг мөрдөж, байгаль орчин, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах;

40.1.5.барилгын ажлын талбайн орчны хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулж, гуравдагч этгээдийг барилгын ажлаас шалтгаалсан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах;

40.1.6.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гуравдагч этгээдийн амьдрах, ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөлийг зөрчихгүй, саад учруулахгүй байх;

40.1.7.барилга байгууламжийн үйл ажиллагаанд оролцогчдын төлөөллийг барилгын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх, барилгын ажил, барилга байгууламжийн баримт бичигтэй танилцуулах;

40.1.8.барилга байгууламжийн ашиглалтын зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохирлыг хариуцах;

40.1.9.барилга байгууламжийн суурь, хана, хучилт, шат, араг бүтээц, дээврийн ажлуудыг бие даан гүйцэтгэх;

40.1.10.барилга байгууламж барих, шинэчлэх, засварлахдаа гудамж, зам, талбай сэтлэх, эвдэж сүйтгэх, шугам сүлжээ шилжүүлэх, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулбал тэдгээрийг нөхөн сэргээх;



40.1.11.барилга байгууламжид хэрэглэгдсэн материал, тоног төхөөрөмж, зураг төсөлд заасан техникийн үзүүлэлтийг хангаж байгааг нотлох, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

40.1.12.барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

40.1.13.барилгын ажил гүйцэтгэх технологи, үйлдвэрлэл, техникийн ослоос сэргийлсэн хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээний зохион байгуулалтын зургийг боловсруулж, түүний дагуу гүйцэтгэх;

40.1.14.Хог хаягдлын тухай хуулийн<sup>9</sup> 9.2-т заасныг хэрэгжүүлэх;

40.1.15.энэ хуулийн 5.8-д заасан зардлыг барилгын төсөвт өртөгт тусган, энэ хуулийн 5.7-д заасан санд төвлөрүүлэх;

40.1.16.барилгын ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхгүй байх;

40.1.17.барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах;

40.1.18.барилгын ажил гүйцэтгэгч туслан гүйцэтгэгчийг ажиллуулж, ерөнхий гүйцэтгэгчийн чиг үүргийг хэрэгжүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүн, эрсдэлийг захиалагчийн өмнө хариуцах;

40.1.19.энэ хуулийн 16.3-т заасан зураг төслийг үндэслэн барилга байгууламжийн буулгалтын ажлыг гүйцэтгэх;

40.1.20.гарал үүсэл, тохирлын гэрчилгээтэй барилгын материал хэрэглэх;

40.1.21.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу даатгалд хамрагдсан байх;

40.1.22.захиалагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол туслан гүйцэтгэгчийг сонгож, гэрээний үндсэн дээр ажиллуулах;

<sup>9</sup> Хог хаягдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

40.1.23. гүйцэтгэгч барилгын ажлын захиалагчийн үүргийг хэрэгжүүлсэн тохиолдолд энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

40.1.24. энэ хуулийн 10.1.1-д заасан ангилалд хамаарах барилгын ажлыг холбогдох зөвшөөрөлгүйгээр иргэн, хуулийн этгээд гүйцэтгэж болно. Энэ тохиолдолд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг дагаж мөрдөх.

40.2. Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

40.3. Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангаагүй, гарал үүсэл, тохирлын гэрчилгээгүй материал, бүтээгдэхүүн, эдлэхүүн болон барилгын хэв хашмалын тулаасанд мод хэрэглэхийг хориглоно.

#### **41 дүгээр зүйл. Барилга байгууламжийн хамгаалалтын горим**

41.1. Барилгын ажлыг долоон сараас дээш хугацаагаар түр зогсоосон бол захиалагч барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулж, энэ талаар барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэж, холбогдох шийдвэрийг гаргуулна. Барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулах шийдвэрт хамгаалалтын горимын хугацаа, нөхцөлийг тусгана.

41.2. Барилга байгууламжийн хамгаалалтын горимыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

41.2.1. барилга байгууламжийн технологийн нөхцөл, барилгын ажлын зөвшөөрөлд заасныг харгалзан барилгын ажлыг түр зогсоох;

41.2.2. барилга байгууламжийн хамгаалалтын горимд шилжих нөхцөлийг хангаж, шаардлагатай арга хэмжээг авах;

41.2.3. барилгын ажлын талбайд аюулгүй байдлыг хангах зорилгоор захиалагч байнгын хяналт тавьж, шалгалт хийх.

41.3. Барилга байгууламжийн хамгаалалтын горимыг техникийн норм, нормативын баримт бичигт заасны дагуу гүйцэтгэнэ.

41.4. Барилга байгууламжийг хамгаалалтын горимд шилжүүлэхэд тэмдэглэл хөтөлж, захиалагч болон барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын байцаагч гарын үсэг зурж баталгаажуулна.



41.5.Энэ хуулийн 41.4-т заасан тэмдэглэлийг барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хүргүүлсэн өдрөөс эхлэн барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг түр түдгэлзүүлж, барилгын ажлыг зогсооно.

41.6.Барилга байгууламжийн хамгаалалтын горимын хугацаа хоёр жил байна. Шаардлагатай тохиолдолд хугацааг сунгах хүсэлтийг захиалагч гаргаж болно.

41.7.Энэ хуулийн 41.6-д заасан хугацаа дуусгавар болмогц захиалагч тухайн барилга байгууламжийн барилгын ажлыг үргэлжлүүлэх, эсхүл чанар аюулгүйн шаардлага хангахгүй нь тогтоогдсон барилга байгууламжийг буулгах арга хэмжээг авна.

41.8.Барилга байгууламжийг хамгаалалтын горимоос гаргасан тохиолдолд захиалагч барилгын ажлыг үргэлжлүүлэхдээ барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

41.9.Энэ хуулийн 41.1, 41.6-д заасан хугацаа барилга байгууламжийг буулгах тухай барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэрт хамаарахгүй.

## **42 дугаар зүйл.Зөвлөх үйлчилгээ**

42.1.Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээг дараахь чиглэлээр үзүүлнэ:

42.1.1.инженер-хайгуулын судалгаа;

42.1.2.хөрөнгө оруулалтын судалгаа;

42.1.3.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, норм, нормативын баримт бичиг боловсруулалтын түвшинг тогтоох;

42.1.4.барилгын материалын үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үндэслэл, түүхий эд болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар, технологийн хяналт, зөвлөгөө, дүгнэлт гаргах, тоног төхөөрөмжийн угсралт, лабораторийн болон үйлдвэрлэлийн туршилт хийх, технологийн горим тогтоох;

42.1.5.барилгын ажлын механикжуулалт, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх ажлын технологи, аргачлал тогтоох;

42.1.6.барилгын ажлын үе шатанд хяналт тавих, барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах;

42.1.7.төслийн удирдлага, зохион байгуулалт, технологийн түвшин;

42.1.8.барилга байгууламжийн захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх;

42.1.9.энэ хуулийн 42.1.1, 42.1.2, 42.1.3, 42.1.4, 42.1.5, 42.1.6, 42.1.7, 42.1.8-д заасан ажлыг иж бүрэн гүйцэтгэх.

42.2.Энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээг заавал авна.

42.3.Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 34.1.11-д заасан байгууллагад бүртгүүлнэ.

42.4.Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журмыг Засгийн газар батална.

### **43 дугаар зүйл. Барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн чиг үүрэг**

43.1.Барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараахь чиг үүрэгтэй:

43.1.1.Ашигт малтмалын тухай болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан журмын дагуу барилгын материалын үйлдвэрлэлд хэрэглэх түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох, боловсруулах;

43.1.2.хууль тогтоомжид заасны дагуу орд газрын ашигласан талбайд нөхөн сэргээлт хийх;

43.1.3.үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнийхээ чанарт баталгаа өгөх;

43.1.4.барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораторийн сорилт туршилтад тогтмол хамруулан технологийн заавар батлуулах, тохирлын гэрчилгээ авах;

43.1.5.үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнийхээ чанарын үндсэн үзүүлэлтийг тодорхойлох лабораторитой байх, хяналт тавих;

43.1.6.итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх



олгосны дагуу шинэ материал, хийц, бүтээц, эдлэхүүн, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, туршилтын журмаар хэрэглэх;

43.1.7.лабораторийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг баталгаажуулах.

#### **44 дүгээр зүйл.Барилгын салбарын ажилтан**

44.1.Барилгын салбарын ажилтан энэ хуульд заасны дагуу бүртгэлд хамрагдана.

44.2.Барилгын салбарын ажилтны тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг төрийн захиргааны байгууллагын дэргэдэх мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл хариуцна. Зөвлөлийн дүрмийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

44.3.Барилгын салбарын мэргэжилтэн дараахь мэргэшлийн зэрэгтэй байна:

44.3.1.инженер, архитектор;

44.3.2.мэргэшсэн инженер, мэргэшсэн архитектор, мэргэшсэн төсөвчин;

44.3.3.зөвлөх инженер, зөвлөх архитектор, тэргүүлэх төсөвчин.

44.4.Мэргэжилтэй ажилчны мэргэжлийн түвшинг нэгээс зургаан зэргээр стандартын дагуу тодорхойлно.

44.5.Мэргэжилтний үйл ажиллагааны хүрээ, түүнд тавих шаардлага, мэргэшлийн зэрэг, гэрчилгээ олгох хугацааг энэ хуулийн 33.1.9-т заасан дүрмээр нарийвчлан тогтооно.

44.6.Энэ хуулийн 44.3.3-т заасан зураг төсөл боловсруулах зөвлөх мэргэжилтэн барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертийн эрхийн сонгон шалгаруулалтад орох эрхтэй.

44.7.Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг гэрээний үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

#### **45 дугаар зүйл.Барилгын салбарт ажиллах гадаадын иргэн, хуулийн этгээд**

45.1.Барилгын үйл ажиллагаанд оролцох хүсэлт гаргасан гадаадын иргэн мэргэжлээрээ ажилласан туршлагатай, хууль тогтоомжийн дагуу ажиллах зөвшөөрөл авсан байна.

45.2.Барилгын үйл ажиллагаа эрхлэх гадаадын хуулийн этгээд энэ хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл авсан байна.

45.3.Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилгын үйл ажиллагааг гадаадын хуулийн этгээд энэ хуульд заасан эрх бүхий Монгол Улсын хуулийн этгээдтэй хамтран гэрээ байгуулж, эрхэлнэ.

45.4.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд энэ хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хавсаргана.

45.5.Барилгын үйл ажиллагаа эрхлэх гадаадын иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу бүртгүүлнэ.

#### **46 дугаар зүйл.Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг**

46.1.Барилга байгууламжийн ашиглалтын явцад өмчлөгч, эзэмшигч дараахь үүргийг хүлээнэ:

46.1.1.хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг дагаж мөрдөх;

46.1.2.энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;

46.1.3.барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг арчлан хамгаалах, зориулалтыг өөрчлөхгүй байх;

46.1.4.барилга байгууламжийн инженерийн хангамжийн системийг арчлан хамгаалах;

46.1.5.барилга байгууламжийг галын аюулаас урьдчилан сэргийлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн болон экологийн шаардлагыг хангуулах;

46.1.6.байгаль орчин, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах;

46.1.7.барилга байгууламжийн орчны тохижилтын засвар арчлалтыг тогтмол хийж, авто болон явган хүний зам, талбайн хөдөлгөөнийг хааж бусдад саад учруулахгүй байх;

46.1.8.барилгын дээвэр, адрын хучилт болон бусад бүтээц дээр бороо, цас, мөс, хог, шороо, тоосонцор болон бусад эд зүйлс хуримтлагдан даац хэтэрч осол гарахаас урьдчилан сэргийлэх;





46.1.9.барилгын даацын хийц, бүтээц болон дотор, гадна инженерийн шугам сүлжээнд байнгын хяналт тавих;

46.1.10.барилга байгууламжид мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, сурталчилгааны болон гэрлэн чимэглэл байрлуулах ажлын зураг төсөл, түүний угсралт, бэхэлгээг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж, барилгын хийц, бүтээцэд эвдрэл, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх;

46.1.11.барилгын хийц, бүтээцэд ан цав, цууралт үүсэх зэрэг ноцтой эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн байгууллагад хандаж дүгнэлт гаргуулан, холбогдох арга хэмжээг авах;

46.1.12.барилгын ашиглалтын хугацаанд барилга байгууламжийн баримт бичгийг баяжуулж, хадгалах;

46.1.13.барилгын нүүр талыг өөрчлөх тохиолдолд аймаг, нийслэлийн ерөнхий архитектортой зөвшилцөх;

46.1.14.барилга байгууламжийн ашиглалтын хугацааны 15 жил тутамд барилга байгууламжийн төлөв байдалд барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн байгууллагаар дүгнэлт гаргуулж, холбогдох арга хэмжээг авах.

46.2.Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл, ослын улмаас барилга байгууламжид учирсан хохирлыг үнэлэхдээ барилга байгууламжийн ашиглалтын нөхцөлийг хангах эсэхийг харгалзан үзнэ.

46.3.Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох архивт шилжүүлнэ.

46.4.Өмчлөгч, эзэмшигч барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учруулах, зохих мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хийц, бүтээц, төлөвлөлт, зориулалтыг өөрчлөх, тухайн барилга байгууламжид байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулж болзошгүй үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.



46.5.Ашиглалтын явцад барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учрах, нурах тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, өмчлөгч, эзэмшигч, материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн аль буруутай нь хариуцлага хүлээнэ.

46.6.Барилга байгууламжийн өмчлөгч, эзэмшигч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ ТЕХНИКИЙН УЛСЫН ХЯНАЛТ**

### **47 дугаар зүйл.Барилга байгууламжийн техникийн улсын хяналт**

47.1.Барилга байгууламжийн техникийн улсын хяналтыг барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

47.2.Барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргээс гадна дараахь хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ:

47.2.1.барилга байгууламжийг барих, тэдгээрийн шинэчлэл, их засварын ажлын чанарт;

47.2.2.барилгын материал, түүхий эд, эдлэхүүн, бүтээгдэхүүний чанарт;

47.2.3.барилга байгууламжийн зураг төслийн хэрэгжилтэд;

47.2.4.барилга байгууламжийн ашиглалтад;

47.2.5.өргөх байгууламжийн угсралт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаанд;

47.2.6.барилга байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн судалгааны ажлын чанарт;

47.2.7.барилга байгууламжийн нуралт, эвдрэл, өргөх байгууламжид гарсан ослын шалтгаанд;

47.2.8.өргөх байгууламжийн улсын бүртгэлд;

47.2.9.барилгын ажлын гүйцэтгэлийн чанарт;

47.2.10.зураг төсөл боловсруулах, магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд;

47.2.11.барилга байгууламжийн зүгшрүүлэх, тохируулах болон эдэлгээний хугацаанд гарсан зөрчилд;



47.2.12.дуусаагүй болон түр зогссон барилга байгууламжийн хамгаалалтын горимын хэрэгжилтэд;

47.2.13.барилга байгууламжийн төсөвт өртөг, үнэ бүрдэлд.

47.3.Барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага зураг төсөл зохиогч, барилгын материал үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийн техникийн дотоод хяналтын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавина.

47.4.Барилга байгууламж баримт бичгийн дагуу баригдсан эсэхийг тодруулах зорилгоор эрх бүхий улсын хяналтын байцаагч барилга байгууламжид тухайн чиглэлээр нэмэлт шалгалт хийж болно.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ**

### **48 дугаар зүйл.Барилга байгууламж ашиглалтад оруулах**

48.1.Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна.

48.2.Барилга байгууламжийг барилгын ажлын явцад шаардагдах цахилгаан, дулаан, халуун, хүйтэн усаар түр хангах бөгөөд байнгын ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг цахилгаан, харилцаа холбоо, дулаан, халуун, хүйтэн усаар хангахыг хориглоно.

48.3.Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

48.4.Цогцолбор барилга байгууламжийн технологийн хувьд нэгдмэл бус бүрдэл хэсгийг хэсэгчлэн энэ хуулийн 48.1-д зааснаар ашиглалтад оруулж болно.

48.5.Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар хүсэлт гаргах бөгөөд түүнд дараахь баримт бичгийг хавсаргана:

48.5.1.барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл;

48.5.2.барилгын ажлын ил, далд ажлын акт;

48.5.3.зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

48.5.4.захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн

дүгнэлт;



48.5.5.барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэсэн, эсхүл өөр эх үүсвэр ашигласныг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл;

48.5.6.барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл;

48.5.7.тоног төхөөрөмж угсарсан актууд, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, тоног төхөөрөмжийг зааврын дагуу суурилсан эсэхэд хийсэн туршилтын дүгнэлт.

48.6.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт, энэ хуулийн 48.5-д заасан баримт бичгийг хянаж, ажлын 10 өдрийн дотор ашиглалтад оруулах комисс ажиллуулна.

48.7.Барилга байгууламжийг дараахь тохиолдолд ашиглалтад оруулахаас татгалзана:

48.7.1.энэ хуулийн 48.5-д заасан баримт бичгийг бүрдүүлээгүй;

48.7.2.захиалагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч энэ хуулийн 47.2, 47.5-д заасан хяналт шалгалт хийхэд саад учруулсан, татгалзсан;

48.7.3.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн нөхцөлүүдийг зөрчсөн.

48.8.Энэ хуулийн 48.5-д заасан баримт бичгийн үнэн зөвийг захиалагч хариуцна.

#### **49 дүгээр зүйл.Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ, паспортжуулалт**

49.1.Энэ хуулийн 48.1-д заасны дагуу ашиглалтад оруулсан барилга байгууламжид барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг үндэслэж, ажлын долоон өдрийн дотор ашиглалтын гэрчилгээ олгоно.

49.2.Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ чанар, аюулгүй байдлын түвшингээр дараахь төрөлтэй байна:

49.2.1.шинээр баригдаж ашиглалтад орсон ашиглалтын шаардлага хангасан барилга байгууламжид ногоон өнгийн;



49.2.2.засвар, шинэчлэлт хийгдэж, ашиглалтын шаардлага хангах боломжтой нь паспортжуулалтаар тогтоогдсон ашиглагдаж байгаа барилга байгууламжид шар өнгийн;

49.2.3.ашиглалтын шаардлага хангахгүй болсон нь паспортжуулалтаар тогтоогдсон ашиглагдаж байгаа барилга байгууламжид улаан өнгийн;

49.3.Ашиглагдаж байгаа барилга байгууламжийн бат бэх, найдвартай ажиллагааны түвшинг энэ хуулийн 49.5-д заасан журмын дагуу энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага паспортжуулж, энэ хуулийн 49.2-т заасан тохирох гэрчилгээг энэ хуулийн 49.1-д заасан эрх бүхий этгээд олгоно.

49.4.Энэ хуулийн 49.2.2-т заасан барилга байгууламжид засвар, шинэчлэлт хийж, ашиглалтын шаардлага хангасан бол энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага ашиглалтад оруулж, энэ хуулийн 49.1-д заасны дагуу ногоон өнгийн гэрчилгээ олгоно.

49.5.Энэ хуулийн 49.1-д заасан барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журмыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **50 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

50.1.Барилгын хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын хяналт хэрэгжүүлэгч байгууллагын холбогдох улсын байцаагч доор дурдсан захиргааны шийтгэл оногдуулна:

50.1.1.энэ хуулийн 5.2, 5.10, 16.1, 24.2, 39.1, 40.2, 40.3, 42.3, 43.1, 46.4, 48.2, 48.3-т заасныг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

50.1.2.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан барилгын ажлын зөвшөөрөл аваагүй, мөн хуулийн 25.2, 25.3, 25.4, 25.6-д заасныг зөрчиж барилгын ажлыг эхлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

50.1.3.барилгын ажлын явцад төсөлд заасан тухайн барилга байгууламжийн барилгын ажлын талбайн хэмжээ, хил хязгаар, зураг төсөл,

барилга архитектурын эх загвар /эскиз/ зураг, барилгын материалыг дур мэдэн өөрчилсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

50.1.4.барилгын ажлын явцад болон ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт зөрчсөн тохиолдолд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, торгууль оногдуулах;

50.1.5.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл аваагүй, мөн хуулийн 21 дүгээр зүйлд заасан барилгын салбарын нэгдсэн санд бүртгүүлээгүй барилгын үйл ажиллагаа эрхэлсэн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

50.1.6.энэ хуулийн 14.1.4, 37.1.1, 37.1.2, 37.1.3, 37.1.4, 37.1.5, 37.1.6, 37.1.7, 37.1.8, 37.1.17, 37.4, 37.5, 37.6, 37.8, 41.1, 41.3-т заасан үүргээ биелүүлээгүй барилгын ажлын захиалагчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

50.1.7.энэ хуулийн 12.1, 14.1.4, 38.1, 38.4-т заасан үүргээ биелүүлээгүй зураг төсөл зохиогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

50.1.8.энэ хуулийн 8.4, 14.1.4, 14.6, 16.1, 40.1, 40.3-т заасан үүргээ биелүүлээгүй барилгын ажил гүйцэтгэгчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр барилгын хяналтын улсын байцаагч торгох;

50.1.9.энэ хуулийн 46.1, 46.4-т заасан үүргээ биелүүлээгүй барилга байгууламжийг ашиглагч, эзэмшигчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр барилгын техникийн хяналтын улсын байцаагч торгох;

50.1.10.энэ хуулийн 45 дугаар зүйлд заасныг зөрчсөн гадаадын иргэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр барилгын техникийн хяналтын улсын байцаагч торгох.

50.2.Барилгын хууль тогтоомж зөрчигчид торгууль оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.



50.3.Энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсийг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, гаргасан шийдвэрийг нь шүүгч хүчингүй болгон, бусдад учруулсан хохирлыг нь нөхөн төлүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ  
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**

1.1.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө олгосон барилгын ажлын зөвшөөрлийг барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгч, гэрчилгээ олгох өдөр хүртэл, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг тухайн гэрчилгээнд заасан хугацаа дуустал тус тус хүчин төгөлдөр байна.

**2 дугаар зүйл.**

2.1.Энэ хуулийг Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2008 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан Барилгын тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийн “чанарын баталгаат” гэсний дараа “болон зүгшрүүлэх тохируулах” гэж, мөн зүйлийн 43.7 дахь хэсгийн “банкны баталгаа,” гэсний дараа “даатгалын гэрчилгээ,” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авто замын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.8 дахь хэсэг нэмсүгэй:

“13.8.Замын байгууламжийг барих тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн барилга байгууламжид Барилгын тухай хуульд заасан барилгын ажлын зөвшөөрөл авна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын зарчим, тогтолцоо

2.1.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүүхэд хамгааллын үндсэн зарчим, стандартыг удирдлага болгоно.

2.2.Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

2.3.Хүүхэд хамгаалал гэр бүл төвтэй, дагнасан, шуурхай, тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй байна.

2.4.Хүүхэд хамгааллын тогтолцоо Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан оролцогч талуудаас авч хэрэгжүүлэх бодлого, хамтын ажиллагаа, цогц үйлчилгээ, статистик мэдээлэл, санхүү төсөв, мэргэшсэн хүний нөөц зэргээс бүрдэнэ.

2.5.Хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх, хамгаалах талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухайн үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно.

2.6.Хүүхэд, өсвөр насны хүнийг халамжлах, эмчлэх, удирдан чиглүүлэх, тэдэнд боловсрол олгох үүрэг хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, бусад хүн тэднийг хүмүүжүүлэх, алдаатай зан авирыг нь засахдаа бие махбодийн болон доромжлон гутаасан бүх төрлийн шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно.

### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилнэ.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа хүүхэд, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.3.Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно.

### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд заасан дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг;

4.1.2.“нийгмийн ажилтан” гэж баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг;

4.1.3.“хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг;

4.1.4.“хууль зөрчсөн хүүхэд” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл зөрчил үйлдэж шийтгэгдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг;

4.1.5.“хамтарсан баг” гэж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг;

4.1.6.“хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг;



4.1.7. “хүүхдийн эрхийн ажилтан” гэж хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтныг;

4.1.8. “хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛ, НИЙГЭМ ДЭХ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ**

### **5 дугаар зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал**

5.1. Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна.

5.2. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсч хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

5.3. Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд<sup>1</sup> заасны дагуу үзүүлнэ.

5.4. Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.

### **6 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал**

6.1. Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана.

6.2. Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлнэ.

6.3. Сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн

<sup>1</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 23 дугаарт нийтлэгдсэн.



орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.3.1.сургалтын байгууллагын багш, ажилтан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмших;

6.3.2.сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх;

6.3.3.сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын хоорондын нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

6.3.4.хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх;

6.3.5.хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах.

## **7 дугаар зүйл.Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал**

7.1.Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ.

7.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна.

7.3.Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ.

## **8 дугаар зүйл.Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал**

8.1.Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө



үзүүлэхүйц тоглоом мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална.

8.2.Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

8.3.Хүүхдэд зориулсан мэдээ, мэдээлэл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзсэн иргэн, хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн ажилтан энэ тухай гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлнэ.

8.4.Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.5.Арван зургаан насанд хүрээгүй хүүхэд бусад хүүхдийнхээ эсрэг хийсэн энэ зүйлийн 8.4-т заасан үйлдлээс үүсэх хохирол, хор уршгийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасны дагуу хариуцна.

8.6.Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно.

### **9 дүгээр зүйл.Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал**

9.1.Худалдаа үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд ханган ажиллана.

9.2.Энэ зүйлийн 9.1-д заасан арга хэмжээ, үйлчилгээг зохион байгуулагч хууль, захиргааны хэм хэмжээний акт, гэрээ хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах нөхцөл бүрдсэн, эсхүл хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.



9.3.Энэ зүйлийн 9.1-д заасан арга хэмжээ, үйлчилгээний үед хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзсэн хувь хүн, хуулийн этгээд орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага, албан тушаалтанд, эсхүл цагдаагийн байгууллагад амаар болон бичгээр мэдэгдэнэ.

9.4.Олон нийтийн үйлчилгээ, арга хэмжээний үед хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар<sup>2</sup> зохицуулна.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭ**

#### **10 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ**

10.1.Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараахь хариу үйлчилгээ үзүүлнэ:

10.1.1.мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах;

10.1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх;

10.1.3.аюулгүй байдлыг хангах;

10.1.4.дэмжих, холбон зуучлах;

10.1.5.хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх;

10.1.6.гэр бүлд нь эргэн нэгтгэх.

10.2.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ.

10.3.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна.

10.4.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

<sup>2</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1998 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



## **11 дүгээр зүйл. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах**

11.1. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авна.

11.2. Энэ зүйлд заасан мэдээ, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулж болно.

11.3. Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээлэл гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх бөгөөд тухайн асуудлыг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагад заавал мэдэгдэнэ.

11.4. Энэ зүйлд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж, холбогдох тэмдэглэлийг нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлнэ.

11.5. Хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ.

11.6. Хүүхдийг түр тусгаарлах шийдвэр гарах хүртэл хугацаанд тухайн мэдээ, мэдээллийг хүлээн авсан нийгмийн ажилтан, албан тушаалтан хуульд заасан боломжит арга хэмжээг гэр бүлийн бусад гишүүн, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ.

11.7. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ хуульд заасан тусгаарлах арга хэмжээг авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй.

11.8. Гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан дангаар болон багаар газар дээр нь, эсхүл байгаа орчинд нь очиж үзэх, харилцан ярилцах хэлбэрээр шалгаж болно.



11.9.Энэ хуульд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээлэл хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийн шинжтэй бол хүүхдийн эрхийн ажилтан холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

11.10.Хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэргийг цагдаагийн байгууллагын алба хаагч холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

## **12 дугаар зүйл.Нөхцөл байдлын үнэлгээ хийх**

12.1.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

12.2.Нөхцөл байдлын үнэлгээ хүүхдийн амьдарч байгаа орчин, хүүхдэд үүссэн нөхцөл байдал, хүүхдийн эрхийн эсрэг үйлдэл, эс үйлдэхүйн аюул, эрсдэлийн түвшинг үнэлэх, шалгах, дүгнэх үе шатнаас бүрдэнэ.

12.3.Баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан өөрийн санаачилгаар, эсхүл хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэх явцдаа холбогдох этгээдээс ирүүлсэн мэдээ, мэдээллийг үндэслэн нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

12.4.Нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийх явцдаа тухайн асуудлыг газар дээр нь болон хуульд заасны дагуу холбогдох этгээдээр шийдвэрлүүлэх үндэслэлтэй бол хүүхдэд хувийн хэрэг нээж, зөвлөгөө өгөх, дэмжих, холбон зуучлах үйлчилгээнд хамруулна.

12.5.Эрсдэлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

12.6.Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

## **13 дугаар зүйл.Хүүхдийн аюулгүй байдлыг хангах**

13.1.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг харгалзан Гэр бүлийн тухай<sup>3</sup>, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авна.

<sup>3</sup> Гэр бүлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.





13.2. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг төрийн байгууллага, эсхүл магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч, хуулийн этгээд, гэр бүл, иргэн, эсхүл тэдгээр нь хамтран үзүүлнэ.

13.3. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.

13.4. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хувилбарт үйлчилгээ үзүүлэх санал, дүгнэлтийг хамтарсан баг, нийгмийн ажилтан гаргах бөгөөд гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.

#### **14 дүгээр зүйл. Дэмжих, холбон зуучлах үйлчилгээ**

14.1. Нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх дүгнэлт гарсан бол иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд нийгмийн ажилтан холбон зуучилна.

14.2. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг дэмжих, холбон зуучлах үйлчилгээний хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.

14.3. Хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагын ажилтан, алба хаагч дэмжих, холбон зуучлах үйлчилгээг үзүүлээгүй, эсхүл шаардагдах үйлчилгээг үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол энэ тухай хүүхдийн эрхийн ажилтан тэмдэглэл үйлдэж, төрийн албаны салбар зөвлөл, мэргэжлийн ёс зүйн хороонд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

#### **15 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил үйлчилгээ**

15.1. Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо нь дараахь үйл ажиллагаа явуулна:

15.1.1. гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

15.1.2. сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

15.1.3. гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг

нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

15.1.4.хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;

15.1.5.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

15.1.6.хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;

15.1.7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн<sup>4</sup> үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах;

15.2.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын албаны үүргийг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.

15.3.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хууль зүйн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

15.4.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргах, яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий тухайн шатны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн эмч, цагдаагийн ажилтан, бусад мэргэжилтний бүрэлдэхүүнтэй хамтарсан багийг сум, хорооны Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулна.

15.5.Хамтарсан багийн ажиллах журам, тухайн багийн гишүүдэд урамшуулал олгох журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **16 дугаар зүйл.Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх**

16.1.Хуульд заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдийг боломжтой тохиолдол бүрд гэр бүлд нь эргэн нэгтгэнэ.

16.2.Нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан хүүхэд асрах хувилбарт болон төвлөрсөн асрамжийн үйлчилгээнээс хүүхдийг гэр бүлд нь нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавина.

<sup>4</sup> Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 30 дугаарт нийтлэгдсэн.



## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

### **17 дугаар зүйл.Төрийн байгууллагын хамтын ажиллагаа**

17.1.Төрийн байгууллага хуульд заасан чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна:

17.1.1.хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхдээ тус тусын хуулиар заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах;

17.1.2.хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүнээр тухайн байгууллагын алба хаагч, ажилтныг томилуулахаар санал болгох, үйл ажиллагааг нь дэмжих;

17.1.3.хүүхдийн үүсгэл санаачилгын байгууллага, элчийн үйл ажиллагааг дэмжих, хүүхэд оролцсон арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцож, хяналт тавих;

17.1.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх, хууль зөрчсөн хүүхдийг нийгмийн харилцаанд дасган зохицуулахад хамтран ажиллах.

### **18 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа**

18.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь үйл ажиллагаа явуулах замаар хүүхэд хамгааллын үндэсний болон орон нутгийн тогтолцоог удирдан зохион байгуулна:

18.1.1.хүүхдийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал, хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлыг Монгол Улсын Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн өмнө хариуцан жил бүр тайлагнах;

18.1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх, хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, үйл ажиллагааг нь дүгнэх;

18.1.3.хүүхэд хамгааллын сургалтын хөтөлбөр батлан хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийн талаар мэдлэг, мэдээллийг сайжруулах арга хэмжээг авах, хүүхэд хамгааллын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах;

18.1.4.хүүхэд хамгааллын үйлчилгээний нэр төрөл, чанарыг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;

18.1.5.хүүхэд хамгаалалд бүх шатны төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэн, гэр бүл, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих;

18.1.6.хүүхдийг гэр бүл, нийгмийн бүх орчинд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

18.1.7.төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчид, үйлчилгээ үзүүлэгчдийг сургаж, мэргэшүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

18.1.8.хууль сахиулах байгууллагатай хамтран хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээд, хууль зөрчигч хүүхэд, гэрч, хохирогч хүүхдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах;

18.2.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна:

18.2.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаархи мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох;

18.2.2.төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх,

18.2.3.Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

18.2.4.нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

18.2.5.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах, бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу



эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

18.2.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;

18.2.7.гэр бүлээсээ дайжсан, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг бүртгэх, судалгаанд авах, гэр бүлд нэгтгэх ажлыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэх.

### **19 дүгээр зүйл.Хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтны хүүхэд хамгааллын чиглэлээр явуулах үйл ажиллагаа**

19.1.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

19.1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, тэдний эрх ашгийг хамгаалах, хариу үйлчилгээнд хамруулах;

19.1.2.Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх,

19.1.3.нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;

19.1.4.нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, дуусах хүртэл хүүхдийг хамгаалах;

19.1.5.хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомж зөрчсөн талаар мэдээлэх, уг зөрчлийг арилгуулахаар шаардлага бичих;

19.1.6.эрсдэлт нөхцөлд байгаа, хууль зөрчсөн хүүхдийн талаар бүртгэл, судалгаа хийх, орон нутгийн хүүхэд хамгааллын нөхцөл байдал дүн шинжилгээ хийх.

### **20 дугаар зүйл.Нийгмийн ажилтны эрх зүйн байдал**

20.1.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, дүүрэг, баг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна.



20.2.Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм, түүнд тавих шаардлагыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлийн холбоодтой зөвшилцөн батална.

20.3.Нийгмийн ажилтан хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа талаархи мэдээлийг хүлээн аваад тухайн газар дээр очиж шалгах, тухайн хүүхэдтэй нөхцөл байдлын талаар харилцан ярилцах, хуулиар хориглоогүй мэдээлэл цуглуулах эрхтэй.

20.4.Нийгмийн ажилтан өөрийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөлд хүүхдэд эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх шаардлагатай болсон тохиолдолд цагдаагийн байгууллагын туслалцааг авна.

20.5.Нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүргийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хариуцна.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, САНХҮҮЖИЛТ**

#### **21 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт**

21.1.Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

21.2.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна.

21.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

21.4.Олон улсын төрөлжсөн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын талаар хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж болно.

21.5.Гадаад улсын байгууллага, хуулийн этгээд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт, судалгаа хийхийг хориглоно.



21.6.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын нөхцөл байдал, тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын талаар жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд тайлагнана.

## **22 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын хяналт, шинжилгээ, үнэлгээ**

22.1.Хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээг үнэлэх зорилгоор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараахь хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ:

22.1.1.орон нутаг, анхан шатны нэгжээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бүртгэл, судалгааг нэгтгэн дүгнэх;

22.1.2.хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдийн талаар бүртгэл, судалгааг цагдаагийн болон хууль сахиулах бусад байгууллагатай хамтран гаргаж, дүн шинжилгээ хийх;

22.1.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, түүний үр дүнг үнэлж, шалгах;

22.1.4.хүүхэд хамгаалалд төрийн байгууллагуудын оролцоог үнэлэх;

22.1.5.хүүхэд хамгааллын хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, сургалтын чанар, үр нөлөөг үнэлэх;

22.1.6.хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх;

22.1.7.Хууль тогтоомжийн тухай хуульд<sup>5</sup> заасан аргачлалын дагуу Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх.

## **23 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын санхүүжилт**

23.1.Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

23.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

<sup>5</sup> Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

**24 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид  
хүлээлгэх хариуцлага**

24.1.Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар тус тус тодорхойлно.

**25 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

25.1.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

25.2.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.7 дахь заалтыг Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3 дахь хэсгийн “14” гэснийг “15” гэж, мөн зүйлийн 109.6 дахь хэсгийн “109.1-109.3-т” гэснийг “109.1, 109.3-т” гэж, 141 дүгээр зүйлийн 141.1.6 дахь заалтын “15000-30000” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, эсхүл түүнийг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” гэснийг “Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон” гэсний дараа “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг” гэж, 13.2.2 дахь заалтын “гэр бүлдээ авч асрамжилж байгаа” гэсний дараа “хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн дараахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт:**

“3.1.3.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг”

**2/18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт:**

“18.2.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ЯЛЛАГДАГЧИД ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

#### **1/12 дугаар зүйлийн 12.1.10 дахь заалт:**

“12.1.10.хүүхэдтэй ажиллах улсын болон хувийн өмгөөлөгчийг мэргэшүүлэх сургалтад хамруулах.”

#### **2/19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт:**

“19.1.5.хүүхдийн хувьд эцэг, эх нь сайн дураараа, өөрийн зардлаар хувийн өмгөөлөгч авахыг хүссэн.”

**2 дугаар зүйл.**Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.3.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Дархлаажуулалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” гэснийг “Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай” гэж өөрчилсүгэй.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэж Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүүхдийг” гэснийг “Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” гэснийг “Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

“3.Эцэг, эх буюу хууль ёсны хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхдийг Монгол Улсын хилээр авч гарах тохиолдолд хууль сахиулах байгууллага хяналт тавьж, хүүхэд хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомж

2.1. Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Гэр бүлийн тухай<sup>3</sup>, Хүүхэд хамгааллын тухай, энэ

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Гэр бүлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.



хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Хүүхдийн эрхийн зарчим, нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг хэрэглэж болно.

### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ.

3.2.Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна.

### **4 дүгээр зүйл.Хүүхдийн эрхийн үндсэн зарчим**

4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална:

4.1.1.хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;

4.1.2.төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;

4.1.3.хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;

4.1.4.хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах;

4.1.5.хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ, мэдээллээр хангах.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮҮХДИЙН ЭРХ, ЭЦЭГ, ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ХАРГАЛЗАН ДЭМЖИГЧИЙН ҮҮРЭГ**

### **5 дугаар зүйл.Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх**

5.1.Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй бөгөөд хүүхэд гадаадын харьяат болох, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд Монгол Улсын харьяат болох асуудлыг Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр зохицуулна.

5.2.Хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй.



5.3.Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй.

5.4.Хүүхэд төрөөс эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах эрхтэй.

5.5.Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга болон түр оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга болон түр оршин суух, эх орондоо амьдрах эрхтэй.

## **6 дугаар зүйл.Хүүхдийн хөгжих эрх**

6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ:

6.1.1.хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших;

6.1.2.хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;

6.1.3.хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах;

6.1.4.хүүхэд шашин шүтэх, эс шүтэх;

6.1.5.хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;

6.1.6.хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх.

6.2.Хүүхэд хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр эдэлнэ.

## **7 дугаар зүйл.Хүүхдийн хамгаалуулах эрх**

7.1.Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.



7.2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.

7.3.Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй.

7.4.Хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.

7.5.Хүүхдийн хамгаалагдах эрхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

## **8 дугаар зүйл.Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх**

8.1.Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхтэй бөгөөд хүүхэд нийгмийн амьдралд оролцоходоо дараахь эрх эдэлнэ:

8.1.1.хүүхэд нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх;

8.1.2.хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох;

8.1.3.хүүхэд өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх;

8.1.4.хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах;

8.1.5.хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах.

## **9 дүгээр зүйл.Хүүхдийн хүмүүжил, төлөвшил**

9.1.Хүүхдийг хүмүүжүүлэх нь хүүхдэд бие хүний сайн сайхан шинж байдал зөв үйл, ёс суртахууны үнэт чанарыг төлөвшүүлэх тасралтгүй үйл ажиллагаа байх бөгөөд хүүхдийг хүмүүжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

9.1.1.эцэг эхээ хайрлах, бусдыг хүндэтгэх, туслах;



9.1.2.эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах;  
9.1.3.зохих насанд нь сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол эзэмшүүлэх;

9.1.4.хууль ёсыг сахих, үндэсний өв уламжлалаа дээдлэн хүндэтгэх;

9.1.5.эрүүл мэнд болон өөрийгөө хамгаалах, амьдрах арга ухааны дадал, чадвар эзэмшүүлэх;

9.1.6.оюун ухаан, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх.

### **10 дугаар зүйл.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг**

10.1.Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь доор дурдсан үүрэг хүлээнэ:

10.1.1.хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх;

10.1.2.хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх;

10.1.3.хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

10.1.4.хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах;

10.1.5.хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах;

10.1.6.хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах;

10.1.7.хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах;

10.1.8.хүүхдийг хөгжиж, төлөвшихэд нь дэмжин туслах;

10.1.9.хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх;

10.1.10.хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах;

10.1.11.хууль тогтоомжид заасан бусад.





10.2.Эцэг, эх тусдаа амьдрах, гэрлэлтээ цуцлуулсан нь тэднийг энэ зүйлийн 10.1-д заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХАД ТӨР, ИРГЭН,  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО**

**11 дүгээр зүйл.Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах  
байгууллагын бүрэн эрх**

11.1.Хүүхдийн эрхийг хангах талаар Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.хүүхдийн эрхийг хангах талаархи төрийн болон орон нутгийн бодлогыг тодорхойлох;

11.1.2.хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөв батлах;

11.1.3.хүүхдийн эрхийн талаархи хууль тогтоомжид хяналт тавих.

**12 дугаар зүйл.Засгийн газрын үүрэг, оролцоо**

12.1.Хүүхдийн эрхийг хангахад Засгийн газар дараахь шийдвэр гаргаж, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

12.1.1.хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого боловсруулах;

12.1.2.хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

12.1.3.хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

12.1.4.хүүхдийн амралт, чөлөөт цагийг хөгжилд чиглүүлэх бодлогыг дэмжиж, хүүхдийн зусланд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төслийг өмчийн хэлбэр харгалзахгүй санхүүжүүлэх журам батлах;

12.1.5.хүүхдийн санаачилсан шинэ бүтээл, урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам баталж, хэрэгжүүлэх;



12.1.6.хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа болон хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрт шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулах;

12.1.7.онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам батлах, шаардлагатай арга хэмжээ тухай бүр авах.

### **13 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, оролцоо**

13.1.Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тэргүүлэх чиг үүргийг гүйцэтгэнэ:

13.1.1.хүүхдийн эрхийг хангах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг Засгийн газрын өмнө хариуцах;

13.1.2.хүүхдийн эрхийн талаархи Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийн Засгийн газрын тайланг боловсруулж, Засгийн газарт танилцуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх, олон улсын байгууллагын зөвлөмжийг олон нийтэд сурталчлах, зөвлөмжийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

13.1.3.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

13.1.4.хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, хүүхдийн санал, санаачилгаар бий болсон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг төсөвт тусгаж батлуулах;

13.1.5.хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг дэмжих;

13.1.6.хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, хүүхдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд үнэлгээ өгөх;

13.1.7.төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх;

13.1.8.хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах.



#### **14 дүгээр зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг, оролцоо**

14.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүүхдийн эрхийг хангах талаар дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1. хүүхдийн эрхийг хангах, хамгаалах талаархи хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

14.1.2. хүүхдийн эрхийг хангах талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

14.1.3. орон нутгийн салбар, нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, бусад байгууллагын уялдаа холбоог зохицуулах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;

14.1.4. хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хуулиар заасан чиг үүргийг хэрэгжүүлэх замаар хяналт тавих;

14.1.5. хүүхдийн асуудал эрхэлсэн бүх шатны ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

14.1.6. хүүхдийн эрхийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах;

14.1.7. хүүхдийн эрхийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж урамшуулах;

14.1.8. хүүхэд гишүүнчлэлтэй болон эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, байр танхимаар хангах;

14.1.9. хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

14.1.10. хууль тогтоомжид заасан бусад.

14.2. Энэ хуулийн 14.1.6-д заасан сан бүрдүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

14.3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сургалт, судалгаа, мэдээллийн төвтэй байх бөгөөд төвийн ажиллах дүрмийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.



## **15 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын үүрэг, оролцоо**

15.1. Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ажилтан нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1. тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.1.2. тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих;

15.1.3. эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

15.1.4. хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн ажлыг гэр бүл, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

15.1.5. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн тухайн шатны байгууллага, ажилтан нь хүүхэд, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвлөгөө, мэдээллээр хангах, шаардлагатай бол сургалт зохион байгуулах, нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжиж, арга зүйн удирдлагаар хангах;

15.1.6. энэ хуулийн 14.2-т заасан журмын дагуу анхан шатны байгууллага, ажилтан, хамтран ажиллаж байгаа хуулийн этгээдээс мэдээ тайлан авч, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хянах, холбогдох мэдээллийг нэгтгэн төв байгууллагад хүргүүлэх;

15.1.7. хүүхэд гишүүнчлэлтэй болон эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг төрөөс дэмжин, байр, танхимаар хангах;

15.1.8. хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

15.1.9. хууль тогтоомжид заасан бусад.

15.2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн нийгмийн ажилтны ажлын шалгуур үзүүлэлтийг хүүхдийн эрхийг хангах талаар явуулсан ажил, үйлчилгээний үр дүнгээр үнэлнэ.



15.3.Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, хэлтэс, газарт болон сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ажилтан нь хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байна.

### **16 дугаар зүйл.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл**

16.1.Хүүхдийн эрхийг хангах талаархи салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт Хүүхдийн төлөө зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.

16.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн төлөөлөл оролцох бөгөөд бүрэлдэхүүнийг Зөвлөлийн тэргүүн батална.

16.3.Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийг тухайн зөвлөл батална.

16.4.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

16.4.1.хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах;

16.4.2.хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх.

16.5.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тусын чиг үүргийн дагуу гүйцэтгэнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **17 дугаар зүйл.Бүх шатны Засаг даргын үүрэг, оролцоо**

17.1.Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхдийн эрхийг хангах талаар дараахь арга хэмжээ авна:

17.1.1.тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийг тэргүүлэх;



17.1.2.хүүхдийн эрхийг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авах, энэ талаар гарсан санал, санаачилгыг дэмжих, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

17.1.3.тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;

17.1.4.хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ, сургалт, хүмүүжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг дэмжих, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

17.1.5.хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах, хүүхдэд зориулсан барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, зориулалтын дагуу ашиглуулах;

17.1.6.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

### **18 дугаар зүйл.Иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо**

18.1.Хүүхдийн эрхийг хангах талаар иргэн, хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

18.1.1.хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

18.1.2.хүүхдэд эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхэд санаачлага гаргах, дэмжих;

18.1.3.иргэний болон нийгмийн хариуцлагын хүрээнд хандив, туслалцаа үзүүлэх, хөрөнгө оруулах;

18.1.4.хүүхдээ хүмүүжүүлж, үлгэр жишээ үзүүлсэн иргэнийг урамшуулах, шагнах;

18.1.5.хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих;

18.1.6.хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгааллын асуудлаар төрийн байгууллага, хуулийн этгээдээс зохион байгуулсан арга хэмжээнд оролцоход эцэг, эхэд нь ажлын чөлөө олгох.



## **19 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн талаар мэдээлэл өгөх, гомдол, нэхэмжлэл гаргах**

19.1. Хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар хууль тогтоомжид заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргана.

19.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, баг, сум, хорооны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан нь хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан журмын дагуу төрийн байгууллагад гомдол, хүсэлт, шүүхэд нэхэмжлэл, холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдэд хүсэлт, шаардлага гаргаж болно.

19.3. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, хүүхэд хамгаалахтай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.

## **20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах**

20.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, тэдгээрийн хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтнаар дамжуулан хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавина.

20.2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчийн эрх эдлэх бөгөөд хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшиж, сургалтад хамрагдсан ажилтанд улсын байцаагчийн эрх олгоно.

20.3. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлсэн сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр таваас доошгүй жил ажилласан, хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байна.

20.4. Улсын байцаагчийн эрх бүхий ажилтан нь хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулна.

20.5. Хүүхдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгэмд тодорхой байр суурь эзэлсэн насанд хүрсэн хүнийг сум, дүүргийн хүүхдийн чуулганаас хүүхдийн элчээр өргөмжилж болно.

20.6. Хүүхдийн элч нь харьяа сум, дүүргийнхээ хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг холбогдох ажилтан, байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.



20.7.Хүүхдийн элчийг сонгон ажиллуулах журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрх бүхий байгууллагатай хамтран батална.

### **21 дүгээр зүйл.Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн тайлан**

21.1.Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу Олон Улсын төрөлжсөн байгууллага (Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний салбар байгууллага)-д Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар үндсэн тайланг заасан хугацаанд төрийн байгууллагаас хүргүүлэх бөгөөд хүүхэд, олон нийт, иргэний нийгмийн оролцоотой гаргана.

21.2.Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн тайланг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулах бөгөөд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, шүүхийн захиргаа, прокурорын байгууллага, Хүний эрхийн үндэсний комиссын албан тушаалтан, мэргэжилтнийг заавал оролцуулна.

21.3.Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн тайланг хүргүүлэх хугацааг Монгол Улсын олон улсын гэрээнд тодорхой заасан бол зургаан сарын өмнө талуудын оролцоог бүрэн хангасны үндсэн дээр боловсруулж, хэлэлцүүлсэн байна.

21.4.Олон Улсын байгууллагад хүргүүлэх хүүхдийн эрхийн хэрэгжилтийн хөндлөнгийн тайланг хүүхэд, олон нийтийн болон хүүхдийн эрхийн чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллага хүргүүлж болно.

21.5.Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргаагүй, хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлээгүй ажилтан, албан тушаалтанд Төрийн албаны тухай<sup>4</sup> хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

21.6.Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар Олон Улсын байгууллагаас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар зохион байгуулна.

### **22 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

22.1.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

<sup>4</sup> Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1996 оны 05 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүүхдийн эрхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “цэцэрлэг” гэсний өмнө “хүүхдийн тоглоомын талбай” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүүхдийн эрхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.**Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо,

баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## **2 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж**

2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

## **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

## **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;

4.1.2.“хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3.“тохирох хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.4.“түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



4.1.5. “хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;

4.1.6. “боломжит дээд хэмжээ” гэж тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч алдагдсан чадварыг нь сэргээж болох дээд хэмжээ;

4.1.7. “урьдчилан сэргийлэх” гэж иргэн, хамт олны оролцоотойгоор өвчин эмгэг, осол гэмтлийн эрсдэлээс хамаарах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, өвчин эмгэгийг эрт илрүүлж эмчлүүлэх, тэдгээрээс үүдэн гарах эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах үйл ажиллагааг;

4.1.8. “туслах хэрэгсэл” гэж биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах, хамгаалах, дэмжих, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

4.1.9. “асаргаа сувилгааны хэрэгсэл” гэж асруулж байгаа хүний эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах, асарч байгаа хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

4.1.10. “ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын эрүүл ахуйн шаардлагыг хангах, зайлшгүй хэрэгцээтэй материал хэрэгслийг;

4.1.11. “бие даан амьдрах эрх” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломжийг;

4.1.12. “хөтөч нохой” гэж хараагүй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах зорилгоор тусгайлан сургаж, бэлтгэсэн нохойг;

4.1.13. “дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг.

## **5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим**

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараах зарчмыг баримтална:

5.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих;



5.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх;

5.1.3.сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх;

5.1.5.хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх;

5.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАРИЛЦААНД ТЭГШ ОРОЛЦОХ ЭРХ**

### **6 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах**

6.1.Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

6.2.Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.

6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.3.1.нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй байх;



6.3.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх;

6.3.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандах;

6.3.4.хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгааны улмаас зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

6.3.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхийг өөрийн нь зөвшөөрөлгүйгээр хязгаарлах;

6.3.6.төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх.

6.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.4.1.ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах;

6.4.2.хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;

6.4.3.байгууллага, аж ахуйн нэгж нь ажиллагсадыг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам, удирдлагын арга барилыг хэрэглэх, ашиглах;

6.4.4.гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;

6.4.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдлэг ур чадвар, онцлогт тохирсон ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох;

6.4.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон ажлын байрны тохирох хэрэглэгдэхүүн бий болгохгүй байх.

6.5.Дараахь үйлдлийг бусад ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:



6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх, хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

6.5.2.гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх;

6.5.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг үр хүүхдээ асрамжиндаа авах эрхийг хязгаарлах.

6.6.Төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

6.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийг нь бодитой хангах зорилгоор онцлогт нь тохируулан авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

## **7 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх**

7.1.Гэр бүл болон нийгмийн бүхий л хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

7.1.2.Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого хэрэгжүүлэх;



7.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх эерэг хандлагыг төлөвшүүлэх асуудлыг бүх шатны боловсролын байгууллагын сурах бичигт тусгайлан тусгаж, сургалт, хичээлийн агуулгаар дамжуулан хэрэгжүүлэх;

7.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлд өгөх, сургалт, сурталчилгаа явуулах арга хэмжээг зохион байгуулах;

7.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх, түүнд чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, гэр бүл, иргэдийн санал санаачлагыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаархи эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгыг агуулсан арга хэмжээг зохион байгуулан холбогдох зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган шийдвэрлэх.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын оролцоог хангана.

7.3.Энэ хуулийн 7.1.4-т заасан арга хэмжээг зохион байгуулах ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалдаг байгууллагатай гэрээгээр гүйцэтгүүлж болох ба холбогдох зардлыг Нийгмийн халамжийн сангаас гаргана.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ АЖИЛЛАЖ АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

#### **8 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ**

8.1.Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

8.2.Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.

8.3.Төрийн байгууллага нь нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн баримт бичгийг боловсруулах, хяналт шалгалт хийх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба холбогдох зардлыг улсын төсөвт тусгана.

8.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах, түүнд мэдээлэл харилцааны технологийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, хувцас, орон байр, ахуйн хэрэгслээр хангах арга хэмжээг авч, зардлыг барилга, зам, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

### **9 дүгээр зүйл.Орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

9.1.Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөлийг энэ хууль, хот байгуулалтын болон барилгын тухай хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх ажлыг иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.

9.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн авто болон явган хүний зам, замын байгууламжийн заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилга, зам, тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.

9.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилгын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

9.4.Орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах барилгын комиссын бүрэлдэхүүний дөрөвний нэгд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.





9.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно.

### **10 дугаар зүйл.Нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

10.1.Нийтийн тээврийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

10.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоол, үйлчилгээний заавал мөрдөх үндэсний стандартыг тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.

10.3.Нийтийн тээврийн байгууллага энэ хуулийн 10.2-т заасан стандарт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах үүрэгтэй.

### **11 дүгээр зүйл.Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

11.1.Мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

11.2.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.2.1.төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох;

11.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах дэлгэц уншигч, программ хангамж болон шинэ технологи, систем, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг эх хэл дээрээ ашиглах боломжийг бий болгох;

11.2.3.ном, сурах бичиг, сонин сэтгүүл, төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, барааны шошго зэрэг бүх төрлийн хэвлэмэл материалыг хүртээмжтэй ашиглахад зориулсан бар кодтой хэвлэх;

11.2.4.цахим хуудас болон телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст



унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

11.2.5.төрийн болон нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, бичигч, уншигч, хөтөчийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

11.2.6.хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэх зорилгоор байгуулагдсан ашгийн бус радио, телевизийг төрөөс дэмжих.

11.3.Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 11.2.1, 11.2.2, 11.2.3, 11.2.4-т заасан арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох байгууллагатай хамтран хангаж, шаардагдах зардлыг улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авна.

11.4.Сонсголын бэрхшээлтэй хүнцагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлнэ.

## **12 дугаар зүйл. Монгол дохионы хэл**

12.1.Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй.

12.2.Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

## **13 дугаар зүйл.Брайль үсгийн стандарт**

13.1.Брайль бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайль бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана.

13.2.Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага батална.



## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ**

### **14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх**

14.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

14.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдрын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох;

14.1.2. хувь хүний чадамж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;

14.1.3. бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг тусалцаа үзүүлэх;

14.1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах.

14.2. Бүх шатны боловсролын байгууллага нь энэ хуулийн 37.2.1-д заасан комиссын дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг бүх шатны боловсролын байгууллага хэрэгжүүлэх орчныг бүрдүүлж, бэлтгэл ажлыг хангаж, боловсрол эзэмшүүлнэ.

14.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, боловсрох, мэргэжил эзэмших эрхийг хангах чиглэлээр төрөөс энэ хуулийн 14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4-т зааснаас гадна дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

14.3.1. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулах;

14.3.2. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээх.



14.4.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлэхэд нь боловсролын байгууллагын болон нийгмийн ажилтан холбогдох мэдээллээр хангах үүрэгтэй.

14.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална.

### **15 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл**

15.1.Бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжил олгох төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

15.1.1.тухайн суралцагчийн онцлогт тохирсон хамгийн зохистой арга хэлбэрээр боловсрол олгох;

15.1.2.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэгслээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;

15.1.3.сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг явуулах;

15.1.4.сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн багш, сурган хүмүүжүүлэгч явуулдаг байх;

15.1.5.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвхи, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайль үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

15.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бие дааж амьдрах чадвар олгох, бүрэн болон бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн бол цаашид суралцах, эсхүл хөдөлмөр эрхлэх, мэргэжлээ сонгоход нь туслалцаа үзүүлэх;

15.1.7.элсэлтийн шалгалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд нээлттэй, хүртээмжтэй, онцлог хэрэгцээ, шаардлагыг нь хангасан орчин, нөхцөлд авах;

15.1.8.боловсролын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй оюутныг ажил олгогчдод танилцуулах, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулах.



15.2.Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

15.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

15.4.Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тухайн сургалтын байгууллагын мэргэжил арга зүйн зөвлөл, эцэг, эхийн оролцоотойгоор боловсруулж батална.

15.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн явц, ахицын өөрчлөлтийг сургууль, цэцэрлэгийн удирдлага эцэг, эхийн оролцоотой хэлэлцэж, дүгнэлтийг энэ хуулийн 37.2.1-д заасан комисст хүргүүлнэ.

15.6.Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг сургалтын төрийн сан хариуцна.

15.7.Ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн тухайн жилийн төсөвт тусгана.

15.8.Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

15.9.Энэ хуулийн 15.7-д заасан ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт, зардлын хэмжээ, олгох журмыг боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

15.10.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь харьяалах засаг захиргааны нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны боловсролын байгууллагыг энэ хуулийн 15.1-д заасан сургалтын орчныг бүрдүүлэхэд зориулж тусгай хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж, холбогдох зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэнэ.



15.11.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын онцлог хэрэгцээг хангах сургалтын хөтөлбөр, ном, сурах бичиг, гарын авлага, дохионы хэлний толь бичиг зохиох, хэвлэх, түгээх, засан сайжруулах, брайль болон программ хангамжийг монгол хэл рүү хөрвүүлэх, сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авах болон шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

#### **16 дугаар зүйл.Багшийн мэргэжил**

16.1.Багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах агуулга, арга зүйг тусгана.

16.2.Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна.

16.3.Энэ хуулийн 16.2-т заасан арга зүй, арга барилыг олгох сургалт болон зөвлөх үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллага гүйцэтгэж болно.

16.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлний багш, сэтгэл зүйч, арга зүйчийг сургалтын төрийн сангийн зардлаар дотоод, гадаадад сургаж бэлтгэнэ.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

#### **17 дугаар зүйл.Хөдөлмөрлөх эрх**

17.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвших, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй.

17.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Хөдөлмөрийн тухай хууль<sup>2</sup>, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль<sup>3</sup>, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль<sup>4</sup> болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

<sup>2</sup> Хөдөлмөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 40 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 11 дугаарт нийтлэгдсэн.



17.3.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй.

17.4.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангахдаа энэ хуулийн 6.4-д заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

17.5.Цалин хөлс олгож байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг зогсоохыг хориглоно.

17.6.Холбогдох хуульд заасан шалгуурыг ханган, нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн хөгжлийн бэрхшээлтэй хүний халамжийн тэтгэврийг Нийгмийн халамжийн тухай хуулийн<sup>5</sup> дагуу зохицуулна.

## **18 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих**

18.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтэд төрөөс дараахь дэмжлэг үзүүлнэ:

18.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгохыг урамшуулах;

18.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх чадварт тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгох, тэдгээрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтад тэргүүн ээлжинд хамруулах;

18.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэргэжлээрээ ажиллахад шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

18.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

18.1.5.мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох

<sup>5</sup> Нийгмийн халамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.



ба урамшуулал олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах;

18.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх.

### **19 дүгээр зүйл.Ажлын байрны сонгон шалгаруулалт**

19.1.Төрийн байгууллага, хуулийн этгээд нь ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт зарлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээг харгалзан үзнэ.

19.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүн нээлттэй сонгон шалгаруулалтад оролцоходоо түүний хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээ, шаардлагад тохирох тусламж, нэмэлт цаг ашиглах эрхтэй.

19.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ хуулийн 19.2-т заасан хэрэгцээ, шаардлагын талаар хүсэлт гаргасан тохиолдолд сонгон шалгаруулалт явуулж байгаа байгууллага хүсэлтийг хүлээн авах үүрэгтэй.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

### **20 дугаар зүйл.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**

20.1.Төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20.2.Эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах орчныг бүрдүүлэх, техник, тоног төхөөрөмж, эм, эмнэлэг, асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, эрт илрүүлгийн урвалж бодисын зардлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган шийдвэрлэнэ.

### **21 дүгээр зүйл.Хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл**

21.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл авах зардлыг Нийгмийн даатгалын, Үйлдвэрийн осол, мэргэжлээс





шалтгаалах өвчний даатгалын, Тэтгэмжийн даатгалын, Эрүүл мэндийн даатгалын, Нийгмийн халамжийн сангаас тус тус санхүүжүүлнэ.

**ДОЛДУГААР БҮЛЭГ  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ ХАМТ  
ОЛОНД ТҮШИГЛЭН ХАМРУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ**

**22 дугаар зүйл.Хамт олонд түшиглэн хамруулан  
хөгжүүлэх үйлчилгээ**

22.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг дараахь чиглэлээр үзүүлнэ:

22.1.1.өвчин, эмгэг, гэмтэл, бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн эрүүл мэндийн чиглэл;

22.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил боловсрол, мэргэжил эзэмшихийг дэмжих боловсролын чиглэл;

22.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүл, хамт олондоо эдийн засгийн хувьд хувь нэмрээ оруулахыг дэмжих хөдөлмөрийн чиглэл;

22.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүн, гэр бүл, хамт олны дунд бусдын адил үүрэг хариуцлага хүлээсэн, идэвхтэй, бие даасан гишүүн болохыг дэмжих нийгмийн чиглэл;

22.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн бүхий л харилцаанд оролцохыг дэмжих дэд бүтэц, зам тээвэр, мэдээллийн технологийн хүртээмжийн.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

**23 дугаар зүйл.Хамт олонд түшиглэн хамруулан  
хөгжүүлэх үйлчилгээ эрхлэх**

23.1.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээг өмчийн бүх хэлбэрийн байгууллага үзүүлнэ.

23.2.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий тусгай зөвшөөрөлтэй төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тохиолдолд зардлыг бүрэн болон хэсэгчлэн тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

23.3.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээний стандартыг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,



хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

23.4.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээг эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулж батална.

#### **24 дүгээр зүйл.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний хөтөлбөр**

24.1.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь тухайн хүний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

24.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийг энэ хуулийн 37.8-д заасан дүгнэлтийн дагуу хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээнд заавал хамруулах үүрэгтэй.

#### **НАЙМДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ХАЛАМЖ**

#### **25 дугаар зүйл.Нийгмийн хамгаалал хүртэх эрх**

25.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хоол хүнс, хувцас, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

25.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглээний протез, ортопед, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, асаргаа сувилгааны болон бусад туслах хэрэгслээр хангах;

25.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлж, туслах үйлчилгээ авах боломжоор хангах;

25.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулах.

25.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах орон сууцны



хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний болон аймаг, нийслэлийн Засаг даргын жил бүрийн төсөвт тусгана.

25.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, нийгмийн даатгалд хамруулах асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.

## **26 дугаар зүйл.Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт**

26.1.Энэ хуулийн 3.1-д заасан хүнд нийгмийн халамжийн сангаас доор дурдсан тусламж, хөнгөлөлт үзүүлнэ:

26.1.1.байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

26.1.2.18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;

26.1.3.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезын үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох;

26.1.4.18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

26.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх;

26.1.6.насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;

26.1.7.дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:

26.1.7.а.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;

26.1.7.б.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь;

26.1.7.в.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь.

26.1.8.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан, сувилалд дараалал харгалзахгүйгээр сувилуулах;

26.1.9.бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

26.1.10.нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

26.1.11.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

26.1.12.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн төлбөрийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

26.1.13.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;

26.1.14.хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;

26.1.15.нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон



хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгох;

26.1.16.аарцаг эрхтэний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх.

26.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж болно.

26.3.Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн болон тэдгээрийг асран хамгаалагчийг нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламжид хамруулна.

26.4.Энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4, 26.1.5, 26.1.6-д заасан тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журам, жишиг үнийг Засгийн газар батална.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ БУСАД ЭРХ**

### **27 дугаар зүйл.Хууль зүйн туслалцаа авах эрх**

27.1.Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

27.2.Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай хууль зүйн зөвөлгөө, тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

27.3.Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүнд түүний эрх, үүрэг болон холбогдох мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлаж өгнө.

27.4.Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах ба үйлчилгээний зардлыг улсын төсөвт тусгана.



## **28 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх**

28.1.Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, тэдэнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээг гэр бүл, хамт олонд нь түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хүүхдийн хөгжлийн төвийг байгуулан, хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд тусгай хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг төрөөс дэмжинэ.

28.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол болон сэргээн засах үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

28.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамруулна.

28.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын болон төрийн эрх бүхий холбогдох байгууллага хэрэгжүүлнэ.

28.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой аливаа бодлого, шийдвэрийг гаргах явцад тэднийг үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана.

28.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгоход төрөөс дэмжлэг үзүүлнэ.

28.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргийг тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээх бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг хориглоно.

28.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд тэтгэлэг төлөгч нь холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу нэмэлт тэтгэлэг төлнө.

## **29 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх**

29.1.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийг боловсрол, хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн салбарт хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

29.1.1.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх;



29.1.2. хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтанд өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах;

29.1.3. гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэшлийн түвшинд чанартай үзүүлэх;

29.1.4. гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх.

### **30 дугаар зүйл. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох**

30.1. Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

30.2. Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна.

30.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй.

30.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.

### **31 дүгээр зүйл. Хувийн нууцыг хүндэтгэх**

31.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний захидал харилцаа, эрүүл мэнд, эд хөрөнгө, гэр бүлийн нууц болон нэр төр, алдар хүндийг холбогдох хууль тогтоомжоор хамгаална.

31.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа аливаа этгээд хөгжлийн бэрхшээлтэй хүний нууцыг задруулахыг хориглоно.

### **32 дугаар зүйл. Бие даан амьдрах эрх**

32.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй.

32.2. Хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрх нь хангагдана.



32.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг иргэн, хуулийн этгээд үзүүлж болно.

32.5.Бие даан амьдрахад дэмжих үйлчилгээг үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтыг нийслэл, аймгийн халамжийн үйлчилгээ хариуцсан төрийн байгууллага гүйцэтгэнэ.

32.6.Энэ хуулийн 32.2, 32.3, 32.4, 32.5-ыг хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын оролцоог хангана.

32.7.Төрөөс хараагүй хүнийг тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах хөтөч нохойг тусгайлан сургаж бэлтгэх ба дотоодод сургаж бэлтгэсэн хөтөч нохойны үнийг есөн жилд нэг удаа олгоно. Хөтөч нохойг сургах, түүнийг хэрэглэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

### **33 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих**

33.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцсон биеийн тамир, спортын тэмцээн, уралдаан нь түүний чадавхид зохицсон байна.

33.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд оролцоход нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.

33.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулахад төрөөс дараахь дэмжлэг үзүүлнэ:

33.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүн биеийн тамир, спортоор хичээллэх, өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд дэмжих үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх;

33.3.2.биеийн тамир, спортын байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүн тэмцээн уралдаан, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оролцох, бэлтгэл сургуулилт хийхэд тохиромжтой заал, талбай болон тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон байх;

33.3.3.хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг олимп, паралимп, тусгай олимп, дифлимп, дэлхийн, тивийн хэмжээний олон улсын тэмцээнд холбогдох журмын дагуу шалгаран явахад нь хуульд заасны дагуу дэмжлэг үзүүлэх.





33.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн олимп, паралимп, дифлимп, тусгай олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тохиолдолд түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох тэтгэвэртэй нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн урамшуулал олгоно.

33.5. Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, хүүхэд олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тохиолдолд Засгийн газраас баталсан жишгийн дагуу мөнгөн урамшуулал олгоно.

### **34 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих**

34.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өөрийн оронд зохиогдох соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцоход төрөөс дэмжинэ.

34.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн соёл, урлагийн арга хэмжээнд оролцох, өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### **35 дугаар зүйл. Соёл, урлагийн бүтээлийн хүртээмж**

35.1. Соёл, урлагийн бүтээл нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

35.2. Уран зохиол, шинжлэх ухааны ном, сонин, сэтгүүлийг хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах, хэрэглэх боломжтойгоор орчин үеийн арга, техник, технологи ашиглан хэвлэх, бүтээх, түүнчлэн музей, номын сан, соёл, урлагийн бүтээлийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

### **36 дугаар зүйл. Онцгой байдлын үед авах арга хэмжээ**

36.1. Хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал зэрэг онцгой байдал бий болох үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах үүргийг төрийн холбогдох байгууллага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.

## **АРАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭСЭХИЙГ ТОГТООХ**

### **37 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох**

37.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараахь шалгуураар тогтооно:

37.1.1.эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, ангилал, хугацаа;

37.1.2.биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын ангилал.

37.2.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараахь комисс /цаашид “Комисс” гэх/ тогтооно:

37.2.1.0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс;

37.2.2.16 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс;

37.2.3.хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс.

37.3.Энэ хуулийн 37.2.1-д заасан комисс хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд, 37.2.2-т заасан комисс нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд тус тус ажиллана.

37.4.Энэ хуулийн 37.2.1, 37.2.2-т заасан комисс нь орон тооны бус салбар комиссстой байна.

37.5.Энэ хуулийн 37.2.1-37.2.3-т заасан комиссын дүрмийг Засгийн газар батална.

37.6.Энэ хуулийн 37.2.1-д заасан хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох, хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг боловсруулах аргачлалыг эрүүл мэнд, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

37.7.Энэ хуулийн 37.2.2-т заасан хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох аргачлалыг эрүүл мэнд, хөдөлмөр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.



37.8.Комисс өөрийн эрх хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, хугацаа, ангилалыг тогтоож, дүгнэлт гаргана.

37.9.Энэ хуулийн 37.2.2-т заасан комиссоос гаргасан дүгнэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт бичиг болно.

### **38 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэх**

38.1.Энэ хуулийн 37.2-т заасан комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.

38.2.Энэ хуулийн 38.1-д заасан үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болно.

38.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд бүртгэл, статистикийн төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгнө.

38.4.Энэ хуулийн 38.1-д заасан үнэмлэхийн загвар, түүнийг олгох журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, нэгтгэсэн “Мэдээллийн нэгдсэн сан”-г бүртгэл, статистикийн төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран бүрдүүлж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

## **АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ**

### **39 дүгээр зүйл.Засгийн газрын чиг үүрэг**

39.1.Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

39.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх;



39.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

39.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

39.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх;

39.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

#### **40 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага**

40.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

40.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бодлого боловсруулах, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, эрх бүхий байгууллагад уламжлах, төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

40.3.Төрийн захиргааны төв байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлнэ.

40.4.Энэ хуульд заасан төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.

#### **41 дүгээр зүйл.Орон тооны бус зөвлөл**

41.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулж болно.



41.2.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

41.3.Зөвлөлийн ажлын албаны үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

41.4.Зөвлөл нь аймаг, нийслэл, дүүрэгт салбар зөвлөлтэй байх бөгөөд салбар зөвлөлийг Засаг дарга тэргүүлнэ.

## **42 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх**

42.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

42.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

42.1.2.дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламж, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, спорт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шат дараалсан арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;

42.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

42.1.4.аж ахуйн нэгж, байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэйгээр үйлчлэх санал, санаачилгыг дэмжих;

42.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгуулан батлуулах;

42.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, түүний хэрэгжилтийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулах, урлаг соёл, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд оролцуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх, эрх чөлөөг хүндэтгэх нөлөөллийн арга хэмжээ авах.



### **43 дугаар зүйл.Хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг**

43.1.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараахь нийтлэг эрх, үүрэгтэй:

43.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэх;

43.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдүүлэхдээ олон улсын чиг хандлагын дагуу түгээмэл загвар хэрэглэхийг эрхэмлэх;

43.1.3.нийтийн зориулалттай үйлчилгээний болон бусад байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлэх;

43.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралын идэвхтэй оролцоо, түүний амжилт, бүтээлийг хамт олонд нь сурталчлах, урамшуулах;

43.1.5.хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд түүнийг ажиллуулж байсан байгууллагын хувьд тусламж, дэмжлэг үзүүлэх;

43.1.6.өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 43.1.5-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;

43.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчихийг үл тэвчих;

43.1.8.ажилтан тухайн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон нь шүүхээр тогтоогдсон бол хохирлыг нөхөн төлөх;

43.1.9.хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартыг хангаж ажиллах;

43.1.10.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

### **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **44 дүгээр зүйл.Гомдол, нэхэмжлэл гаргах**

44.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хуульд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл иргэн, хуулийн этгээдээс зөрчлийг арилгуулахыг шаардах, холбогдох хуульд заасны дагуу гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.



44.2.Иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хуульд заасан эрхийг хязгаарласан, ялгаварлан гадуурхах үйл ажиллагааг явуулсан гэж үзвэл хөндөгдсөн эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах эрхээ шууд болон төлөөллөөрөө дамжуулан хэрэгжүүлнэ.

**45 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид  
хүлээлгэх хариуцлага**

45.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

45.1.1.энэ хуулийн 6.5.1, 6.5.2-т заасан зөрчил гаргасан хувь хүнийг, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтад 14 хоногоос доошгүй хугацаагаар хамруулна.

45.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд гэм хор, хохирол, хор уршиг учирсан бол буруутай этгээдээр холбогдох хуульд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2005 оны 12 дугаар сарын 08-ны өдөр баталсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21 дэх заалтын “өвчлөхөөс урьдчилан сэргийлэх” гэсний дараа “, өвчин, эмгэг, гэмтлийн улмаас эрүүл мэндэд үүсэх үр дагаврыг багасгах, арилгах” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.7 дахь заалт нэмсүгэй:

“10.1.7.ажиллах хүчний 50 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж.”

**2 дугаар зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “10.1.4-т” гэснийг “10.1.4, 10.1.7-д” гэж, мөн зүйлийн 10.3, 10.4 дэх хэсгийн “10.1.1-10.1.4-т”, “10.1.2-10.1.4-т” гэснийг “10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.7-д” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

“9.13.Тусгай цэцэрлэг нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байна.

9.14.Тусгай цэцэрлэгт ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

9.15.Цэцэрлэгийн багшид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэмэгдэл цалин олгоно.

9.16.Энэ хуулийн 9.15-д заасан нэмэгдэл цалингийн хэмжээ, түүнийг олгох журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Бага, дунд боловсролын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

**1/12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсэг:**

“12.9.Ерөнхий боловсролын сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүний насны зөрүүг боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”

**2/13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг:**

“13.3.Тусгай сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байна.”



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.2.8 дахь заалт нэмсүгэй:

“44.2.8.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн бие эрхтэн, хөгжлийн онцлогийг хүндэтгэн үзэж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдын адил тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх.”

**2 дугаар зүйл.**Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалт, 43 дугаар зүйлийн 43.1.8 дахь заалтын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” гэснийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “хэрэглэгчдийн эрх ашиг,” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүйн өв сан (цаашид “Сан” гэх)-г байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, Сангийн өгөөжийг хуваарилах, Сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах, макро эдийн засгийн тогтвортой, үр ашигтай удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

##### **2 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хууль тогтоомж**

2.1.Ирээдүйн өв сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Сантай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг энэ хуулиар, нийтлэг харилцааг бусад хуулиар зохицуулна.

3.3.Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлага, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай<sup>1</sup> хуулиар зохицуулна.

##### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөрөнгө оруулах хэрэгсэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай<sup>2</sup> хуулийн 4.1.6-д заасныг болон энэ хуулиар хориглоогүй хөрөнгө оруулж болох бусад хэлбэрийг;

<sup>1</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

4.1.2. “Сангийн хөрөнгө” гэж Сангийн эзэмшил, өмчлөлд байгаа эдийн болон эдийн бус бүх хөрөнгийг;

4.1.3. “Сангийн хөрөнгийн удирдлага” гэж Сангийн хөрөнгийг хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулах, тэдгээрийг арилжаалах үйл ажиллагааг;

4.1.4. “зөвлөх баг” гэж энэ хуулийн 16.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх орон тооны бус этгээдийг;

4.1.5. “Сангийн хөрөнгийн удирдлагын мандат” /цаашид “мандат” гэх/ гэж энэ хуульд заасан шаардлагын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс баталсан Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх олгосон бодлогын баримт бичгийг;

4.1.6. “Ирээдүйн өв сан корпораци” /цаашид “Корпораци” гэх/ гэж Сангийн хөрөнгийн удирдлагыг мандатаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит хуулийн этгээдийг;

4.1.7. “төлөөлөн удирдах зөвлөл” /цаашид “удирдах зөвлөл” гэх/ гэж Корпорацийн эрх барих дээд байгууллагыг;

4.1.8. “хөрөнгө оруулалтын стратеги” гэж мандатын хэрэгжилтийг хангах зорилгоор удирдах зөвлөлөөс баталсан Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд баримтлах стратегийн баримт бичгийг;

4.1.9. “Сангийн хөрөнгө оруулалтын орлого” гэж Сангийн хөрөнгийн удирдлагын үр дүнд бий болсон хүү, ногдол ашиг, түрээсийн орлого, хөрөнгө оруулсан хэрэгслийг борлуулсны ашиг зэрэг Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг;

4.1.10. “Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлого” гэж Сангийн хөрөнгө оруулалтын орлогоос энэ хуулийн 4.1.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан зардлыг хасч тооцсоныг;

4.1.11. “ашиг сонирхлын зөрчил” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай<sup>3</sup> хуулийн 3.1.3-т заасныг;

4.1.12. “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.11-д заасныг;

<sup>3</sup>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 08 дугаарт нийтлэгдсэн.



4.1.13.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан этгээдийг;

4.1.14.“санхүүгийн үүсмэл хэрэгсэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.7-д заасныг;

4.1.15.“суурь жил” гэж 2017 оныг.

### **5 дугаар зүйл.Сангийн хөрөнгийг удирдахад баримтлах зарчим**

5.1.Сангийн хөрөнгийг удирдахад дараахь зарчмыг баримтална:

5.1.1.хараат бус байх;

5.1.2.ил тод байх;

5.1.3.Сангийн хөрөнгийг зохистой удирдах;

5.1.4.Сангийн хөрөнгийг үр ашигтай удирдах;

5.1.5.хариуцлагатай байх.

### **6 дугаар зүйл.Сангийн хөрөнгийн удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх**

6.1.Энэ хуулийн 5.1.1-д заасан хараат бус байх зарчмыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

6.1.1.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан тушаалтнаас нөлөөлөхгүй, зааварчилгаа өгөхгүй байх;

6.1.2.энэ хуульд зааснаар сонгон шалгаруулах, томилох, гэрээ байгуулах ажиллагааг зохион байгуулахад төрийн байгууллага, албан тушаалтнаас аливаа хэлбэрээр нөлөөлөхгүй байх;

6.1.3.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, энэ хуульд зааснаар шалгаруулах, томилох, гэрээ байгуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд бусдын нөлөөнд автахгүй, хараат бус, бие даасан байх;

6.1.4.зөвлөх баг, Удирдах зөвлөл, нэр дэвшүүлэх хороо, хяналтын зөвлөлийн гишүүд, Сангийн үйл ажиллагаанд оролцогч этгээд, Корпорацийн эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлага, ажилтан ашиг сонирхлын зөрчилтэй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсч болох шийдвэр гаргахгүй, үйл ажиллагаа явуулахгүй байх;

6.1.5.энэ хуульд заасан Корпорацийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, хяналтын зөвлөлийг өрсөлдөхүйц цалин хөлсөөр хангах.

6.2.Энэ хуулийн 5.1.2-т заасан ил тод байх зарчмыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:



6.2.1.Сангийн хөрөнгийн удирдлагын талаар үнэн зөв мэдээллийг олон нийтэд энэ хуульд заасан журмын дагуу ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлж байх;

6.2.2.энэ хуульд олон нийтэд мэдээлэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлэх.

6.3.Энэ хуулийн 5.1.3-т заасан Сангийн хөрөнгийг зохистой удирдах зарчмыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

6.3.1.Сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хадгалах, түүнийг арвижуулах;

6.3.2.болзошгүй алдагдлыг хамгийн бага байлгах, илүүдэл эрсдэл хүлээхгүй байхаар өгөөжийн зорилтот түвшинг зохистой тодорхойлох;

6.3.3.өгөөжийг мандатад заасан түвшинээс багагүй байлгах хөрөнгө оруулалтын багцыг оновчтой тодорхойлох;

6.3.4.хөрөнгө оруулалтын багцыг төрөлжүүлэхдээ эрсдэл-өгөөжийн нөхцөлийг сайжруулах чиглэл баримтлах;

6.3.5.хөрөнгө оруулах стратеги, эрсдэлийн түвшин болон хөрөнгө оруулалтын багцыг зах зээлийн хувьсал, эрсдэл-өгөөжийн зорилтын өөрчлөлтөд нийцүүлэн байнга хянан тохируулах;

6.3.6.хөрөнгө оруулах шийдвэр нь тооцоо, судалгаанд суурилсан үндэслэлтэй байх;

6.3.7.эдийн засаг, улс төр, нийгмийн тогтвортой орчин бүхий зах зээл, улсад хөрөнгө оруулах;

6.3.8.эрсдэлийг хэт төвлөрүүлэхгүй байх, хөрвөх чадварын зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;

6.3.9.эрсдэлийг зохистой удирдах бүтэц, арга, хэрэгсэлтэй байх;

6.3.10.энэ хуульд зааснаас бусад тохиолдолд Корпорацийн хүлээсэн төлбөрийн үүргийг Сангийн хөрөнгөөр хүлээхгүй байх;

6.3.11.олон улсын үндэсний баялгийн сангуудын баримталдаг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг баримтлах.

6.4.Энэ хуулийн 5.1.4-т заасан Сангийн хөрөнгийг үр ашигтай удирдах зарчмыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:



6.4.1.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ мандатад заасан өгөөжийн зорилтот түвшинг хангаж ажиллах;

6.4.2.Сангийн хөрөнгийг урт хугацаанд өгөөжтэй байхаар байршуулах.

6.5.Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

6.5.1.мандат, хөрөнгө оруулалтын стратегийг чанд мөрдөж ажиллах;

6.5.2.Сангийн хөрөнгийг Корпорацийн хөрөнгөөс тусгаарласан байх;

6.5.3.Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн байх;

6.5.4.энэ хууль болон бусад хуульд заасан тайлан, дүгнэлт, шийдвэр, зөвлөмжийг хуульд заасан хугацаанд гаргах;

6.5.5.хөрөнгө оруулалт хийж болохгүй хуулийн этгээдэд хөрөнгө оруулахгүй байх;

6.5.6.Сангийн нэр хүндэд харш аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

6.5.7.Сангийн хөрөнгийг улс төрийн үйл ажиллагаа явуулах болон санхүүжүүлэхэд ашиглахгүй байх.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ САНГИЙН ЭХ ҮҮСВЭР, ЗАРЦУУЛАЛТ**

### **7 дугаар зүйл.Сангийн эх үүсвэр**

7.1.Сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

7.1.1.ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

7.1.2.Ашигт малтмалын тухай<sup>4</sup> хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь;

<sup>4</sup> Ашигт малтмалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.



7.1.3.Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогоос энэ хуулийн 9.6-д заасны дагуу шилжүүлсний дараа Санд үлдэх хэсэг;

7.1.4.Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, шинээр хууль батлах замаар татвар бий болгох, татварын хувь, хэмжээг өөрчилсөн тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.7-д заасан ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдээс улсын төсөвт орох нэмэлт орлогын 50 хувь;

7.1.5.2018 оноос эхлэн тухайн жил улсын төсөвт орох энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4-т зааснаас бусад эрдэс баялгийн орлогын суурь жилийн орлогын гүйцэтгэлээс давсан хэсгийн 20 хувь.

7.2.Монгол Улсын Их Хурал тухайн жилд энэ хуулийн 7.1-д заасан Санд төвлөрүүлэх хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батална.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэрийг тооцож Санд төвлөрүүлэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **8 дугаар зүйл.Сангийн эх үүсвэрийг төвлөрүүлэх**

8.1.Энэ хуулийн 7.1.1-д заасан эх үүсвэрийг төв төрийн санд төвлөрснөөс хойш, энэ хуулийн 7.1.2-т заасан эх үүсвэрийг холбогдох журмын дагуу хуваарилалт хийснээс хойш тус тус ажлын таван өдрийн дотор төрийн сан дахь Сангийн дансанд шилжүүлнэ.

8.2.Энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэрийг энэ хуульд зааснаас өөр зорилгоор ашиглах, захиран зарцуулахыг хориглоно.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасан Сангийн данснаас санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ажлын таван өдрийн дотор Корпорацийн Монгол банкин дахь дансанд шилжүүлнэ.

8.4.Улсын төсөв, Сан, Корпораци, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани хооронд Сангийн хөрөнгө шилжүүлэх журам, дансны зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **9 дүгээр зүйл.Сангийн хөрөнгийн удирдлагын зардлыг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын цэвэр орлогоос улсын төсөвт хуваарилах**

9.1.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой Корпорацийн зардал, энэ хуульд заасан хөндлөнгийн аудитын зардлыг Сангийн хөрөнгөөс санхүүжүүлнэ.





9.2.Нэр дэвшүүлэх хороо, хяналтын зөвлөл, зөвлөх багийн үйл ажиллагаа, гишүүний сонгон шалгаруулалт, тэдгээрийн цалин, хөлс, урамшууллын зардлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусган улсын төсвөөс санхүүжүүлнэ.

9.3.Энэ хуулийн 9.1-д заасан зардлын тухайн жилд зарцуулах дээд хэмжээг Корпорацийн удирдаж байгаа Сангийн хөрөнгийн хэмжээ, олон улсын жишигт нийцүүлэн өмнөх жилүүдийн дундажийг үндэслэн Корпорацийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр удирдах зөвлөлтэй тохиролцсоны үндсэн дээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.4.Энэ хуулийн 9.3-т заасан дээд хэмжээг Корпорацийн урсгал зардлын хувьд өмнөх жилийн гүйцэтгэлээс бууруулахгүй байна.

9.5.Сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2030 он хүртэл энэ хуулийн 9.1-д зааснаас бусад хэлбэрээр зарцуулахыг хориглоно.

9.6.2030 оноос эхлэн Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөвт шилжүүлнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ САНГИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА**

### **10 дугаар зүйл.Мандат**

10.1.Сангийн хөрөнгийн удирдлагыг мандатад заасны дагуу хэрэгжүүлнэ.

10.2.Мандатад дараахь зүйлийг тусгана:

10.2.1.өгөөжийн зорилтот түвшин;

10.2.2.хөрөнгө оруулалтын хугацааны далайц;

10.2.3.урт хугацааны хөрөнгө оруулалтын зорилтод нийцүүлэн хүлээх эрсдэл;

10.2.4.энэ хуулийн 10.2.2-т заасан хугацаанд хамаарах хөрөнгө оруулах хэрэгслийн төрөл;

10.2.5.энэ хуулийн 10.2.4-т заасан хөрөнгө оруулах хэрэгслийн төрөл тус бүрд байршуулах хөрөнгийн хувь хэмжээний дээд хязгаар;

10.2.6.хөрөнгө оруулах орчин, валютын төрөл;

10.2.7.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд удирдлага болгох жишиг багцад тавих шаардлага;

10.2.8.олон улсын жишигт нийцсэн бусад зүйл.

10.3.Мандатаар нэгж хөрөнгө оруулах хэрэгсэл, хуулийн этгээд, эдийн засгийн үйл ажиллагааг нэр зааж хөрөнгө оруулалт хийхэд шууд болон шууд бусаар зааварчилгаа өгөхийг хориглоно.

10.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мандатын төслийг боловсруулж, түүнийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Корпорацийн удирдах зөвлөлөөс санал авна.

10.5.Мандатыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хяналтын зөвлөлөөр дамжуулан хэрэгжилтэд хяналт тавина.

10.6.Сангийн бодит үнэ цэнэ, Сангийн хөрөнгийн удирдлагын үр дүнд бий болох орлогыг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.7.Энэ хуулийн 10.6-д заасан аргачлалыг Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнг тооцох, үнэлэх, мандатын хэрэгжилтэд хяналт тавихад ашиглана.

10.8.Удирдах зөвлөл мандатыг хэрэгжүүлэх талаар хуульд заасан арга хэмжээг авч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

10.9.Мандат зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн тухай бүр удирдах зөвлөл нь түүний тайлбар, авах арга хэмжээний саналыг тусган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

10.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэдэгдлийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор удирдах зөвлөлд мандат зөрчигдсөн нөхцөл, байдлыг шийдвэрлэх арга хэмжээний чиглэл өгч, биелэлтийг хангуулна.

## **11 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын стратеги**

11.1.Удирдах зөвлөл хөрөнгө оруулалтын стратеги, түүнд оруулах өөрчлөлтийг мандат батлагдсан, түүнд өөрчлөлт оруулсан өдрөөс хойш санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй байгуулсан гэрээнд заасан хугацааны дотор мандатад нийцүүлж батална.

11.2.Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мандатад нийцүүлэн удирдах зөвлөл хөрөнгө оруулалтын стратегид өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах эрхтэй.



11.3.Хөрөнгө оруулалтын стратегийг шинэчлэн баталсан, өөрчлөлт оруулсан тухай бүр удирдах зөвлөл нэн даруй санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

11.4.Хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтийг сар бүр удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, дүгнэлт гаргана.

11.5.Удирдах зөвлөл хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих үүрэгтэй.

11.6.Удирдах зөвлөл Сангийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргаснаас хойш 25 хоногийн дотор хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтийн жилийн тайлан, дүгнэлт гаргана.

## **12 дугаар зүйл.Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд тавих шаардлага**

12.1.Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд дараахь шаардлага тавигдана:

12.1.1.энэ хуулийн 12.3-т зааснаас бусад тохиолдолд зээл авахгүй байх;

12.1.2.энэ хуулийн 12.3-т зааснаас бусад тохиолдолд Сангийн хөрөнгийг барьцаалах, зээл олгох, зээлийн баталгаа, батлан даалт гаргах болон бусад аливаа хэлбэрээр бусдын үүргийн гүйцэтгэлийг хангах гэрээ, хэлцэл байгуулахгүй байх;

12.1.3.санхүүгийн хөшүүрэг оролцсон аливаа төрлийн гэрээ, хэлцэл хийхгүй байх;

12.1.4.санхүүгийн үүсмэл хэрэгслийг зөвхөн хөрөнгө оруулалтын эрсдэлийг хаах, бууруулах зорилгоор ашиглах;

12.1.5.Сангийн хөрөнгийг зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалагдаж байгаа хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулах;

12.1.6.нэгж санхүүгийн хэрэгсэлд байршуулсан хөрөнгийн хувь, хэмжээг хөрөнгө оруулж байгаа этгээдийн хяналтын багцын хувь, хэмжээнд хүргэхгүй байх;

12.1.7.татан төвлөрүүлсэн хөрөнгө нь Монгол Улсад шууд орох, Монгол Улсын төлбөрийн тэнцэлийн орох урсгалд бүртгэгдэх хөрөнгө оруулах хэрэгсэл болон бусад Монгол Улсад бүртгэлтэй хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахгүй байх.

12.2.Сангийн хөрөнгөөс дараахь хэлбэрээр хөрөнгө оруулахыг хориглоно:

12.2.1.цэрэг, зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, тэдгээрийн худалдаа, хуулиар хориглосон бусад үйл ажиллагаанд;

12.2.2.эрх бүхий этгээдэд бүртгүүлээгүй үнэт цаасанд;

12.2.3.авто зам, төмөр зам, нисэх буудал болон Хот байгуулалтын тухай<sup>5</sup> хуулийн 3.1.10-т заасан инженерийн дэд бүтцэд хамаарах үл хөдлөх эд хөрөнгөд.

12.3.Хөрөнгө оруулах шийдвэрийг гаргах үед зээл авах нөхцөл, шаардлага үүсээгүй, зөвхөн Сангаас хөрөнгө оруулахаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, тухайн хэрэгсэлд хөрөнгө оруулах төлбөр тооцоог гүйцэтгэхэд дутагдаж байгаа богино хугацааны эх үүсвэрийн дутагдлыг бүрдүүлэх зорилгоор зээл авч болно.

12.4.Энэ хуулийн 12.3-т заасны дагуу зээл авахад дараахь нөхцөлийг нэгэн зэрэг хангасан байна:

12.4.1.зээлийн хугацаа долоо хоног хүртэл байх;

12.4.2.зээлийн хэмжээ нь Сангийн мөнгөн хөрөнгө, зээл төлөгдөх хугацааны дотор орохоор хүлээгдэж байгаа хөрөнгө оруулалтын мөнгөн орлогоор баталгаажсан, түүнээс хэтрээгүй байх;

12.4.3.Сангийн зээлийн нийт үлдэгдэл нь Сангийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээний таван хувиас хэтрэхгүй байх.

12.5.Энэ хуулийн 12.3-т заасан зээл авах шийдвэрийг хөрөнгө оруулалтын хороо, эсхүл түүний эрх олгосон хэмжээнд гүйцэтгэх удирдлага гаргана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНГИЙН ЗАСАГЛАЛ**

### **13 дугаар зүйл.Ирээдүйн өв сан**

13.1.Сан Монгол Улсын нийт ард түмний өмч байна.

13.2.Сан нь Засгийн газрын тусгай сан бөгөөд орлого, эх үүсвэр, хуримтлалын хувьд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

13.3.Сангийн хөрөнгийн удирдлагыг энэ хуулийн дагуу байгуулагдах Корпораци хэрэгжүүлнэ.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасан хуулийн этгээдийн өмчлөлийг

<sup>5</sup>Хот байгуулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлнэ.

13.5.Сангийн хөрөнгийн удирдлагын бодлого тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүргийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ.

13.6.Сан, төсөв хоорондын харилцаанд Монгол Улсын Ерөнхий аудитор хяналт тавина.

#### **14 дүгээр зүйл.Сантай холбоотой санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

14.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Сантай холбоотой дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.мандатыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох;

14.1.2.удирдах зөвлөлөөс стратегийн баримт бичгийг батлах, түүнд өөрчлөлт оруулах тухай бүрд шаардлагатай гэж үзвэл уг баримт бичиг мандатад нийцэж байгаа эсэхэд аудит хийлгэх;

14.1.3.мандатын хэрэгжилтийн байдалд дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах;

14.1.4.мандатын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн тохиолдолд Корпорацийн үйл ажиллагаанд аудит хийлгэх;

14.1.5.удирдах зөвлөлийн гишүүнтэй гэрээ байгуулах, цалин хөлсний хэмжээг тогтоох;

14.1.6.зөвлөх багийн гишүүдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах;

14.1.7.хяналтын зөвлөлтэй гэрээ байгуулах;

14.1.8.удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох ажлыг зохион байгуулах;

14.1.9.Сангийн тайланг хүлээн авах, хянах;

14.1.10.хуульд заасан бусад эрх.

#### **15 дугаар зүйл.Хяналтын зөвлөл**

15.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий хяналтын зөвлөлийг ажиллуулна.

15.2.Хяналтын зөвлөл орон тооны бус таван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

15.3.Хяналтын зөвлөлийн гишүүн дараахь шаардлагыг хангасан

байна:

15.3.1.эдийн засаг, санхүү, үнэт цаасны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;

15.3.2.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх;

15.3.3.хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Сангийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

15.3.4.сүүлийн хоёр жилийн хугацаанд Корпорацийн ажилтнаар ажиллаагүй, Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд оролцоогүй байх;

15.3.5.Монгол Улсын иргэн байх;

15.3.6.ял шийтгэлгүй байх.

15.4.Хяналтын зөвлөлийн гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

15.4.1.улс төрийн албан тушаалтан;

15.4.2.намын гишүүн;

15.4.3.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдэд сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаж байсан, эсхүл ажиллаж байгаа этгээд;

15.4.4.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдийн хувьцааны хяналтын багц эзэмшигч.

15.5.Хяналтын зөвлөлийн гишүүнд дараахь журмаар сонгогдсон байгууллага тус бүрээс нийт гишүүн, эсхүл нийт ажилтны олонхийн санал авсан гурав хүртэлх хүний нэрийг дэвшүүлнэ:

15.5.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгосон санхүү, эдийн засгийн чиглэлийн, эсхүл санхүү, эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний гурав хүртэлх байгууллагаас их, дээд сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан, багш 10-аас дээш жилийн ажлын туршлагатай хүнийг;

15.5.2.Монгол Улсын Их Хурлын даргын сонгосон санхүү, эдийн засгийн судалгаа, шинжилгээний туршлагатай, нийгэмд үйлчлэх гурав хүртэлх төрийн бус байгууллагаас;

15.5.3.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын



гишүүний сонгосон дараахь мэргэжлийн тав хүртэлх байгууллагаас:

15.5.3.а.банкны болон банкны мэргэжилтнүүдийн холбоо;

15.5.3.б.үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын болон мэргэжилтнүүдийн холбоо;

15.5.3.в.санхүү, нягтлан бодох, аудит, хөрөнгийн үнэлгээ, даатгалын мэргэжлийн байгууллагын болон мэргэжилтнүүдийн холбоо, хуульчдын холбоо.

15.6.Энэ хуулийн 15.5-д заасан журмаар нэр дэвшүүлсэн этгээдээс санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн таван хүнийг хяналтын зөвлөлийн гишүүнээр шууд сонгоно.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасны дагуу хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгохдоо Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний сонгосон аль нэг байгууллагаас нэг төлөөллийг заавал хамруулах бөгөөд нэг байгууллагаас давхардуулан сонгохгүй.

15.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан нэр дэвшүүлэх хороогоор дамжуулан хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгож болно.

15.9.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хяналтын зөвлөлийн гишүүдтэй таван жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллана.

15.10.Хяналтын зөвлөлийн гишүүнтэй байгуулсан гэрээг дараахь үндэслэлээр дуусгавар болгоно:

15.10.1.энэ хуулийн 15.3-т заасан шаардлагыг хангахгүй болсон, энэ хуулийн 15.4-т заасан үндэслэл бий болсон;

15.10.2.эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гэрээг дуусгавар болгох хүсэлтийг өөрөө гаргасан;

15.10.3.гэмт хэрэгт холбогдож гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон;

15.10.4.гэрээний хугацаа дуусгавар болсон;

15.10.5.Сангийн эрх ашигт харш үйлдэл, эс үйлдэл гаргасан нь тогтоогдсон;

15.10.6.ашиг сонирхлын зөрчил үүссэн;

15.10.7.хуульд заасан бусад үндэслэл.

15.11.Хяналтын зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.11.1.мандат болон хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, дүгнэлт, зөвлөмж гаргах;

15.11.2.хөрөнгө оруулалтын стратеги болон бусад баримт бичиг мандатад нийцэж байгаа эсэхэд зөвлөх багийн санал, зөвлөмж авч, дүгнэлт гаргах;

15.11.3.энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан хөрөнгийн удирдлагын зарчмын хэрэгжилт, энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан хөрөнгийн удирдлагад тавих шаардлагын биелэлтэд хяналт тавих;

15.11.4.энэ хуулийн 12.1, 12.2 дахь заалтыг зөрчсөн, зөрчих нөхцөл бий болсон тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон удирдах зөвлөлд нэн даруй мэдэгдэж холбогдох арга хэмжээг авахуулах;

15.11.5.удирдах зөвлөлийн дотоод хяналтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилт болон Корпораци тайлангаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдалд хяналт тавих;

15.11.6.Сангийн хөрөнгө оруулах шалгуурт үл нийцэх, хөрөнгө оруулалт хийж болохгүй хуулийн этгээдийн талаарх санал, зөвлөмж гаргаж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

15.11.7.Корпорацийн дотоод хяналтын газар, аудитын хороо, Аудитор болон Корпорацийн санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллагын аудитортой харилцах, санал солилцох;

15.11.8.шаардлагатай тохиолдолд удирдах зөвлөл, Корпорацийн үйл ажиллагаанд аудит хийлгэх саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргах.

15.12.Хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, хяналтын зөвлөлийн ажиллах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **16 дугаар зүйл.Зөвлөх баг**

16.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд орон тооны бус гурван гишүүний бүрэлдэхүүнтэй зөвлөх баг /цаашид “зөвлөх баг” гэх/ ажиллана.

16.2.Зөвлөх баг дараахь чиг үүрэгтэй байна:





16.2.1.мандатыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шийдвэр гаргахад санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд зөвлөх;

16.2.2.Сангийн улирал, бүтэн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг үндэслэн мандатын хэрэгжилт болон цаашид авах арга хэмжээний талаарх дүгнэлт, зөвлөмж гаргаж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх;

16.2.3.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шаардлагатай гэж үзсэн Сангийн хөрөнгө оруулалттай холбоотой бусад судалгаа, шинжилгээ хийх.

16.3.Зөвлөх багийн гишүүдийг сонгон шалгаруулах, зөвлөх багийн ажиллах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.4.Зөвлөх багийн гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:

16.4.1.олон улсын санхүүгийн зах зээлд 15-аас дээш жил удирдах албан тушаалд ажилласан, хөрөнгө оруулах шийдвэр гаргахад оролцсон туршлагатай байх;

16.4.2.хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Сангийн нэр хүнд, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

16.4.3.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс тогтоосон бусад шаардлага.

### **17 дугаар зүйл.Сантай холбоотой санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг**

17.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Сангийн удирдлагатай холбоотой дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ:

17.1.1.мандатын төслийг боловсруулах;

17.1.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг чиг үүргээ гүйцэтгэхэд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

17.1.3.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, зөвлөх баг, хяналтын зөвлөл, Корпораци хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах;

17.1.4.зөвлөх багийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

17.1.5.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон бусад чиг үүрэг.

## **ТАВДУГААР БҮЛЭГ КОРПОРАЦИ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **18 дугаар зүйл.Корпораци**

18.1.Корпорацийг үүсгэн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргаж, Улсын Их Хуралд танилцуулна.

18.2.Корпораци хөрөнгө оруулах шийдвэрийг мандат, хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд, бусад байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар, бие даан гаргана.

18.3.Корпораци Монголбанкинд төгрөгийн болон валютын харилцах данстай байна.

18.4.Корпорацийн Монголбанк дахь төгрөг болон гадаад валютын дансны хооронд хийх гүйлгээг Монголбанкнаас зарласан тухайн өдрийн албан ёсны ханшаар Монголбанк гүйцэтгэнэ.

18.5.Корпораци хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын, дотоод хяналтын асуудал хариуцсан дотоод бүтцийн нэгжтэй байна.

18.6.Корпорацийн өөрийн хөрөнгийн доод хэмжээг Засгийн газар тогтооно.

18.7.Корпорацийн дүрмийг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.

18.8.Корпорацийн дүрэмд дараахь зүйлийг заавал тусгана:

18.8.1.корпорацийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;

18.8.2.корпорацийн хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

18.8.3.удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх;

18.8.4.Корпорацийн үйл ажиллагааны чиглэл;

18.8.5.Корпорацийн дүрэмд тусгахаар хуульд заасан бусад зүйл.



18.9.Корпорацийн дүрэмд хууль тогтоомжтой зөрчилдөөгүй бусад зүйлийг тусгаж болно.

18.10.Корпораци үйл ажиллагаандаа корпорацийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

### **19 дүгээр зүйл.Корпорацийн үйл ажиллагаа**

19.1.Корпораци Сангийн хөрөнгө, Засгийн газраас итгэмжлүүлсэн тохиолдолд Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

19.2.Корпораци энэ хуульд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

19.3.Сан, Засгийн газраас итгэмжлүүлсэн Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө, Корпорацийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээллийг тус бүрээр нь гаргана.

### **20 дугаар зүйл.Нэр дэвшүүлэх хороо**

20.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэр дэвшүүлэх хороонд ажиллах иргэдийн нэрсийн жагсаалт бүхий мэдээллийн сантай байна. Мэдээллийн санг дараахь журмаар бүрдүүлнэ:

20.1.1.энэ хуулийн 20.4-д заасан шаардлагыг хангасан иргэдэд тусгайлан урилга өгөх замаар 20-иос доошгүй иргэнийг;

20.1.2.нээлттэй сонгон шалгаруулалтаар энэ хуулийн 20.4-т заасан шаардлагыг хангасан 50-иас доошгүй иргэнийг.

20.2.Энэ хуулийн 20.1.1-д заасан тусгайлсан урилгаар нэрсийн жагсаалтыг бүрдүүлэхдээ эрдэм шинжилгээ, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, иргэдийн төлөөллийг зохистой хамруулах зарчмыг баримтална.

20.3.Энэ хуулийн 20.1.1-д заасан урилга хүргүүлэх ажил, энэ хуулийн 20.1.2-т заасан сонгон шалгаруулалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

20.4.Нэр дэвшүүлэх хорооны гишүүн дараахь шаардлагыг хангасан байна:

20.4.1.Корпорацийн удирдах зөвлөлийн гишүүнд өрсөлдөхөөр өргөдөл, хүсэлт гаргаагүй байх;



20.4.2.энэ хуулийн 15.3.1, 15.3.2, 15.3.3, 15.3.4, 15.3.5, 15.3.6-д заасан шаардлагыг хангасан байх.

20.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь хэлбэрийн аль нэгийг сонгох замаар нэр дэвшүүлэх хороог тухай бүр байгуулна:

20.5.1.энэ хуулийн 20.1-д заасан жагсаалтаас таван иргэний нэрийг сугалаагаар тодруулах зарчмаар санамсаргүй байдлаар сонгох;

20.5.2.энэ хуулийн 20.1-д заасан жагсаалтад байгаа нийт иргэдийг нэр дэвшүүлэх хороо болгон зохион байгуулах.

20.6.Нэр дэвшүүлэх хороо байгуулагдсанаас хойш 8 цагийн дотор удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг, энэ хуулийн 15.8-д заасан тохиолдолд хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд шийдвэрээ танилцуулна.

20.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг үндэслэн удирдах зөвлөлийн гишүүнтэй, энэ хуулийн 15.8-д заасан тохиолдолд хяналтын зөвлөлийн гишүүнтэй гэрээ байгуулна.

20.8.Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг, энэ хуулийн 15.8-д заасан тохиолдолд хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг нэр дэвшүүлэх хорооны нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

20.9.Энэ хуулийн 20.5.2-т заасны дагуу нэр дэвшүүлэх хороог зохион байгуулсан бол жагсаалтад байгаа нийт гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор санал хүчин төгөлдөр болно.

20.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын түвшинд үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр удирдах зөвлөлийн гишүүнд тавих шаардлага хангасан этгээдүүдийн жагсаалтыг гаргаж, удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг гүйцэтгэнэ.

20.11.Нэр дэвшүүлэх хорооны эрх хэмжээ нь энэ хуулийн 20.5.1-д заасны дагуу байгуулагдсан бол шийдвэрийг танилцуулснаар, энэ хуулийн 20.5.2-т заасны дагуу байгуулагдсан бол саналаа өгснөөр дуусгавар болж, татан буугдана.

20.12.Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журам, нэр дэвшүүлэх хороонд ажиллах гишүүнд урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



## **21 дүгээр зүйл.Удирдах зөвлөл**

21.1.Корпорацийн эрх барих дээд байгууллага нь удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөл таван гишүүнээс бүрдэнэ.

21.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдах зөвлөлийн гишүүнтэй таван жилийн хугацаатай гэрээ байгуулна.

21.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдах зөвлөлийн гишүүнтэй байгуулсан гэрээг тав хүртэлх жилийн хугацаагаар хоёроос дээшгүй удаа сунган ажиллуулж болно.

21.4.Удирдах зөвлөлийн гишүүнтэй байгуулсан гэрээг дараахь тохиолдолд дуусгавар болгоно:

21.4.1.энэ хуулийн 21.5-д заасан шаардлагыг хангахгүй болсон;

21.4.2.энэ хуулийн 15.10.2, 15.10.3, 15.10.4, 15.10.5, 15.10.6, 15.10.7-д заасан үндэслэл бий болсон.

21.5.Удирдах зөвлөлийн гишүүн дараахь шаардлагыг хангасан байна:

21.5.1.энэ хуулийн 15.4.1, 15.4.2, 15.4.4-т заасан этгээд биш байх, энэ хуулийн 15.3.1, 15.3.2, 15.3.3, 15.3.6-д заасан шаардлагыг хангасан байх;

21.5.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон түвшинээс багагүй хэмжээний санхүүгийн хөрөнгийг удирдаж байсан байгууллага, эсхүл олон улсын санхүүгийн байгууллагад энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтантай адилтгах албан тушаал эрхэлж байсан байх;

21.5.3.хөрөнгө оруулалт, нягтлан бодох, аудитын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах санхүүгийн ажилтан, санхүүгийн шинжээч, мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, хуульчийн аль нэгээр 10-аас дээш жил ахлах, удирдах түвшинд ажилласан байх;

21.5.4.мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн хүрээнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний үндэслэл бүхий, шаардлагатай гэж үзсэн бусад.

21.6.Удирдах зөвлөлийн даргыг удирдах зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар, гишүүд дотроос хоёр жилийн хугацаагаар сонгоно.

21.7.Удирдах зөвлөлийн дарга хуралд хүндэтгэн үзэх шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд удирдах зөвлөлөөс урьдчилан сонгогдсон гишүүн хурлын даргын үүргийг гүйцэтгэнэ.

21.8.Удирдах зөвлөл нарийн бичгийн даргатай байна.

21.9.Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг удирдах зөвлөлийн даргын санал болгосноор удирдах зөвлөл томилно.

## **22 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн бүрэн эрх**

22.1.Удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.Сангийн хөрөнгө оруулалтын стратегийг батлах;

22.1.2.мандат, түүний хэрэгжилттэй холбогдох асуудлаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй шууд харилцаж, байр сууриа илэрхийлэх;

22.1.3.Корпорацийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох;

22.1.4.Корпорацийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг батлах;

22.1.5.Корпорацийн дотоод журам, заавар, аргачлалыг батлах;

22.1.6.Корпорацийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх этгээдийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгож, гэрээ байгуулан ажиллуулах;

22.1.7.энэ хуулийн 25.19, 25.20-д заасан болон Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх бусад үйл ажиллагаанд оролцох этгээдүүдийг сонгон шалгаруулах журмыг батлах, зөвшөөрөл олгох;

22.1.8.Корпорацийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;

22.1.9.гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг үнэлэх;

22.1.10.хяналтын зөвлөлийн зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч үр дүнг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

22.1.11.гүйцэтгэх удирдлагын нэгж хөрөнгө оруулах хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргах хөрөнгийн дээд хэмжээг тогтоох;

22.1.12.энэ хуулийн 22.1.11-д заасан хэмжээнээс дээш хэмжээний хөрөнгө оруулах болон түүнийг буцаан татах шийдвэр гаргах;



22.1.13.Корпорацийн ёс зүйн дүрмийг батлах.

**23 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн хуралдаан**

23.1.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

23.2.Удирдах зөвлөл сард нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд хуралдааны дэгийг Удирдах зөвлөл батална.

23.3.Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

23.4.Удирдах зөвлөлийн хуралдааны явцыг тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд түүнд хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурна.

23.5.Удирдах зөвлөлийн хуралдаанаар ашиг сонирхлын зөрчилтэй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц асуудлыг хэлэлцэхэд удирдах зөвлөлийн гишүүн хуралдаан эхлэхээс өмнө энэ тухай мэдэгдэж, уг асуудлыг хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргахад оролцохгүй.

23.6.Энэ хуулийн 23.5-д заасан ашиг сонирхлын зөрчлийн талаар удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

**24 дүгээр зүйл.Удирдах зөвлөлийн дэргэдэх хороод**

24.1.Удирдах зөвлөл нь аудитын хороо, хөрөнгө оруулалтын хороог байгуулна.

24.2.Хороодын даргыг хороодын гишүүдийн олонхийн саналаар хоёр жилийн хугацаагаар сонгоно.

24.3.Удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрийн эрх хэмжээний хүрээнд бусад хороог байгуулж, тэдгээрийн эрх, үүргийг тогтооно.

24.4.Удирдах зөвлөл нь хороодын бүтэц, ажиллах журмыг батална.

24.5.Аудитын хороонд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Аудиторыг аудитын хороо томилно.

24.6.Аудитороор энэ хуулийн 15.3.2, 15.3.3, 15.3.4, 15.3.6-д заасан шаардлагыг хангасан, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг этгээд, олон улсын санхүүгийн байгууллагад аудитороор 10-аас дээш жил ахлах

түвшинд ажилласан ажлын туршлагатай санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй, энэ хуулийн 15.4-т зааснаас бусад этгээдийг томилно.

24.7.Аудитор нь дотоод хяналтын газрын захирлын үүргийг гүйцэтгэж, дотоод хяналтын асуудлаар аудитын хороонд, захиргааны асуудлаар Гүйцэтгэх захиралд тайлагнана.

24.8.Аудитор нь хорооны гишүүн, Корпорацийн эрх бүхий албан тушаалтан, дотоод нэгжүүдийн удирдах албан тушаалтан, ажилтан, эдгээртэй болон Корпорацийтай нэгдмэл сонирхолтой, хамаарал бүхий этгээд байхыг хориглоно.

### **25 дугаар зүйл. Корпорацийн гүйцэтгэх удирдлага**

25.1.Корпорацийн гүйцэтгэх удирдлагыг /цаашид “гүйцэтгэх удирдлага” гэх/ хувь хүн, эсхүл багаар хэрэгжүүлнэ.

25.2.Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн, эсхүл багаар хэрэгжүүлэх шийдвэрийг удирдах зөвлөл гаргана.

25.3.Гүйцэтгэх удирдлага нь Корпорацийн дүрэм болон удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

25.4.Гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

25.5.Гүйцэтгэх удирдлага нь удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Корпорацийг төлөөлөх зэргээр Корпорацийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

25.6.Гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх тохиолдолд Корпорацийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор багийн гишүүдийн ажиллах дотоод журмыг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр баталж мөрдөнө.

25.7.Энэ хуулийн 25.6-д заасан баг удирдах зөвлөлийн өмнө гэрээ болон Корпорацийн дүрэм, холбогдох хууль тогтоомжийн дагуу хамтын хариуцлага хүлээнэ.

25.8.Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч баг энэ хуулийн 25.5-д заасны дагуу гэрээ, хэлцэл хийх, төлөөллийг хэрэгжүүлэх тохиолдолд Корпорацийг төлөөлж багийн ахлагч гарын үсэг зурна.





25.9.Энэ хуулийн 25.8-д заасан багийн ахлагчийг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн багийн гишүүд сонгох бөгөөд багийн ахлагч Корпорацийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэнэ.

25.10.Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн хурал, гаргасан шийдвэрийн тэмдэглэлийг заавал хөтлөх бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал биечлэн хариуцна.

25.11.Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг удирдах зөвлөл хэдийд ч гаргах эрхтэй.

25.12.Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд Корпорацийн гүйцэтгэх захирал байна.

25.13.Гүйцэтгэх удирдлага дараахь үндсэн эрх, үүрэгтэй байна:

25.13.1.удирдах зөвлөлөөс баталсан хөрөнгө оруулах стратегийг хэрэгжүүлэх;

25.13.2.Корпорацийн дүрэм, удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Корпорацийг төлөөлөх;

25.13.3.санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх, төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой санхүү бүртгэл, мэдээлэл, удирдлага, зохион байгуулалтын асуудлаар холбогдох шийдвэрийг гаргах;

25.13.4.Корпорацийн жилийн төсвийг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг зохион байгуулах;

25.13.5.Корпорацийн захирлуудыг гэрээ байгуулан ажиллуулах, Гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлж байгаа тохиолдолд багийн бүрэлдэхүүнд ороогүй захиралтай гэрээ байгуулан ажиллуулах;

25.13.6.Корпорацийн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах;

25.13.7.удирдах зөвлөлөөс олгогдсон эрх хэмжээний хүрээнд, удирдах зөвлөлийн эрх хэмжээнд хамруулснаас бусад журам, заавар, аргачлалыг батлах;

25.13.8.хөрөнгө оруулах хэрэгсэлд хөрөнгө оруулах үнэлгээний журмыг тогтоож, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;

25.13.9.мандат, хөрөнгө оруулалтын стратегийн дагуу Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулах хэрэгсэлд үр өгөөжтэй байршуулах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

25.13.10.Корпорацийн хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулсан хөрөнгийн өгөөж, цаашдын хандлагын талаар санал боловсруулан удирдах зөвлөлд танилцуулах;

25.13.11.төсөвт шилжүүлэх боломжтой Сангийн цэвэр орлогын хэмжээг тооцож, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулахаар төсвийн цаглабарын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад удирдах зөвлөлөөр дамжуулан хүргүүлэх;

25.13.12.Корпорацийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

25.14.Гүйцэтгэх удирдлага дараахь шаардлагыг хангасан байна:

25.14.1.энэ хуулийн 15.4.1, 15.4.2, 15.4.4-т зааснаас бусад этгээд байх;

25.14.2.энэ хуулийн 15.3.1, 15.3.2, 15.3.3, 15.3.6-д заасан шаардлагыг хангасан байх;

25.14.3.санхүү, хөрөнгө оруулах үйл ажиллагаанд шийдвэр гаргах түвшинд 10-аас доошгүй жил, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх;

25.14.4.гүйцэтгэх захирал буюу багийн ахлагч 25.14.2, 25.14.3-т зааснаас гадна санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон хэмжээнээс багагүй хэмжээний санхүүгийн хөрөнгийг удирдаж байсан байгууллагад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд шийдвэр гаргах түвшинд 10-аас доошгүй жил, үүнээс 5-аас доошгүй жил нь удирдах албан тушаалд ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх;

25.14.5.хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлага хариуцсан захирлууд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон хэмжээнээс багагүй хэмжээний санхүүгийн хөрөнгийг удирдаж байсан байгууллагад ижил түвшний албан тушаал эрхэлж байсан, эсхүл энэ төрлийн байгууллагад тухайн чиглэл, мэргэжлээр ахлах түвшинд 10-аас доошгүй жил ажилласан байх;

25.14.6.удирдах зөвлөлийн үндэслэл бүхий, шаардлагатай гэж үзсэн бусад.

25.15.Гүйцэтгэх удирдлага бусад байгууллагад ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглоно.

25.16.Гүйцэтгэх удирдлага ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчтэй байх зэрэг тохиолдолд удирдах зөвлөлөөс урьдчилан тогтоосон этгээдэд



өөрийн бүрэн эрхийг тушаалаар шилжүүлж болох бөгөөд ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

25.17.Гүйцэтгэх удирдлага хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн нь эрх бүхий этгээд, хөндлөнгийн хяналтын байгууллагаас тогтоогдсон тохиолдолд удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээг цуцалж болно.

25.18.Гүйцэтгэх удирдлага Сангийн хөрөнгийн бүртгэл, хадгалалт, гүйлгээ болон бусад шаардлагатай үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр олон улсын нэр хүнд бүхий кастодианы байгууллагаар гүйцэтгүүлнэ.

25.19.Гүйцэтгэх удирдлага удирдах зөвлөлийн зөвшөөрөлтэйгээр Сангийн хөрөнгийн зарим хэсгийг гэрээний үндсэн дээр хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниар гүйцэтгүүлж болно.

25.20.Хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы байгууллага болон Корпорацийн хооронд байгуулах гэрээг удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэх удирдлага байгуулна.

## **26 дугаар зүйл.Хойшлуулшгүй арга хэмжээ**

26.1.Хөрөнгө оруулалтын менежментийн компани, эсхүл кастодиантай холбогдуулан доор дурдсан нөхцөл бий болсон, түүнчлэн дараахь бусад нөхцөл үүссэн тохиолдолд гүйцэтгэх удирдлага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, удирдах зөвлөлд нэн даруй мэдэгдэнэ:

26.1.1.татан буугдсан, дампуурлын хэрэг үүссэн;

26.1.2.энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг зөрчсөн;

26.1.3.Сан, Корпорацийн нэр хүндэд ноцтой нөлөөлөх нөхцөл байдал бий болсон;

26.1.4.үйл ажиллагааг нь эрх бүхий этгээдээс зогсоосон, бусад шалтгаанаар үйл ажиллагаа нь саатсан буюу зогссон;

26.1.5.Сангийн хөрөнгийн хэмжээ тухайн төсвийн жилийн эхний хэмжээнээс 50 болон түүнээс дээш хувиар буурсан;

26.1.6.гүйцэтгэх удирдлагын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл.

26.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, удирдах зөвлөл энэ хуулийн 26.1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор зохих шийдвэр гаргана.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТАЙЛАГНАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ**

### **27 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэл**

27.1. Корпораци өөрийн хөрөнгө болон Сангийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг тус тусад нь бүртгэнэ.

27.2. Корпорацийн хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниар гэрээгээр гүйцэтгүүлж байгаа хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг менежментийн компани тус бүрээр бүртгэнэ.

### **28 дугаар зүйл. Сангийн тайлан**

28.1. Корпораци Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг улирал, бүтэн жилээр гаргана.

28.2. Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланд дараахь зүйлийг тусгана:

28.2.1. Сангийн санхүүгийн тайлан;

28.2.2. Корпорацийн санхүүгийн тайлан;

28.2.3. мандат болон хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилт;

28.2.4. Корпорацийн Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн;

28.2.5. Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны зардал, өгөөжийн үзүүлэлтүүд;

28.2.6. Сангийн төсвийн орлого, зардлын гүйцэтгэл;

28.2.7. Корпорацийн үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл.

28.3. Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд дараахь зүйлийг тусгана:

28.3.1. энэ хуулийн 28.2-т заасан улирлын тайланд тусгасан зүйлс;

28.3.2. Сангийн эрсдэлийн удирдлагын тайлан;

28.3.3. аудитын дүгнэлт.

28.4. Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.



28.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхий аудитор, зөвлөх багт хүргүүлж олон нийтэд мэдээлнэ.

28.6.Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж аудит хийлгэсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

28.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор дүгнэлт гаргаж, аудитын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулна.

28.8.Корпорациас хуульд зааснаас бусад хэлбэрээр тайлан гаргуулахыг хориглоно.

### **29 дүгээр зүйл.Сангийн ил тод байдал**

29.1.Сангийн удирдлагатай холбоотой дараахь мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон нийтэд мэдээлнэ:

29.1.1.Сангийн асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийг албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дотор;

29.1.2.мандатыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталснаас хойш 10 хоногийн дотор;

29.1.3.зөвлөх багийн зөвлөмжийг уг зөвлөмжийг гаргаснаас хойш тав хоногийн дотор;

29.1.4.Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг уг дүгнэлтийг гаргаснаас хойш 10 хоногийн дотор;

29.1.5.Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг уг тайланг гаргаснаас хойш 10 хоногийн дотор;

29.2.Корпораци Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой дараахь мэдээллийг сар бүр шинэчлэн олон нийтэд мэдээлнэ:

29.2.1.Сангийн хөрөнгө оруулсан санхүүгийн хэрэгслийн ангилал, харгалзах өгөөжийн түвшинг жиших үзүүлэлтүүдтэй харьцуулснаар;



29.2.2. удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

29.2.3. Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох Хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы байгууллага болон бусад оролцогчийн нэр;

29.2.4. хуульд заасан бусад.

29.3. Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн хэлбэр, тайланд тавих тусгай шаардлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **30 дугаар зүйл. Хөндлөнгийн аудит**

30.1. Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Корпорацийн үйл ажиллагаанд олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар доор дурдсан журмаар аудит хийлгэнэ:

30.1.1. хоёр жилд нэгээс доошгүй удаа;

30.1.2. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мандатын хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэсэн.

30.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 30.1-д заасан аудитын байгууллагыг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгож, гэрээ байгуулан ажиллуулна.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **31 дүгээр зүйл. Хариуцлага хүлээлгэх үндэслэл**

31.1. Ирээдүйн өв сангийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан хариуцлага оногдуулсан нь түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **32 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

32.1. Ирээдүйн өв сангийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий албан тушаалтан дараахь сахилгын шийтгэл хүлээлгэнэ:

32.1.1. энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 10.3-т заасныг зөрчсөнийг шүүх, улсын байцаагчаас тогтоосон бол төрийн албан тушаалтан, албан



хаагчийг төрийн албанд таван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;

32.1.2.сан, сангийн хөрөнгө оруулалттай холбоотой нууцад хамаарах мэдээллийг задруулсан, хувийн зорилгоор ашигласан этгээдийг албан тушаалаас халах, төрийн албан хаагчийг төрийн албанд 10 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;

32.1.3.энэ хуулийн 24.8, 25.15-д заасныг зөрчсөн этгээдийг албан тушаалаас халж хохирлыг нөхөн төлүүлэх;

32.1.4.энэ хуулийн 8.2, 9.5-д заасныг зөрчсөн нь томилсон эрх бүхий этгээд тухайн албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулах, халах үндэслэл болно.

32.2.Ирээдүйн өв сангийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эсхүл улсын байцаагч доор дурдсан захиргааны шийтгэлийг оногдуулна:

32.2.1.энэ хуулийн 6.3.6, 6.3.10, 6.5.1, 6.5.2-т заасныг зөрчсөн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, Санд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

32.2.2.энэ хуулийн 12.2-т заасныг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлэх;

32.2.3.энэ хуулийн 12.3-т заасныг зөрчиж зээл авсан этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлэх;

32.2.4.энэ хуулийн 19.2-т заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж, буруутай албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 350 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

32.2.5.энэ хуулийн 28.8-д заасныг зөрчсөн этгээдийг олон нийтэд мэдээлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

32.2.6.энэ хуульд заасан тайлан, дүгнэлт, шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргаагүй этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;



32.2.7.энэ хуулийн дагуу олон нийтэд мэдээлэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд хүргүүлээгүй, мэдээлээгүй этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

**33 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

33.1.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ  
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД  
ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Хүний хөгжил сангийн тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлийг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс, бусад зүйлийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “Хадгаламжийн даатгалын” гэсний дараа “болон Ирээдүйн өв сан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалтын “Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д” гэснийг “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.6, 8.8, 8.9 дэх хэсэг, мөн зүйлийн 8.6.3 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “төсөв, Хүний хөгжил сангийн” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.1.6, 38.1.7 дахь заалтын “төсөв болон Хүний хөгжил сангийн” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.33 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “төсөв, Хүний хөгжил сангийн” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.1.6, 38.1.7 дахь заалтын “төсөв болон Хүний хөгжил сангийн” гэснийг тус тус хассугай” гэснийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, бусад зүйлийг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.1.15 дахь заалт нэмсүгэй:

“18.1.15.Ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого, сангийн хөрөнгө оруулалтын орлого.”



**2 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтын “Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д” гэснийг “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН  
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.5.17 дахь заалт нэмсүгэй:

“13.5.17. Ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого эх үүсвэр, сангийн хөрөнгө оруулалтын орлого.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.8 дахь хэсэг нэмсүгэй:



“3.8.Ирээдүйн өв сан, Ирээдүйн өв сан корпорацийн үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн “эрдэнэсийн” гэсний дараа “сан, Ирээдүйн өв” гэж, “Хадгаламжийн даатгалын” гэсний дараа “корпораци, Ирээдүйн өв сан” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН  
ТУХАЙ ХУУЛЬ**

**1 дүгээр зүйл.**Ирээдүйн өв сангийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Хүний хөгжил санд хуримтлагдсан өрийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон улсын төсөвт өглөгөөр бүртгэж улсын төсвөөс барагдуулах ба улсын төсөв тухайн шилжүүлэн авсан дүнгээр Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэнэ.

**2 дугаар зүйл.**Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1, 7.1.2-т заасны дагуу бүрдүүлсэн сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2017 онд 160 тэрбум төгрөг, 2018 онд 100 тэрбум төгрөг, 2019 онд 50 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус шилжүүлнэ.



**3 дугаар зүйл.**Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан шилжүүлэг болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 9.1, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон Корпорацийн зардлыг шилжүүлсний дараа үлдэх эх үүсвэрээр энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан Ирээдүйн өв сангийн өглөгийг төлж барагдуулна.

**4 дүгээр зүйл.**Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 8.3 дахь хэсгийг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу өглөгийг төлж барагдуулж дууссанаар дагаж мөрдөнө.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу өглөгийг барагдуулж, Ирээдүйн өв санд хуримтлал үүсэх хүртэлх хугацаанд Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 9.3-т заасны дагуу Корпорацийн зардлын хязгаарыг тогтоож, санхүүжүүлэхдээ санд хуримтлал бий болж эхлэх үеийн хэмжээний хөрөнгийг удирдахад тохирсон бүтцийг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэлийг хангахад нийцсэн зохистой түвшинд байлгах зарчмыг баримтална.

**6 дугаар зүйл.**“Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын Засгийн газар шинэчлэн батална.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “, Хүний хөгжил сангийн” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтын “сан, Хүний хөгжил” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.5.1 дэх заалтын “төсөв, Хүний хөгжил сангийн” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.9 дэх заалт нэмсүгэй:

“4.1.9. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг



дараа “Төсвийн тогтворжуулалтын сан,” гэж, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийн “Эрсдэлийн” гэсний дараа “сан, Төсвийн тогтворжуулалтын” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.4.27 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалтын “Хүний хөгжил” гэснийг “Ирээдүйн өв” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийн 2 дугаар зүйлийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, бусад зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/16 дугаар зүйл:**

**“16 дугаар зүйл.Төсвийн тогтворжуулалтын сан**

16.1.Төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагад нийцсэн нэгдсэн төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилготой Төсвийн тогтворжуулалтын сантай байна.

16.2.Төсвийн тогтворжуулалтын санг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

16.2.1.татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон төсвийн орлого;



16.2.2.төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг;  
16.2.3.Засгийн газрын нөөц сангийн болон эрсдэлийн сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй үлдэгдэл;

16.2.4.Төсвийн тогтворжуулалтын сангийн санхүүгийн үйл ажиллагааны цэвэр орлого;

16.2.5.Монгол Улсын Их Хурлаас төсвийн тогтворжуулалтын санд хуваарилахаар тогтоосон бусад орлого.

16.3.Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгөөс доор дурдсан санхүүжилт хийх зориулалтаар улсын төсөвт шилжүүлж болно:

16.3.1.урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч төсвийн алдагдал баталсан хэмжээнээс дотоодын нийт бүтээгдэхүүний дөрвөн хувиар нэмж буурсан тохиолдолд үнэ болон биет хэмжээ төлөвлөснөөс буурсан гол нэр төрлийн эрдэс баялгийн Төсвийн тогтворжуулалтын санд өмнө хуримтлагдсан хөрөнгөөс зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг;

16.3.2.төсвийн гол нэр төрлийн эрдэс баялгийн зах зээлийн үнэ төсөвт туссан тэнцвэржүүлсэн үнээс буурсан болон гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын биет хэмжээ төсөвт туссан биет хэмжээнээс 20 хувиар буурсан тохиолдолд уг үнэ болон биет хэмжээ төлөвлөснөөс буурсан гол нэр төрлийн эрдэс баялгийн Төсвийн тогтворжуулалтын санд өмнө хуримтлагдсан хөрөнгөөс зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг;

16.3.3.энэ хуулийн 9.1.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас давсан хэсгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлэх.

16.4.Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэх эх үүсвэр, зарцуулалтын хэмжээг тооцох аргачлал болон уг санд эх үүсвэр төвлөрүүлэх, түүнээс зарцуулалт хийх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.5.Энэ хуулийн 16.3.1, 16.3.2-т заасан зөрүүг нөхөн зарцуулалт хийх шийдвэрийг Засгийн газар гарган хэрэгжүүлж, төсвийн гүйцэтгэлд тусгана.

16.6.Энэ хуулийн 16.3.3-т заасан зориулалтаар зарцуулалт хийх шийдвэрийг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал гаргаж,

энэ хуулийн 9.1.3-т зааснаар тухайн жилийн төсвийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусган батална.

16.7.Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө энэ хуулийн 16.3.1-д заасан төсвийн алдагдлыг бүрэн санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд уг алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаарт багтаан зээл авч болно.”

## **2/17 дугаар зүйл:**

### **“17 дугаар зүйл.Санхүүгийн хуримтлал, түүний хөрөнгө оруулалт**

17.1.Энэ хуулийн 16.1-д заасан Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх ба шаардлагатай гэж үзвэл гэрээний үндсэн дээр Ирээдүйн өв сангийн тухай хуулиар байгуулагдсан корпорациар удирдуулж болно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан гэрээнд Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх удирдамж, нөхцөл, түүнтэй холбогдох зардал зэрэг асуудлыг тусгана.

17.3.Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө удирдлагын бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа дараахь шаардлагыг хангасан байна:

17.3.1.энэ хуулийн 17.4-т зааснаас бусад тохиолдолд зээл авахгүй байх;

17.3.2.зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан, гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалагдаж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй, эсхүл Монгол Улсын хуулийн этгээдтэй нэгдэл бүхий компанийн нэгдлийн оролцогчоос бусад этгээдийн гаргасан санхүүгийн хэрэгсэлд байршуулах;

17.3.3.зээлжих зэрэглэл тогтоодог нэр хүнд бүхий олон улсын байгууллагаас тогтоосон зээлжих зэрэглэлийн үнэлгээгээр “А” болон түүнээс доош үнэлгээтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахгүй байх;

17.3.4.санхүүгийн хөрөнгө оруулалт хөрвөх чадвартай байх;

17.3.5.Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийг барьцаалах, зээл олгох, зээлийн баталгаа, батлан даалт гаргах болон бусад хэлбэрээр Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгөөр бусдын үүргийн гүйцэтгэлийг хангах гэрээ хэлцэл байгуулахгүй байх;





17.3.6.санхүүгийн хөшүүрэг оролцсон гэрээ, хэлцэл хийхгүй байх;

17.3.7.санхүүгийн үүсмэл хэрэгслийг зөвхөн хөрөнгө оруулалтын эрсдэлийг хаах, бууруулах зорилгоор ашиглах.

17.4.Хөрөнгө оруулах шийдвэрийг гаргах үед зээл авах нөхцөл, шаардлага үүсээгүй, зөвхөн Сангаас хөрөнгө оруулахаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, тухайн хэрэгсэлд хөрөнгө оруулах төлбөр тооцоог гүйцэтгэхэд дутагдаж байгаа богино хугацааны эх үүсвэрийн дутагдлыг бүрдүүлэх зорилгоор зээл авч болно.

17.5.Энэ хуулийн 17.4-т зааснаар зээл авахад дараахь нөхцөлийг нэгэн зэрэг хангасан байна:

17.5.1.зээлийн хугацаа долоо хоног хүртэл байх;

17.5.2.зээлийн хэмжээ нь сангийн мөнгөн хөрөнгө, зээл төлөгдөх хугацааны дотор орохоор хүлээгдэж байгаа хөрөнгө оруулалтын мөнгөн орлогоор баталгаажсан, түүнээс хэтрээгүй байх;

17.5.3.сангийн зээлийн үлдэгдэл Сангийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 5 хувиас хэтрэхгүй байх.

17.6.Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлого болон хөрөнгийн удирдлагатай холбогдох журам, заавар, аргачлалыг энэ хуульд нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “Хүний хөгжил санд” гэснийг “Ирээдүйн өв санд” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийн 2 дугаар зүйлийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, бусад зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.12, 19.13 дахь хэсэг нэмсүгэй:

“19.12. Аймаг, сумын төв нь нийслэл /Улаанбаатар/ хотоос 550 км-ээс хол байршилтай аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, бүртгэлтэй, орон нутгийн төсөвтэй харьцдаг, гурваас доошгүй ажлын байр бий болгож /нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан/ байгаа энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.3-т заасан татварт ногдох орлогын албан татварыг 550 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлнө.

19.13. Доор дурдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчид энэ хуулийн 19.12-т заасан хөнгөлөлт үзүүлэхгүй:

19.13.1. ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах;  
19.13.2. согтууруулах ундаа худалдах, импортлох;  
19.13.3. тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;

19.13.4. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх, автобензин, дизель түлшний худалдаа эрхлэх, импортлох;

19.13.5. ярианы үйлчилгээ эрхлэх;  
19.13.6. эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, түгээх;

19.13.7. иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;  
19.13.8. авто зам, замын байгууламжийг барих, засварлах;  
19.13.9. цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлийн үйл ажиллагаа.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.7 дахь хэсэг нэмсүгэй:

“3.7. Сонгуулийн төв байгууллагаас Сонгуулийн тухай хуулийн 38.1-д заасан төсвийн хүрээнд сонгууль зохион байгуулахтай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2016 оны 02 дугаар 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **УРГАМАЛ, МАЛЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭРЭГСЛИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 02 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН СИСТЕМИЙГ ДЭМЖИХ ЗАМААР ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар



эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгох төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 02 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

**САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ  
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** “Санхүүгийн хамтын ажиллагааны Ерөнхий хөтөлбөрийн тухай” Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

**Захиргааны хэрэг шүүхэд хянан  
шийдвэрлэх тухай хууль батлагдсантай  
холбогдуулан авах арга хэмжээний тухай  
Улсын Их Хурлын тогтоолын төслийг  
буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи батлах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 02 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи батлах шаардлагагүй** гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг батлах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

### Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан хөтөлбөр, төлөвлөгөөг 2016 онд багтаан баталж, хэрэгжүүлэх;

2/Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ашиглалтад орсон нийтийн зориулалттай барилга байгууламжийг холбогдох стандартын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох ажлыг 2020 онд багтаан уг барилгын өмчлөгч, эзэмшигчтэй хамтран зохион байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Д.Батцогт/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг батлах саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 02 дугаар  
сарын 05-ний өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

### **“Нийгмийн халамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн халамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 81 дүгээр тогтоолын 1 дэх заалтын “Хүний хөгжил сангийн тухай хуулийг баталсантай холбогдуулан” гэснийг хассугай.

2.“Нийгмийн халамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 81 дүгээр тогтоолын 1.1 дэх дэд заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 484

Улаанбаатар  
хот

### **Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай**

Төсвийн тухай хуулийн 11.1.11, 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.3, 10.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Сангийн сайд Б.Болорт олгосугай.

2. Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагчийн үнэмлэхийн загварыг 1 дүгээр, Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагчийн тэмдэгийн загварыг 2 дугаар, Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагчийн актын загварыг 3 дугаар, Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагчийн албан шаардлагын загварыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.



3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 327 дугаар тогтоолын 7 дугаар зүйлийн “Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Сангийн сайд Ч.Улаанд олгосугай” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**САНГИЙН САЙД**

**Б.БОЛОР**

Засгийн газрын 2015 оны 484 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР**

Улсын байцаагчийн үнэмлэх хэвтээ хэлбэртэй, 2 нүүр байна. Монгол Улсын Санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагчийн үнэмлэх улаан өнгийн, улсын байцаагчийн үнэмлэх хөх өнгийн хавтастай, хавтасны гадна талд тусгайлан хийсэн санхүүгийн хяналт шалгалтын бэлгэдэлтэй байна. Бэлгэдлийн дээд талд “Санхүүгийн хяналт шалгалт”, доод талд “Улсын ерөнхий байцаагч”, “Улсын ахлах байцаагч”, “Улсын байцаагч” гэсэн үгийг алтан шармалаар бичнэ. Үнэмлэхийн суурь нь цэнхэр тэнгэрийн өнгө, үргэлжилсэн алхан хээ бүхий дэвсгэртэй байна.

Үнэмлэхийн дотор талд дор дурдсан бичиглэл байна.

**ҮНЭМЛЭХ**

Монгол улсын Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн үнэмлэх

Индекс ..... Дугаар .....

..... (аймаг, нийслэлийн)

Санхүүгийн хяналт, аудитын алба

Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч

..... Овогтой ..... нь

Монгол Улсын хууль тогтоомжид заасан төрийн санхүүгийн хяналт, шалгалтын талаарх бүрэн эрхийг эдэлж, хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан мөн. Үнэмлэхийг бусдад шилжүүлэхийг хориглоно. Үнэмлэхийг ..... оныг дуустал хугацаагаар олгов.

Монгол Улсын Санхүүгийн хяналт шалгалтын

Ерөнхий байцаагч .....





Засгийн газрын 2015 оны 484 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧИЙН ТЭМДГИЙН ЗАГВАР**

Монгол Улсын Санхүүгийн хяналт шалгалтын ерөнхий байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 40х40 мм-ийн дөрвөлжин хэлбэртэй байна. Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна. Улсын ерөнхий байцаагчийн тэмдгийн голд “МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ” гэсэн үг, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл байрлана. Тэмдгийн дөрвөн өнцөгт загасан нүд, гадна хүрээ, төв хэсгийн хүрээ алхан хээгээр хүрээлэгдэнэ.

Улсын ахлах байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35х35 мм-ийн дугуй хэлбэртэй байна. Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна. Улсын ахлах байцаагчийн тэмдгийн хүрээг дагаж “МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН”, төв хэсэгт “УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ” гэсэн үг, дээд хэсэгт санхүүгийн хяналт шалгалтын бэлгэдэл, доод талд байгууллагын индекс, улсын байцаагчийн хувийн дугаар байна.


Улсын байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35х35 мм-ийн дугуй хэлбэртэй байна. Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна. Улсын байцаагчийн тэмдгийн хүрээг дагаж “МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН”, төв хэсэгт “УЛСЫН БАЙЦААГЧ” гэсэн үг, дээд хэсэгт санхүүгийн хяналт шалгалтын бэлгэдэл, доод талд байгууллагын индекс, улсын байцаагчийн хувийн дугаар байна.

Засгийн газрын 2015 оны 484 дүгээр  
тогтоолын 3 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН АКТ  
Монгол Улсын Сангийн Яам,  
15160 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр, Д Корпус  
Утас: 26-74-68, E-mail: support@mof.gov.mn

№ \_\_\_\_\_






Засгийн газрын 2015 оны 484 дүгээр  
тогтоолын 4 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА

Монгол Улсын Сангийн Яам,  
15160 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр, Д Корпус  
Утас: 28-74-68, E-mail: support@mof.gov.mn

№ \_\_\_\_\_



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2016 оны 02 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 16.45 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Д.Сугар, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Д.Ламжав, мөн иргэн Ц.Батхолбоогийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Р.Очирбал нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 5, 35 дугаар зүйлийн 3 дахь хэсэг; Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40<sup>1</sup> дүгээр зүйлийн 40<sup>1</sup>.1 дэх хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийг, Жаран тавдугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3,



Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар хороонд оршин суугч, иргэн Д.Ламжав Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:***

“Нэгдүгээрт. Өөрчлөлт оруулах тухай энэ гурван хуулийг “баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэсэн төгсгөлийн заалтууд нь хууль хүчин төгөлдөр болох тухай Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрхийн тухай Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, шүүх нийтлэгдээгүй хуулийг хэрэглэж болохгүй тухай Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэг гэсэн Үндсэн хуулийн заалтыг илэрхий зөрчиж байна.

Хоёрдугаарт. Цэцийн тухай хуулийн “4 дүгээр зүйл. Цэцийн гишүүн” гэсэн зүйлийг өөрчлөн найруулсны 4 дэх хэсэгт “Цэцийн гишүүн Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу Цэцийн гишүүний албан тушаалаас чөлөөлөгдөх болно” гэж, “5 дугаар зүйл. Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа” гэсэн зүйлийн 4, 5 дахь заалтыг өөрчлөн найруулахдаа ийнхүү өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн нь Цэцийн гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө чөлөөлөх үндэслэл болгохоор хуульчилсан, “3 дугаар зүйл. Цэцийг байгуулах журам” гэсэн зүйлийн 1 дэх буюу мөн чанартаа Үндсэн хуулийн холбогдох заалтад Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно гэсэн хязгаарлалт тогтоосон, цаашилбал Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “40<sup>1</sup> дүгээр зүйл. Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам” гэсэн зүйлийн 40<sup>1.1</sup> дэх хэсгийг өөрчлөн найруулахдаа мөн ийнхүү өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн нь Цэцийн гишүүнийг анх илгээсэн байгууллага чөлөөлөх санал болгох үндэслэлд тооцохоор хуульчилсан явдал тус тус Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жилээр тогтоосон Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг гэсэн шууд заалтыг зөрчсөн байна.

Гуравдугаарт. ... Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн “10 дугаар зүйл. Цэцийн гишүүд зөвлөлдөх” гэсэн зүйлийн 2 дахь заалтаас “Зөвлөлдөх тасалгаанд гишүүдийн гаргасан саналыг задруулахыг хориглоно” гэснийг хасан, “Зөвлөлдөх тасалгаанд гаргасан гишүүний санал Цэцийн шийдвэрийн үндэслэл болсон бол шийдвэрийн үндэслэл хэсэгт бичигдэх бөгөөд тусгай санал гаргасан гишүүний саналыг Цэцийн шийдвэрт хавсаргана” гэж нэмсэн, “18 дугаар зүйл. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг” гэсэн зүйлийн 2 дахь заалтад “маргагч тал Цэцийн хуралдааны тэмдэглэлийг авах

эрхтэй. Маргагч тал хүсвэл Цэц хуралдааны тэмдэглэлээ цаас болон дуу, дүрс, цахим хэлбэрээр гарган өгнө” гэж нэмсэн, “28 дугаар зүйл. Цэцийн хуралдаанд маргаан хянан хэлэлцэх” гэсэн зүйлийн 5 дахь заалтад “Цэцийн гишүүний асуулт нь урьдчилсан дүгнэлтийн агуулгатай, мэтгэлцэх хэлбэртэй байж болохгүй” гэж нэмсэн, “35 дугаар зүйл. Цэцийн хуралдааны тэмдэглэл” гэсэн зүйлийн 3 дахь заалтаас “зөвлөлдөөний тэмдэглэлийг байгууллагын нууцын зэрэгт хамааруулан хадгална” гэснийг хассан явдал нь тус тус Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг зөрчсөн байна.

Иймд миний энэхүү мэдээллээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн хянан шийдвэрлэж өгөхийг хүсье. Цаашилбал, өөрчлөлт оруулах тухай эдгээр гурван хууль мэдээлэлд дурдаагүй Үндсэн хуулийн бусад зөрчлийг агуулж байгаагаас гадна, ийнхүү зөрчилтэйгөөс бусдыг харгалзах хуулиудаас хуулбарлан /хуульд өөрчлөлт оруулах журмыг зөрчин/ бичигдсэн тул энэ гурван хуулийг бүхэлд нь хүчингүй болгож өгөхийг хичээнгүйлэн хүсч байна.” гэжээ.

***Хоёр. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 14 дүгээр хороонд оршин суугч, иргэн Ц.Батхолбоо Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна. Үүнд:***

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Цэц нь хараат бус байх, Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, гишүүд эрх тэгш байх, асуудлыг шударга шийдвэрлэх, үйл ажиллагаа нь ил тод байх үндсэн зарчмыг баримтална” хэмээн заасныг “Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим” мөн хэмээн өөрчлөлт оруулжээ.

Мэдээлэл гаргагчийн хувьд “Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх”, “Төвийг сахих” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” гэсэн заалт, 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна”, 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэж байна.



Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэг бүхий Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг шийдвэрлэх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага болохын хувьд зөвхөн Үндсэн хуульд захирагдан үйл ажиллагаагаа явуулна. Харин “Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх” хэмээн заасан нь Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг шударга бусаар хязгаарлах боломжийг бий болгож байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хууль мөн, биш эсэхийг хэн хэрхэн тогтоох нь ойлгомжгүй бөгөөд агуулгын хувьд ийм зохицуулалт байх боломжгүй юм. Хожим нь Үндсэн хуулийн цэцээс хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийг хууль тогтоох байгууллагаас зүй бусаар үгүйсгэх, Үндсэн хуулийн бус аргаар Үндсэн хуулийн цэцийн хууль хэрэглэх орчинг тодорхой бус болгох боломжийг дээрх заалт олгож байна. Үндсэн хуулийн цэц нь гагцхүү Үндсэн хуулийг хэрэглэж маргааныг шийдвэрлэх учиртай. Иймд Үндсэн хуулийн цэц нь “Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна.

Үндсэн хуулийн цэц нь “Төвийг сахина” гэсэн зарчим нь шүүхийн байгууллагын үйл ажиллагааны баримтлах боломжгүй зарчим юм. Шүүх нь эрх зүйн маргаанд зөв, буруугийн дүгнэлт өгөхөөс бус нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, эсхүл олон нийтийн хүсэл сонирхолд нийцүүлэн төвийг сахих замаар Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих үүргээ биелүүлэх боломжгүй, Үндсэн хуулийн шүүх эрх зүйн маргаанд эрх зүйн дүгнэлт өгөх замаар Үндсэн хуульд ёсыг хамгаалахаас илүү өөр эрх ашиг байж болохгүй. Хууль тогтоогчийн хувьд төвийг сахих зарчмын агуулгыг хэрхэн ойлгох талаар Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд тусгайлан зохицуулаагүй хэдий ч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 5-д төвийг сахих зарчмын агуулгыг Цэцийн гишүүн татгалзах агуулгаар ойлгохоор тайлбарлажээ. Мэдээлэл гаргагчийн хувьд “төвийг сахина” гэх зарчмын агуулга нь Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах утгаас илүү өргөн хүрээтэй хэмээн ойлгож байгаа бөгөөд энэ байдал нь Үндсэн хуулийн цэцээс бүрэн эрхээ хуулийн хүрээнд шударгаар хэрэгжүүлэх боломжийг ихээхэн хязгаарлана хэмээн үзэж байна. Иймд “Төвийг сахих” гэсэн зарчмыг бэхжүүлсэн Үндсэн хуулийн цэцээс бүрэн эрхээ хуулийн хүрээнд шударгаар хэрэгжүүлэх боломжийг ихээхэн хязгаарлана хэмээн үзэж байна. Иймд “төвийг сахих” гэсэн зарчмыг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 5 дахь заалт Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилж бөгөөд Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно” хэмээн нэмэлт оруулсан байна, дээрх нэмэлт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно”, түүнчлэн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана” гэсэн заалтыг зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал Үндсэн хуулиас давсан хязгаарлалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд оруулсан хэмээн үзэж байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт Цэцийн гишүүнийг Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрснээр Цэцийн гишүүнээс чөлөөлөхөөр хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байх талаарх зохицуулалтыг зөрчсөн хэмээн үзэж байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг ийнхүү Үндсэн хуулиар зохицуулсан нь түүнийг аливаа шударга бус үндэслэлээр бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох явдлаас хамгаалсан заалт юм. Хэдийгээр Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэх хэдий ч түүний баталсан хууль тогтоомж Үндсэн хуулийн агуулгыг зөрчсөн, Үндсэн хуулийн хяналтыг үгүйсгэсэн, хязгаарласан байж хэрхэвч болохгүй ээ. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь түүнийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан нь Үндсэн хуулийн цэцийн хяналтыг хэрэгжүүлж байгаа гишүүдийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө олноор нь чөлөөлөх замаар Цэцийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг объектив байдлаар хязгаарлан, хяналт тавих боломжийг шууд үгүйсгэсэн зүй бус үйлдэл хэмээн иргэний хувьд бодож байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн хэмээн үзэж байна.

4. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл





хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно” гэсэн заалтыг “Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.” хэмээн өөрчилсөн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно ...”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана” гэсэн заалтыг зөрчсөн хэмээн үзэж байна. Хууль зөрчсөн эсэхийг эцэслэн тогтоох нь шүүхийн байгууллагын эрх хэмжээний асуудал бөгөөд хууль зөрчсөнийг эрх бүхий байгууллагаас тогтоосон гэдэгт шүүх эрх мэдлийн байгууллагаас бусад байгууллагыг хамруулах боломжтой байхаар ойлгогдож байгаа нь Үндсэн хуулийн цэцийн гишүүний хуулиар хамгаалагдсан баталгааг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Мэдээлэл гаргагч иргэний хувьд Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн заалтууд нь Үндсэн хуулийн ямар заалтыг зөрчсөн талаар мэдээлэлдээ тодорхой дурдсан тул дээрх хуулийн заалтууд Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг магадлан шалгаж, хэрэв Үндсэн хууль зөрчсөн бол хүчингүй болгож өгөхийг хүсэж байна.” гэжээ.

**Гурав. Улсын Их Хурлын дарга З.Энхболдод илгээсэн Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 3/77 дугаартай албан бичигт Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны дарга Д.Ганбат 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр “Хариу өгөх тухай” 10/1004 дугаартай албан бичгээр хариу ирүүлжээ. Үүнд:**

“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн “Мэдээлэл нэгтгэн шалгаж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай” 20 дугаартай тогтоол баталж, Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн “Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилуулах, тайлбар гаргуулах тухай” 3/41 дугаартай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлсэн.

Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу баталсан

хууль тогтоомжийн эцсийн найруулгыг нь Улсын Их Хуралд танилцуулж, ёсчилсны дараа Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээдэг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.6 дахь хэсэгт заасны дагуу тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэхээ ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэдэг.

Монгол Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээх ажил хийгдээгүй, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу дээрх хуулиудад хориг тавих эсэхээ шийдвэрлээгүй, “Төрийн мэдээлэл” эмхтгэлд нийтлээгүй байхад Үндсэн хуулийн цэц нэр бүхий иргэдийн мэдээллийн дагуу маргаан үүсгэж албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэсэн нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.”, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэгт “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ “Төрийн мэдээлэл” эмхтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.”, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.10 дахь хэсэгт “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ.” гэж тус тус заасан байдаг.

Иймд та Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн “Мэдээлэл нэгтгэн шалгаж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай” 20 дугаар тогтоолыг батлахдаа дээр дурдсан хуулиудыг зөрчсөн гэж үзэж байгаа тул Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч томилуулж, холбогдох тайлбар гаргуулан хүргүүлэх боломжгүй байна.” гэжээ.



***Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэдээлэл гаргагч, иргэн Д.Ламжав дараах нэмэлт тайлбарыг гаргасан болно. Үүнд:***

“Цэцийн бүрэн эрхтэй холбогдсон нэр бүхий гурван хуульд оруулсан өөрчлөлтийг “... баталсан өдрөөс (буюу 19-нөөс) эхлэн дагаж мөрдөнө” гэсэн төгсгөлийн заалтуудыг Үндсэн хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх боломжгүй юм. Үүнийг хууль санаачлагч, Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын дарга болон Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн олон удаагийн мэдэгдэл, ярилцлага зэргээр нэгэнт нотолсон байдаг: ойлгож болох бодитой шалтгаанаар, өөрчлөлт оруулах тухай уг гурван хуулийг нийтлэх нь байтугай, редакцийг сонсох болон ёсчлох зэрэг Улсын Их Хурлын үүрэгт хамаарах ажиллагаа 19-нд биш, нэлээд хэд хоногийн дараа хийгдсэн байна.

Ийнхүү дээрх төгсгөлийн заалтууд нь дагаж мөрдөхөөс өмнө “хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх” тухай Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийг, “Улсын дээд шүүх, бусад шүүх Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй” гэсэн Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсгийг, эцэст нь ёсчлогдсон хуулийг Ерөнхийлөгчид хүргэсний дараа, дагаж мөрдөж эхлэхээс өмнө хориг тавих хугацаа ямагт олгогдсон байх агуулгатай Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн байна.

Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт байгаа хугацааг “хуульд өөрөөр зааж болох”-ыг дээд зэргээр туйлшруулан “энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж хэрэглэснээр Үндсэн хуулийн нөгөө хоёр заалтыг ч бас зөрчихөд хүргэсэн байна. Үүний бас нэг тод баримт бол “Өршөөл үзүүлэх” тухай хуулийн төгсгөлийн заалт бөгөөд Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж “баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөх” Үндсэн хууль илэрхий зөрчсөн энэхүү заалтыг үндэслэл болгон “авлигын” хэргийг өршөөлд хамруулах гэж ихээхэн хүчин чармайлт гаргасан билээ.

Хуулийг түүний мөн чанар, онцлогт үл хамаарах байдлаар хэтэрхий урт хугацааны дараа эхлэн дагаж мөрдөхөөр заах нь нийгмийн эрх ашигт үл нийцэх, хэсэг бүлгийг талдаа татах гэсэн эрх баригчийн далд санаархал байдгийг дашрамд дурдъя.” гэжээ.

#### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болох заалт оруулсан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар



зүйлийн 3 дахь хэсэгт зөвхөн Үндсэн хуулийн цэцийн даргыг нэг удаа улируулан сонгож болохоор заасан атлаа Цэцийн гишүүнийг дахин томилогдоход хязгаарлалт тавиагүй байна. Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Цэцийн гишүүний дахин томилогдох хугацаанд хийсэн хязгаарлалт нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцийн гишүүн Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол тэтгэвэрт гарах ...” гэж заажээ. Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд Цэцийн гишүүнээр ажиллах хүний насны дээд хязгаарыг хуульчлан тогтоох нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй боловч ийнхүү хууль батлах замаар хууль батлагдахаас өмнө нэгэнт томилогдсон Цэцийн гишүүний Үндсэн хуульд заасан бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэл болгож болохгүй. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хугацаагаар нэгэнт томилогдсон Цэцийн гишүүний тухайд уг хуулийг буцааж хэрэглэвэл Үндсэн хуульд заасан Цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулах болно.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Цэцийн хуралдааны тэмдэглэлийг авах эрхтэй. Маргагч тал хүсвэл Цэц хуралдааны тэмдэглэлээ цаас болон дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон цахим хэлбэрээр гарган өгнө.” гэсэн өөрчлөлт оруулсан нь зөвлөлдөөний хуралдаанд нэгэн адил хамаарахаар байна. Мөн хуулийн 35 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Зөвлөлдөөний ... тэмдэглэлийг бүрэн гүйцэд хөтлөх үүднээс дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн техник хэрэгсэл ашиглах бөгөөд түүнийг 7 хоногоос хэтрэхгүй хугацаанд цаасан хэлбэрт буулгаж, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамт маргаан хянан шийдвэрлэсэн материалд хавсаргана.” гэсэн нэмэлт оруулж зөвлөлдөөний тэмдэглэлийг байгууллагын нууцын зэрэгт хамааруулан хадгалах заалтыг хассан байна.

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн гишүүн зөвлөлдөх тасалгаанд маргаан бүхий асуудлаар өөрийн санал, байр сууриа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх түүний хараат бус байдлын баталгаанд харшилж байна. Зөвлөлдөх тасалгаанд гишүүний илэрхийлсэн санал, хэлсэн үг байгууллагын нууцын зэрэгт хамаардаг учраас зөвлөлдөх тасалгааны нууцыг ил болгох нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гишүүдийн хараат бус байдлыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... тусгай санал гаргасан



гишүүний саналыг Цэцийн шийдвэрт хавсаргана.” гэсэн нэмэлт оруулсан нь тусгай саналтай гишүүний саналыг өөрийн хүсэлтийг нь үл харгалзан заавал нийтэлж байх үүрэгжүүлсэн шинж бүхий зохицуулалт болсон байна. Энэ нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гишүүний хараат бус байдлын баталгааг алдагдуулсан гэж үзэхээр байна.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Цэцийн гишүүн хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол түүнийг үндэслэн Цэцийн гишүүнийг эгүүлэн татахаар заасан нь хууль зөрчсөн эсэхийг зөвхөн шүүхээр тогтоосон байх зарчмыг алдагдуулж, Цэцийн гишүүний хараат бус байдлыг баталгаажуулсан Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн шинжийг агуулсан байна.

6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлд тус тус “Энэ хуулийг 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж эдгээр хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна.

Дээрх хуулиудыг батлагдсан өдрөөс нь дагаж мөрдөхөөр заасан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно.”, Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих ...”, Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.” гэж заасныг тус тус зөрчсөн шинжийг агуулжээ.

7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг; Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 40<sup>1</sup> дүгээр зүйлийн 40<sup>1</sup>.1 дэх хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр өөрчлөлт оруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно." гэсэн нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.", Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуулийн цэцесөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно." гэснийг; 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... эсхүл хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон ..." гэсэн нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ..." гэснийг тус тус зөрчсөн байна.

2. 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... тусгай санал гаргасан гишүүний саналыг Цэцийн шийдвэрт хавсаргана." гэсэн нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.", 3 дахь хэсгийн "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана." гэснийг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... Цэцийн хуралдааны тэмдэглэлийг авах эрхтэй. Маргагч тал хүсвэл Цэц хуралдааны тэмдэглэлээ цаас болон дууны, дүрсний, дуу-дүрсний



бичлэг болон цахим хэлбэрээр гарган өгнө.”, 35 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “...Хуралдааны тэмдэглэлийг бүрэн гүйцэд хөтлөх үүднээс дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн техник хэрэгсэл ашиглах бөгөөд түүнийг 7 хоногоос хэтрэхгүй хугацаанд цаасан хэлбэрт буулгаж, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамт маргаан хянан шийдвэрлэсэн материалд хавсаргана.” гэсэн нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэснийг тус тус зөрчсөн байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлд тус тус “Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж эдгээр хуулийг батлагдсан өдрөөс дагаж мөрдөхөөр заасан нь Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно.” гэснийг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавих.” гэсэн Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийг, Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.” гэснийг тус тус зөрчсөн байна.

4. 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр өөрчлөлт оруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих ...”, 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцийн гишүүн Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу Цэцийн гишүүний албан тушаалаас чөлөөлөгдөж болно.”, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “... эсхүл Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн ...”, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “... Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрснээс ...”, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно.”, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Цэц дахин

хянан үзэж ...” гэсэн нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.”, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

5. 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлээр нэмэлт, өөрчлөлт оруулсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “... Цэцийн гишүүний асуулт нь урьдчилсан дүгнэлтийн агуулгатай, мэтгэлцэх хэлбэртэй байж болохгүй.” гэсэн нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

6. 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр өөрчлөлт оруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40<sup>1</sup> дүгээр зүйлийн 40<sup>1.1</sup> дэх хэсэгт “... Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэнтэй холбогдуулж тэтгэвэрт гаргах асуудлыг анх илгээсэн байгууллага санал болгон Улсын Их Хуралд ирүүлсэн ...” гэсэн нь Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг зөрчөөгүй байна.

7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.”, 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “... эсхүл хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон ...”; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... тусгай санал гаргасан гишүүний саналыг Цэцийн шийдвэрт хавсаргана.”, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...Цэцийн хуралдааны тэмдэглэлийг авах эрхтэй. Маргагч тал хүсвэл Цэц хуралдааны тэмдэглэлээ цаас болон





дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон цахим хэлбэрээр гарган өгнө.”, 35 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “... Хуралдааны тэмдэглэлийг бүрэн гүйцэд хөтлөх үүднээс дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн техник хэрэгсэл ашиглах бөгөөд түүнийг 7 хоногоос хэтрэхгүй хугацаанд цаасан хэлбэрт буулгаж, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамт маргаан хянан шийдвэрлэсэн материалд хавсаргана.”, 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн заалтуудын үйлчлэлийг 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

8. Энэхүү дүгнэлтийн 4 дэх хэсэгт заасан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг; мөн дүгнэлтийн 6 дахь хэсэгт заасан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40<sup>1</sup> дүгээр зүйлийн 40<sup>1.1</sup> дэх хэсгийн холбогдох заалт 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдрөөс өмнө томилогдсон Цэцийн гишүүдийн тухайд буцаан хэрэглэгдэхгүй болохыг дурдсугай.

9. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**  
**ГИШҮҮД**

**Ж.АМАРСАНАА**  
**Н.ЖАНЦАН**  
**Д.СУГАР**  
**Д.НАРАНЧИМЭГ**  
**Д.ГАНЗОРИГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medecelel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 17

**Индекс: 14003**